ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2016 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН.

2016.12.20. Даланзадгад хот

Цагдаагийн газар нь 2016 оны эхний хагас жилд Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд, ХЗЯ-ны Сайд, Цагдаагийн Ерөнхий Газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргын өгсөн үүрэг, даалгавар, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтууд, Хууль зүйн сайд, аймгийн засаг дарга, ЦЕГ-ын даргын гурвалсан гэрээ, Цагдаагийн газрын даргаас ЦЕГ-ын даргатай болон Аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны явцад аймаг орон нутагт хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хуулийг дээдэлж, бие бүрэлдэхүүний сахилга, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, тэдний мэдлэг боловсрол, ажил хариуцах чадварыг сайжруулах, албаны шуурхай бэлэн байдлыг хангах, цагдаагийн ажил үйлчилгээг иргэд, байгууллагад шуурхай хүртээмжтэй хүргэх, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа.

НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС 2016 ОНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР:

Цагдаагийн байгууллагаас 2016 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Удирдах ажилтны манлайлалыг дээшлүүлж, алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах

1.1. Удирдах ажилтны манлайлалыг дээшлүүлэх чиглэлээр

2015 онд тус газрын дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг 90 хувьтайгаар дүгнүүлсэн.

Цагдаагийн газрын дарга, менежерээс ЦЕГ-ын дарга, Аймгийн Засаг даргатай 2016 оны үр дүнгийн гэрээг байгуулсан

Тасгийн дарга нараас цагдаагийн газрын даргатай алба хаагчдаас тасгийн дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үр дүнгийн гэрээг байгуулахдаа менежерүүд алба хаагчдын ажлын үр дүнтэй биечлэн танилцаж цаашид зохион байгуулах чухал шаардлагатай ажлыг үр дүнгийн гэрээнд нь нэмэлтээр тусгах асуудлыг шийдвэрлэн 2016 оны үр дүнгийн гэрээг байгуулсан

Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын дагуу тус цагдаагийн газраас 2015 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлбэл зохих 83 алба хаагч байгаа бөгөөд уг алба хаагчдын мэдүүлгийг хуулийн хугацаанд, үнэн зөв бодитой гаргуулан meduuleg.iaac.mn цахим хаягаар хүлээн авч, хяналт тавин, цаасан хэлбэрээр гаргуулж гарын үсэг зуруулан баталгаажууллаа. Мөн ХАСХОМ-ийн тайлангуудыг журмын дагуу гарган, материалыг архивын нэгж болгон хуулийн хугацаанд хүргүүлсэн ба хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаа хожимдуулсан болон гаргаж өгөөгүй алба хаагч байхгүй болно. Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах шаардлагагүй алба хаагчдын өмнөх онуудад гаргаж өгч байсан хөрөнгө орлогын мэдүүлгүүдпийг цэгцэлж жагсаалтаар ЦЕГ-т хүргүүлсэн

Албад хэлтэс тасгийн даргын үүрэг хариуцлагыг өндөржүүлж өөрсдөө үлгэрлэн манлайлах зөрчил дутагдал гаргахгүй байхад анхаарах хариуцсан алба алба хаагчидтай ганцаарчилж уулзаж тулж ажиллуулж энэ талаар танилцуулга газрын даргад хүргүүлэн тодорхой зарим асуудлыг шийдүүлж ажилласан. Хариуцсан алба, алба хаагчдаас нь зөрчил дутагдал гаргавал шат шатны дарга ахлахад нь давхар хариуцлага тооцож ажилласнаар жилийн байдлаар 10 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан нь өмнөх оныхоос 19 буюу 52.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна

Мөн цагдаагийн газрын ахлах алба хаагчдын манлайлал, хариуцлагыг өндөржүүлэх зорилготой орон тооны бус “Ахлахын зөвлөл”-ийг газрын даргын тушаалаар томилж алба хаагчдын дунд урлаг соёл, спорт уралдаан мөн сахилга хариуцлага, ар гэрийн гачигдалзэргийг хэлэлцэж газрын даргад болон газрын даргын зөвлөлд танилцуулга, санал оруулж ажлуулсан нь нэг талаар удирдах арга барилд сургах нөгөө талаар манлайлал үлгэрлэн дуйралал, сахилга хариуцлага өндөржсөн үр дүнгээ өгсөн шинэлэг ажил болж байна.

1.2.. *Алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах чиглэлээр:*

Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсээс ирүүлсэн ажлын байрны тодорхойлолтыг хүлээн авч холбогдох алба хаагч бүрд гарын үсэг зуруулан танилцуулж, ахлагч бүрэлдэхүүний хувийн хэрэгт баяжилтаар хийсэн. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан шинээр баталсан болон дутуу ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг жагсаалтыг гарган хүргүүлж нөхөж авч холбогдох алба хаагчдад танилцуулсан.

2. Байгууллагын соёл, алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах

2.1. Байгууллагын соёлыг сайжруулах чиглэлээр:

Тус газрын алба хаагчдаас байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх судалгааг 2016 оны сүүлийн хагас жилд авахаар төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Мөн тасгийн дарга, ахлах албан тушаалтнуудын харилцааны соёл, үйл ажиллагааны талаарх судалгааг авч газрын удирдлага танилцсан.

Цагдаагийн газрын цахим хаяг болон иргэдийн хүлээлгийн танхимд Газрын удирдах ажилтнуудын танилцуулга, иргэдийг хүлээн авах цагийн хуваарь, утасны дугаар, холбоо, шуудангийн ажилтны овог, нэр, хаяг, утасны дугаар зэргийг байршуулсан. Мөн цагдаагийн газраас үзүүлэх үйлчилгээ зөвшөөрлийн талаар болон ямар алба хаагч хариуцдаг тэдний албан тушаал нэр харилцах утас цахим хаяг зэргийг байршуулсан бөгөөд 2 удаа “Нээлттэй хаалганы өдөр”-ийг” зохион байгуулж иргэдэд танилцуулсан

Цагдаагийн газрын танилцуулга, үйл ажиллагааны талаар интернет орчинд цахим хаяг “Facebook” хуудас нээж байнгын ажиллагаанд оруулсан хэв журмын ахлах байцаагчаар хариуцуулан үйл ажиллагааг идэвхижүүлэн байнгын харилцаатай болсон иргэдээс санал хүсэлт шүүмжлэлийг авч 14 хоног тутам дүнг газрын удирдлагад танилцуулж хариуг өгч ажиллаж байна. Тус газрын жижүүрийн шуурхай албаны **7053-102**, **7053-3221** дугаарын суурин утас 24 цагаар дуудлага, мэдээ мэдээлэл хүлээн авч ажиллаж байгаа ба жижүүрийн өрөөнд интернэт оруулан иргэдээс өөрийн “Facebook” хаяг, вейф хуудас зэргээр цахим хэлбэрээр мэдээ мэдээлэл авах туршилтыг явуулж байна.

Аймгийн ард, иргэдийн санал хүсэлт, алба хаагч нартай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах **7053-3321** дугаарын суурин утсыг шинээр ажилд оруулан ажиллаж байгаа

2.2. Алба хаагчдын сахилга ёс зүйн чиглэлээр:

Сахилга ёс зүйн зөвлөл, Аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийг газрын даргын тушаалаар томилж хийх ажлын төлөвлөгөө гарган газрын дарга баталж сахилга хариуцлагын зөвлөгөөнийг удирдамж төлөвлөгөөний дагуу 3 удаа зохион байгуулж алба хаагчдад сонсгол тавьж хэлэлцүүлсэн.

Аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийн хурлыг 2 удаа хийж ололт дутагдал, анхаарах асуудал цаашид хийх ажлаа төлөвлөж ажилласан. Хагас бүтэн жилээр ажлын үр дүнг тооцсон

Эхний хагас жилд тус цагдаагийн газраас 1 алба хаагч захиргааны зөрчил, 1 алба хаагч гэмт хэрэгт холбогдон шалгагдсан ба гэмт хэрэгт холбогдон шалгагдсан алба хаагчийн албан тушаалыг түдгэлзүүлэх саналыг холбогдох газарт хүргүүлсэн. Захиргааны зөрчил гаргасан алба хаагчтай тус газрын сэтгэлзүйч уулзаж, ярилцлага хийж, үр дүнг газрын удирдлагад танилцуулсан. Газрын удирдлагаас өглөө бүрийн яриан дээр алба хаагч нэг бүр аюулгүй байдлаа хангаж ажиллах, харилцааны соёлтой харилцах талаар, хэлтэс тасгийн дарга нар хариуцсан алба хаагчиддаа бичгээр зааварчилгаа, зөвлөмж өгч, хяналт тавин ажиллаж байна. Мөн тус газрын сэтгэл зүйч харилцааны урлаг, амьдралын зөв хэвшил бий болгох ишлэл үгүүдийг өглөө бүрийн яриан дээр проектороор гарган ажиллаж байна.

Хамт олны дунд эерэг уур амьсгалыг бий болгох зорилгоор Монгол цэргийн өдөр, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Цагдаагийн байгууллагын 95 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажил арга хэмжээ зохион байгуулан ажилласан ба гэр бүлийн гишүүдтэй уулзалт хийж, явган аялал, салхинд гарах зугааллага зохион байгуулсан.

ЦЕГын даргын 2015 оны “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх 11 заалт бүхий төлөвлөгөө оны эхэнд шинэчлэн гарган тасаг алба хэлтсүүдэд хүргүүлэн биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан. Бие даасан хэлтэс, тасгийн алба хаагчдыг оролцуулан нийт алба хаагчдын дунд улирал бүр сахилга ёс зүйн зөвлөлгөөнийг хийж өнгөрсөн оны болон өмнөх улиралын ажлын ололт дутагдал алба хаагчдын сахилга хариуцлагын байдал, гаргасан зөрчлийн талаар хэлэлцүүлэг хийж ажил тасалж хариуцлага алдсан 4 алба хаагчдад хамт олны өмнөөс дахин зөрчил дутагдал гаргахгүй байх “Итгэл найдварын хуудас”-ыг гардуулсан нь нөлөөлийн ач холбогдолтой ажил болсон. Мөн архидан согтуурах зөрчлийг таслан зогсоох чиглэлээр алба хаагчдад анхааруулга сэрэмжлүүлэг өгч батлагаа гаргуулан авч ажилласны үр дүнд жилийн байдлаар архитай холбоотой зөрчил гараагүй таслан зогсоогдсон байна.

2.3. Албаны бэлэн байдлыг сайжруулах чиглэлээр:

-Тус Цагдаагийн газар нь 2016 онд бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдал, сахилга хариуцлага, цэрэгжилч, жагсаалч байдал, алба хаагчдын ёс зүйг төлөвшүүлэхэд анхаарч

сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан ба Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Цагдаагийн дотоод албаны дүрэм, Цагдаагийн алба хаагч биеийн хүч тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмаар тус тус нийт бие бүрэлдэхүүнд 4 удаагийн сургалт явуулж, алба хаагчдаар бие даан судлуулав. Тайлангийн хугацаанд дээрх хууль журмуудаар ахлагч бүрэлдэхүүнээс 3 удаа тестээр эрхзүйн мэдлэгийн шалгалт авч, үр дүнг тооцлоо.

Алба хаагчдын албаны бэлэн байдлыг шалгаж “Говь Ц-111” дохиогоор 7 удаа түргэн цуглралтыг зохион байгуулан

2016 онд цагдаагийн газрын ахлагч бүрэлдэхүүний цугларалт, сургалтыг 2 удаа зохион байгуулсан ба сургалтыг төлөвлөгөө удирдамжийн дагуу явуулж хууль эрх зүйн мэдлэг олгох соён гэгээрүүлэх ажил зэргийг зохион байгууллаа.

-Цагдаагийн алба хаагчдын хоорондоо албаны харьцаагаар харьцах, цэрэгжилч жагсаалч байдал, бие биендээ хүндэтгэлтэй хандаж байгаа эсэхэд газрын удирдлагууд болон ёс журам сахиулах эргүүлүүд тогтмол хяналт тавин илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд нийт 12 удаа жагсаалын үзлэг хийж хяналт тавьж ажилласан ба мөн жагсаалын бэлтгэл хийлгэж зөрчлийг тухай бүр нь арилгуулж ажиллаа.

-Алба хаагчдын дундаас үйлдэгдэж болзошгүй сахилга, ёсзүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус газрын сэтгэл зүйчтэй хамтарч нийт ахлагч бүрэлдэхүүнийг

ганцаарчлан уулзаж, зөвлөгөө өгөх, баталгаа авах, гэр бүлийн гишүүдтэй нь уулзаж ярилцах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

<u>3. Сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх</u>

Алба хаагчдаас сургалт явуулах арга хэлбэр хичээлийн сэдвийн талаар судалгаа авч түүний дагуу сургалтын төлөвлөгөө гарган цагдаагийн газрын бүх албадын ахлахуудыг сургагч багшаар даргын тушаалаар томилж мэргэшүүлэх сургалтанд хамруулсан.





Бүсийн сургалтын танхим шинээр байгуулан бүрэн засч сүүлийн үеийн хүчин чадал сайтай өндөр үзүүлэлттэй суурин компьютер 10 ш, сургалтын самбар 2 ш, тонафон чихэвч 10 ш, багтаамж сайтай плаш 2 ш зэргэг мөн алба хаагчдыг галт зэвсэг буудлага хийх сургуулилтын цахим төхөөрөмж “Скат” зэргийг байрлуулан тохижуулсан сургалтын чанар үр дүн дээшлэхэд өндөр ач холбогдолтой ажил болсон.

Мөн бялдаржуулах өрөөнд иж бүрэн тоног төхөөрөмжөөр шинэчлэсэн нь алба хаагчид чөлөө цагаа зөв боловсон өнгөрүүлж бие бялдараа хөгжүүлэх таатай нөхцөл бүрдсэн.

Мөн Цагдаагийн газрын ахлагч бүрэлдэхүүнд сургалтын шинэлэг арга хэлбэрээр явуулж Зэвсэгт хүчний 167-р ангитай хамтарч тус ангийн хээрийн сургалтын төв полигонд 3 хоног байрлуулсан жагсаалын бэлтгэл галт зэвсэгтэй харьцах сургалт болон өдөр шөнийн буудлага хийлгэж сүүлийн үеийн байлдааны зэвсэг техниктэй танилцах зэрэг бусад сургалтыг явуулсан нь шинэлэг ажил болсон.

Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, х/ч С.Төрмөнх БНТУлсад зохиогдсон “ Хар тамхитай тэмцэх чиглэл”-ийн 14 хоногийн сургалтанд хамрагдсан. Мөн эрүүгийн төлөөлөгч а/х Ц.Эрдэнэбаатар Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцохоор нэгдсэн сургалтанд хамрагдаж нөөцөнд орсон

ХОЁР: ЦАГДААГИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНГИЙН ТАЛААР:

2.1. Цагдаагийн ерөнхий газрын 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн б/279 тоот тушаалаар тус цагдаагийн газрын бүтэц орон тоог Төлөвлөлт зохион байгуулалтын тасаг, Эрүүгийн цагдаагийн тасаг, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасаг, Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс, Ханбогд сум дахь Цагдаагийн тасаг, Гурвантэс сум дахь Цагдаагийн тасаг гэсэн бүтэцтэй нийт 87 офицер, 62 ахлагч, үйлчилгээний энгийн 2, гэрээт цагдаа 4 нийт 155 алба хаагчтайгаар баталсан ба одоогийн байдлаар офицерын орон тоо бүрэн, 8 ахлагчийн орон тоо дутуу, нийт 87 офицер, 58 ахлагч, 2 энгийн ажилтан, нийт 147 алба

хаагчийн, 20 Олон нийтийн цагдаагийн ажилтан бүрэлдэхүүнтэйгээр, ажил үүргээ гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд тус цагдаагийн газарт 26 алба хаагч албан тушаал томилогдсон ба төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д зааснаар 1 алба хаагч, мэргэшлийн шалгалтад тэнцэж 10 алба хаагч, нөөцөөс 2, туршилтаар 1, захиргааны санаачилгаар 2, Тахарын ерөнхий газар татан буугдсанаар 10 алба хаагч шилжин ирж ажилласан бөгөөд 1 алба хаагч хэлтсийн даргаар, ахлах албан тушаалд 3, цагдаагаас офицер бүрэлдэхүүнд 3 алба хаагч тус тус дэвшин томилогдсон байна.

2016 оны 1 сард газрын даргын зөвлөлийн хурлаар удирдах ажилтны нөөцөд авхуулах алба хаагчдыг хэлэлцэн нийт газар хэлтсийн даргын нөөцөд 2 алба хаагч, тасгийн даргын нөөцөд 6 алба хаагч, ахлах офицерийн нөөцөд 6 алба хаагч, офицерийн бүрэлдэхүүнд оруулахаар нөөцанд 4 алба хаагчийн материал саналыг холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэн нөөцөд авхуулсан.

Эхний хагас жилийн байдлаар 4 тасаг, хэсгийн дарга, 7 ахлах байцаагч ЦЕГ-аас зохион байгуулсан удирдахуйн сургалтуудад хамрагдсан

Цагдаагийн байгууллагад анх орох иргэний сонгон шалгаруулалтын зарыг орон нутгийн “Алтанговь”, “Вест” телевизийн зарын эфирээр түгээлгэж, тус газрын facebook хаягт байршуулан ажилласан ба нийт 38 иргэн хүсэлт гарган бүртгүүлсэнээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд зааны дагуу шаардлага хангасан 14 иргэдийг сонгон шалгаруулалтад оролцуулсан. Мөн шинээр томилогдон ирсэн алба хаагч бүртэй тогтвортой ажиллах гэрээ байгуулсан.

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар 2016 онд сар бүр 7, улирал бүр 7, хагас жилд 1, бүтэн жилээр оны эцэст 9 асуудал хэлэлцэх жагсаалтын төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулсан Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлыг батлагдсан төлөвлөгөөт 14, ээлжит бус 3 удаа хийсэн.

Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн болон туслах тоо бүртгэлийн зааврын хэрэгжилт, торгуулийн тасалбар, шийтгэвэрийн хуудасны тооцоо, эрүүлжүүлэх баривчлах байрны тооцоо, танилцуулга, гэмт хэрэг илрүүлэх талаар хийсэн ажлын сонсгол зэргийг сар бүр хэлэлцэхээс гадна алба хаагчдын ажлын үр дүнг сар бүр цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч ажил үүргээ хангалттай биелүүлсэн, байгууллагаас зохион байгуулагдаж байгаа ажил, арга хэмжээнд идэвхитэй оролцсон давхардсан тоогоор 398 алба хаагчийн сарын үндсэн цалинг 5-20 хувь нэмж, ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, өгсөн үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн 183 алба хаагчийн сарын үндсэн цалинг 5-20 хувь бууруулан ажилласан. Мөн Олон нийтийн цагдаагийн ажилтны ажлыг дүгнэж давхартсан тоогоор 119 алба хаагчийн цалинг 5-20% нэмж, 5 ажилтны цалинг 5-20% бууруулсан байна.

Цагдаагийн газрын даргын тушаалыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 99 дүгээр тушаалаар батлагдсан ЦБҮАЖурам /код 136/ журмын дагуу төлөвлөн, тушаалын төслийг тасаг албадын дарга нарт танилцуулан шаардлагатай гэж үзвэл нэмэлт саналыг тусган, хууль эрхзүйн актад бүрэн нийцүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд газрын даргын 129 тушаал гаргасан ба үүнд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 45, хүний нөөцтэй холбоотой 84 тушаал гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн дээд газраас ирүүлсэн тушаал, журмын төслийг алба хаагчдаар хэлэлцүүлэн, тэмдэглэлийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Мөн шалгагдаж байгаа хэрэгт бичсэн албаны даргын даалгавар, зааварчилгаа, ахлахуудаас гаргасан зааварчилгаа зэрэгт шат шатны дарга нарын хяналтыг тавиулж биелэлт үр дүнг тооцож ажилласан.

Аймгийн нийгэм эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд /Гэрч хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх түр байрны 5.0 сая, Цагдаагийн газрын төв байрны урсгал засварт 80.0 сая, "Ногоон гэрэл цагаан шугам", "Автомашингүй өдөр", "Иргэн ба хууль" цогцолбор арга хэмжээг зохион байгуулахад 10.0 сая, Олон нийтийн цагдааг Даланзадгад, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс Цогт-Овоо сумдад ажиллуулах, тэдэнд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх 156.0 сая, "Архигүй Өмнөговь" хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх 30.0 сая, Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах түр байрыг бий болгох 50.0 сая, Улаанбаатар чиглэлийн хатуу хучилттай замд Замын цагдаагийн пост байгуулах 160.0 сая төгрөг/-ийн 7 ажил арга хэмжээг тусгуулсан үүнээс төсөв санхүүгийн хүндрэлээс Улаанбаатар чиглэлийн хатуу хучилттай замд Замын цагдаагийн пост байгуулах 160.0 сая төгрөг/-ийн ажил арга хэмжээ хийгдээгүй тасалдсан 91.4 хувьтай биелэгдсэн.

2017 оны Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 7 ажил, арга хэмжээний 547.700.000 төгрөгний санхүүжилтийг шийдүүлэн суутгуулсан

Мөн аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдал ажлын ачаалал хийж буй ажил цаашид хийх ажлын талаар шаардлагатай орно тоо зэрэг зурган видео танилцуулгыг бэлтгэн газрын дарга ЦЕГ-ын зөвлөлийн хуралд танилцуулснаар Тавантолгойн нүүрсний бүлэг ордоос нүүрс тээвэрлэлтийг замын нөхцөл байдал хүндэрч Ханбогд сумын Хайрхан баг “Цагаан хад” гэх автомашин, болон хүн ам олноор сууршиж бөөгнөрөл үүсч байгаа газар 30 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй Гэрээт цагдаагийн тасаг байгуулах шийдвэрийг гаргуулсан.

Гадаад харилцааг хөгжүүлж БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах газартай хамтарч ажилласны үр дүнд хандив тусламжаар тусгай тоноглолтой 1 авто машин, 2 мотоцикель ирүүлснийг аймгийн засагт даргад танилцуулан хүсэлт тавьснаар гаалийн татвар болох 9.000.000 төгрөгийг шийдүүлэн авто машин, мотоцикелийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2016 онд:

-Цагдаагийн газрын төв байранд 96.000.000 төгрөгөөр бүрэн засвар үүнд барилгын дээврийг бүрэн сольж засуулсан, гаднга пассадны шавар өнгөлгөө хийлгэн будуулсан, 1-3 давхарын коридор шат, үүдний иргэдийн хүлээлгийн танхимд шинэчилж бүрэн засвар, 6 өрөө

тасалгааг бүрэн засч барилгын цахилгааны засвар гэрэлтүүлэг монтаж зэргийг бүрэн солиулж урсгал засвар хийлгэсэн.

Засвар хийхээс өмнө

Засвар хийсний дараа

Цагдаагийн газрын үүдний коридор

өмнө нь

засвар хийсэн дараа

Цагдаагийн газрын зөвлөлийн өрөө

өмнө нь

засвар хийсэн дараа

Цагдаагийн газрын 1 давхарын коридор

өмнө нь



засвар хийсэн дараа

-Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд болон тэдний бага насны хүүхдийг хамгаалах түр байрыг 50.000.000 төгрөгний санхүүжилтээр бий болгон тохижуулж, тухайн үед аймгийн тахарын албанд хүлээлгэн өгсөн байсан одоо Цагдаагийн газар ашиглаж байна.

-2016 оны 04-р сарын сүүлээр зүүн сумдууд болох Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Манлай зэрэг сумдын иргэдэд сургалт хийх, байгаль орчины эсрэг гэмт хэргийн талаарх сумдын ГХУСАЗСЗ-ийн ажлыг шалгаж, зааварчлах, уул уурхайн компанийн үйл ажиллагаатай танилцаж, шалган заарчилах, хилийн боомтын нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцаж, улсын хилээр хууль бусаар эд зүйл ялангуяа алт, чулуу гаргахгүй байх талаар хамтран ажиллах төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлыг зохион байгуулсан. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 10-р сарын 08-ны өдрийн 136 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн нутаг дэсвгэрт металл хайгч ашиглахыг хориглох шийдвэрийг хууль тогтоомж зөрчсөн гэж улсын дээд шүүхээс үзсэн тул түдгэлзүүлээд байна. Мөн байгаль орчны эсрэг гэмт хэрэг, хууль бус агнуур худалдааны талаар мэдээлэл авах шуурхай утас 97177000 дугаар, аймгийн цагдаагийн газрын иргэдээ сонсох утас 70533321 дугаарыг сурталчилсан наалтыг тус бүр 500 ширхэг хэвлүүлэн олшруулж сумдад хүргүүлсэн цагдаагийн газар хамтран ашиглаж байна.

Тайлангийн хугацаанд удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт, хугацаатай албан бичиг, тайлан, мэдээ, судалгааг заасан хугацаанд гаргаж холбогдох газруудад хүргүүлэн ажилласан болно.

Орон нутгийн гэмт хэрэг, эрхзүйн зөрчлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг 14 хоног тутамд ЦЕГ-ын даргад, сар бүрийн эцэст аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Хуульзүйн хэлтсийн дарга нарт хүргүүлэн ажиллалаа.

Цагдаагийн газрын даргад алба хаагчдаас хандаж гаргасан 86 өргөдөл санал байгаа бөгөөд хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна. Өргөдөл саналыг өнгөөр харуулбал ажилд орох, суралцахыг хүссэн 30, ажилд дахин орохыг хүссэн 8, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 6, захиргааны чөлөө хүссэн 25, тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн 5, бусад 12 өргөдөл, саналыг хүлээн авч шийдвэрлэлээ.

Тайлант хугацаанд иргэд байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн 14 гомдол, мэдээллийн шалтгаан нөхцлийг тодруулж ажилласан ба өнгөөр харуулбал хууль ёс, хүний эрх, эрхчөлөө зөрчсөн 1, бусдыг чирэгдүүлсэн 6, цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл ёс зүй зөрчсөн 3, бусдын эрх чөлөөнд халдсан 2, архидан согтуурсан 1, ЭБШХ болон бусад хууль тогтоомж зөрчсөн 1 байсан ба албаны шалгалт явуулахад 3 алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдсон тул сахилгын арга хэмжээ ногдуулж, 11 мэдээлэл нотлогдоогүй ба гомдол, санал гаргасан иргэн бүрт шийдвэрлэлтийн хариуг өгч ажиллалаа.

Өмнөх онд Олон нийтийн цагдаа 24 урамшуулал нь 98 сая төгрөг байсныг эхний хагас жилд Даланзадгад сумын 8 баг болон Ханбогд, Гурвантэс, Цогтцэций зэрэг хүн ам ихээр төвлөрөх болсон сумдад нийт 30 олон нийтийн цагдаагийн ажилтан байхаар, урамшууллыг 156 сая төгрөгөөр батлуулсан бөгөөд дутуу орон тоон дээр нэмж 4 хүнийг сургалтанд хамруулан материалыг НХЖХАлбанд хүргүүлсэн. Одоо ажиллаж байгаа Олон нийтийн цагдаа нарыг багуудад хуваарилан хэсгийн байцаагч, төлөөлөгч нар өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Алба хаагчдтай орон сууц болон хэрэглээний хөнгөлттэй зээлийн талаар Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа банкуудаас уулзалт ярилцлаг хийлгэсэн байнгын харьцаатай гэрээт “Хаан” банктай хамтарч хөнгөлттэй хувийн орон сууц хашаа байшин барих зээлд 3 албан хаагч хамрагдсан, Цагдаагийн газраас аймгийн төвд 1 алба хаагч Улаанбаатар хотод 1 алба хаагч хөнгөлттэй зээлээр орон сууцанд орсон. Мөн алба хаагчдад болон ахмад ажилтнуудад өвөлжилтийн бэлтгэл ажилд тусламж үзүүлэн зорилгоор орон нйтгийн өмчит “Тавантолгой” ХК-тай 520 тонн нүүрсний худалдан авах гэрээ байгуулан уурхайн үнээр буюу тонныг нь 8.000 төгрөгөөр уурхайгаас татан авч 2-5 тонн нүүрс олгож тусламж үзүүлсэн.

Алба хаагчдын дунд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч И.Золбообаатар 1 удаа зохион байгуулсан бөгөөд алба хаагчдыг цахим хаяганд өөрийн албаны дүрэмт хувцастай болон гэр бүлийн гишүүдийн талаарх зураг, бичлэг тавихгүй байх, цахимаар үзэл бодлоо илэрхийлэхгүй байх талаар чиглэл өгсөн. Цагдаагийн газрын албаны хэрэгцээнд ашиглаж байгаа компъютерийг нууц кодтой болгох ажлыг зохион байгуулж, дууссан ба холбооны инженер цагдаагийн ахлах дэслэгч С.Батцэнгэлээр нийт алба хаагчидад Microsoft Lync-2010 мессенжер, Outlook программ, сүлжээний аюулгүй байдал, компъютерийн зөв хэрэглээний талаар нийт алба хаагчидад 2 цагийн сургалт орсон байна.

Цагдаагийн байгууллагын болон ЭЦГ-ын дотоод сүлжээ холбогдсон албаны компьютерт аюулгүй байдлыг хангаж ажиллах талаас нь интернэт холболтыг салгуулсан байна. Өмнөговь цагдаагийн газар цахим хаягаар дамжуулан хүүхэд, залуучуудад хар, тамхи мансууруулах бодисоос сэрэмжлүүлэх мэдээ, мэдээлэл, богино хэмжээний шторкыг хүргэсэн. Өмнөговь Цагдаагийн газар цахим хаяган дээр **“Шинэ үеийн сонголт лав эдгээр биш”** нэртэй нээлттэй бүлгэм үүсгэн хар тамхи, мансууруулах бодис, архи, тамхины хэрэглээ, хорт зуршлын талаар мэдээ, мэдээлэл тавин ажиллаж байна. Орон нутгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаарх мэдээллийг долоо хоногт хоёр удаа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгч хэвшсэн бөгөөд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд мэдээ, мэдээлэл өгөх алба хаагчаар олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч А.Төмөрмөнхийг томилон ажиллуулж байна.

“Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн хүрээнд салбар төлөвлөгөө гарган алба хэлтэс тасгуудад хүргүүлсэн. Цагдаагийн газрын эрүүл мэнд хариуцсан орон тооны бус ажилтан эрүүлжүүлэх баривчлах байрны дарга эмч цагдаагийн хошууч Б.Алдармаа цагдаагийн газрын алба хаагч нарыг 2016 оны эхний хагас жилд 1 удаа Бүсийн оношлогоо эмчилгээний төвтэй хамтарч нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт /зүрхний бичлэг, эхо, цусны шинжилгээ авхуулсан/ оруулж тус бүрт нь эрүүл мэндийн картыг байгууллага дээр нээж холбогдох мэдээллийг бичилт хийж эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

2.2. ЦЕГ-ын “Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах талаар 2016 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах талаар ажил зохион байгуулж биелэлтийг 92 хувьтайгаар тооцож гаргаад байна.

Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хэсгийг Цагдаагийн газрын даргын тушаалаар 2015 оны 12 дугаар сарын 14-ны өдөр шинэчилэн томилж ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг тодотгон зааварчилга зөвлөмж хүргүүлэн хийж гүйцэтгэж байгаа ажил арга хэмжээнүүдэд байгууллагын даргын зүгээс хяналт тавьж ажилласан. Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хэсэг нь Цагдаагийн газрын даргыг байлцуулан 4 удаа хуралдаж ажлын үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаах санал бодлоо солилцон хуралдаж тодорхой шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын аюулгүй байдалд учирч болох эрсдлийг тодорхойлж түүнийг сааруулах чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Байгууллагын дотоод аюулгүй байдалд учирч болох 16 эрсдлийг тодорхойлж хэрэгжүүлэх арга замын саналын хамт ЦЕГ-ын Дотоод хяналт аюулгүй байдлын газарт 2016 оны 04-дүгээр сарын 20-ны 42/705 тоот албан бичгээр хүргүүлэн танилцуулсан.

2.2.1. *Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр:*

Цагдаагийн газрын төв байрны 1 дүгээр давхрын бүх цонхонд хамгаалалт төмөр /решотик/ хийлгэсэн.

Цагдаагийн газрын гадна талд давхар бүрт 2, журмын хашаанд 2, зэвсгийн өрөө болон архивын өрөөнд тус бүр 1, иргэдийн хүлээлгийн танхимд 1 нийт 13 өдөр шөнийн дурантай камер суурьлуулж, 6 камер саатуулах байранд ажиллаж жижүүрийн өрөөнд дэлгэцээр 19 камераар хяналт тавьж байна

2.2.2. *Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр*

Жижүүрийн шуурхай албанд томилогдсон алба хаагчид Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын код 113 “Дотоод аюулгүй байдлыг хангах”, код 200, 202-д заасан “Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа”-г хангаж ажиллах, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар гомдол, мэдээллийг холбогдох журмын дагуу тэмдэглэл үйлдэн авч, хойшлуулашгүй ажиллагаа явуулах, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах ажлыг шуурхай зохион байгуулж тасаг, албад, алба хаагчдын үйл ажиллагааг уяалдуулан зохицуулж, удирдлагыг мэдээллээр хангаж, хэргийн газрын үзлэгийн бүрэлдэхүүнийг цаг алдалгүй, шуурхай цуглуулан явуулж, араас нь байнгын холбоотой байж гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг дэвтэрт бүртгэн хүлээн авч хоногийн мэдээнд тусган санд шивж, шийдвэрлэлтийг хянаж байх талаар зааварчилгааг сум дундын хэлтэс, хэсэг , нийт алба хаагч нарт өгч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын алба хаагч нарыг Бүсийн оношлогоо эмчилгээний төвтэй хамтарч нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт /зүрхний бичлэг, эхо, цусны шинжилгээ авхуулсан/ оруулж тус бүрт нь эрүүл мэндийн картыг байгууллага дээр нээж холбогдох мэдээллийг бичилт хийж эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

Алба хаагчдаас согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх баталгаа гаргуулж хяналт тавьж улмаар алба хаагчдаас сахилга, ёс зүйн гаргасан зөрчлийг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар болон хамт олны хурлаар хэлэлцэж урьдчилан сэргийлэх мэдээллийг тогтмол хүргүүлсэн. Мөн алба хаагчдын сахилга хариуцлагын чиглэлээр ирүүлсэн үүрэг даалгавар сэрэмжлүүлэгүүдийг бие бүрэлдхүүнд тухай бүрт нь хүргүүлж анхааруулга санамжуудыг тогтмол өгч ажиллаж байна.

Сахилга хариуцлагын зөвлөгөөнийг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулж алба хаагчдад сонсгол тавьж хэлэлцүүлсэн. Сахилга хариуцлагын зөвлөгөөнөөс гарсан уриалгыг алба хаагчдад хүргэх зорилгоор “Уриалгад нэгдэх, сахилга хариуцлагын зөрчил дутагдалгүй ажиллах баталгааны дэвтар алба хаагчдаар аялуулан алба хаагч нар уриалгыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.2.3. *Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр*

Алба хаагчдыг албаны компьютерүүдийг нууцлах, албанд ашиглаж байгаа компьютерүүдийн интернэтийн эх үүсвэрт холбохгүй байх зэрэг чиглэлээр зөвлөмж зааварчилга өгч хяналт тавьж ажилласан.

Албаны компьютерүүдэд вирусын праграмм суулгуулгаж холбооны инжинертэй хамтарч албаны компьютерт үзлэг шалгалтыг тогтмол явуулж бүх компьютерын дэлгэцийг цонхны эсрэг талрүү харуулах чиглэлийг алба хаагч бүрт өгч шалгаж ажилласан.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас шалгаж байгаа болон бусад хэргийн талаар мэдээллийг ЭБШХуульд зааснаар прокурорын зөвшөөрлөөр мөн газрын удирдлагын өгсөн чиглэлээс бусад байдлаар нийтэд болон хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр мэдээлэхгүй байхыг анхааруулж шат шатны дарга, ахлахууд байнгын хяналт тавьж ажиллаж байна.

2.2.4. Санхүү /төсвийн хөрөнгө/-ийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Тус Цагдаагийн газрын санхүү нь Төсвийн тухай Монгол улсын хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол улсын хууль болон бусад хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, төсөв, хөрөнгийн төлөвлөлт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, тооллого, тооцоо бодолт зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллаж ирлээ.

Алба хаагчдын торгуулийн хуудас, шийтгэврийн ашиглалтын талаар 7 хоног бүр санхүүгээр жагсаалт гаргуулан нийт бүрэлдэхүүнт танилцуулж гарсан зөрчлийг арилгуулж

ажилласан сар бүр даргын зөвлөлийн хурлаар энэ талаар ахлах нягтлан бодогчоор сонсгол тавиулж хэлэлцэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын тушаалаар удаан жил, гадуур алба, цолны мөнгө, зэрэг бусад нэмэгдэл, болон цалин нэмж хассан шийдвэрийн хэрэгжилтэнд сар бүр хяналт тавьж тушаалын төслийг албадлын бүх дарга нарт танилцуулж гарын үсэг зуруулж саналыг авсан дараа газрын даргад танилцуулж хэвшсэн.

2.2.5. Галт зэвсэг, тусгай хэрэгслийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Галт зэвсэг, тусгай хэрэгслийг бүртгэх олгох, хэрэглэх, хадгалахад хяналт тавих журам, галт зэвсэг тусгай хэрэгсэл хэрэглэх журмуудын биелэлтэнд хяналт тавьж ажиллаж хэвсэн ба цагдаагийн газрын галт зэвсгийн байранд сар бүр 1 удаа, өдөр тутамд цагдаагийн газрын ёс журам сахиулах эргүүлүүд хяналт тавьж, хэсгийн төлөөлөгч нарын гар дээр байгаа галт зэвсгүүдийг сар бүрийн цугларалтанд ирэх үед бүртгэж тоолж аюулгүй ажиллагааны зааварчилга өгч ажилласан.

Цагдаагийн газрын зэвсэгийн байранд дохиоллын систем байрлуулан зэвсгийг хариуцсан алба хаагч /Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга/-аас өөр алба хаагчыг уг өрөөнд нэвтрүүлдэггүй.

Цагдаагийн газрын даргын томилсон ажлын хэсэг Цагдаагийн газрын зэвсэгт хагас бүтэн жилээр тоолон дүнг ЦГ-н даргад танилцуулан ажилласан

2.3. Алба хаагчдын сахилга, ажлын хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

ЦЕГын даргын 2015 оны “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх 11 заалт бүхий төлөвлөгөө оны эхэнд шинэчлэн гарган тасал алба хэлтсүүдэд хүргүүлэн биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан. Бие даасан хэлтэс, тасгийн алба хаагчдыг оролцуулан нийт алба хаагчдын дунд улирал бүр сахилга ёс зүйн зөвлөлгөөнийг хийж өнгөрсөн оны болон улиралын ажлын ололт дутагдал алба хаагчдын сахилга хариуцлагын байдал, гаргасан зөрчлийн талаар хэлэлцүүлэг хийж ажил тасалж хариуцлага алдсан 4 алба хаагчдад хамт олны өмнөөс дахин зөрчил дутагдал гаргахгүй байх “Итгэл найдварын хуудас”-ыг гардуулсан нь нөлөөлийн ач холбогдолтой ажил болсон. Мөн архидан согтуурах зөрчлийг таслан зогсоох чиглэлээр алба хаагчдад анхааруулга сэрэмжлүүлэг өгч батлагаа гаргуулан авч ажилласны үр дүнд эхний хагас жилийн байдлаар архитай холбоотой зөрчил гараагүй таслан зогсоогдсон байна.

Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдал, хяналт шалгалт тавих ажлын даргаар ахлуулсан тушаалаар томилж ажиллах төлөвлөгөө гаргуулан үр дүнг тооцож эхний хагас жилийн байдлаар Цагдаагийн газрын даргын нэрэмжит шалгалтын төлөвлөгөө удирдамж гарган тасаг албадын дарга нараар хийлгэж үр дүнг тооцож зөвлөлийн хурлаар хэлэлцэж нийт 3 удаа газрын дарга зааварчилгаа өгч биелэлтийг тооцсон. Өдөр бүр тасаг албадын дарга ахлахуудаас хувиар гарган ёс журмын эргүүлээр ажиллуулж үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын цаг ашиглалт, үйл ажиллагаа зэрэгт хяналт тавиулж илэрсэн зөрчлийг аргилгуулж өглөө бүр танилцуулгаар газрын дарга танилцаж хэвшсэн. Нийт бие бүрэлдэхүүн сахилга хариуцлагатай байх зөрчил дутагдал гаргахгүй байх талаар байнга үүрэг чиглэл өгч хэрэг алба хаагч хариуцлага алдаж зөрчил дутагдал гаргавал шат шатны дарга ахлахуудад давхар хариуцлага тооцож байна.

Мөн дээрх хууль журмын талаарх мэдлэгийг ёс журам сахиулах эргүүлүүд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас амаар шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллаж байна. “Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээний стандарт”-уудыг албаны сургалтын төлөвлөгөөнд тусган

сургалт зохион байгуулан үр дүнг тооцож ажиллалаа. Мөн стандартын хэрэгжилтэнд газрын удирдлагууд болон ёс журам сахиулах эргүүлүүд тогтмол хяналт тавин илэрсэн зөрчлийг тухай бүр нь арилгуулах, алба хаагчдын стандартын мэдлэгийг амаар шалгах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллаа.

-Цагдаагийн алба хаагчдын хоорондоо албаны харьцаагаар харьцах, цэрэгжилч жагсаалч байдал, бие биендээ хүндэтгэлтэй хандаж байгаа эсэхэд газрын удирдлагууд болон ёс журам сахиулах эргүүлүүд тогтмол хяналт тавин илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллаж байна. Алба хаагчдын дунд нутгархах, албан тушаалын төлөө дайсагналцах зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажилласнаар дээрх асуудал гараагүй байна. 2016 онд нийт 6 удаа бэлэн байдлыг “Говь Ц-111” командаар түргэн цугларалтаар шалгаж, жагсаалын үзлэг хийж хяналт тавьж ажилласан ба мөн жагсаалын бэлтгэл хийлгэж зөрчлийг тухай бүр нь арилгуулж ажиллаа.

-Алба хаагчдын дундаас үйлдэгдэж болзошгүй сахилга, ёсзүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус газрын сэтгэл зүйчтэй хамтарч нийт ахлагч бүрэлдэхүүнийг ганцаарчлан уулзаж, зөвлөгөө өгөх, баталгаа авах, гэр бүлийн гишүүдтэй нь уулзаж ярилцах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд хуучин арга барилаа өөрчилж өөр арга барилаар ажиллахаар санал бодлоо солилцон тасгийн хурлыг зохион байгуулж алба хаагчдыг офицер, цагдаа, олон нийтийн цагдаа гэсэн бүрэлдэхүүнтэй багийн зохион байгуулалтанд оруулж ажиллахаар тохиролцон ажиллаж байгаа ба хариуцсан офицерууд тэдний гэр бүлээр орж ар гэрийхэнтэй уулзан санал хүсэлтийг нь хүлээн авч үйл ажиллагаандаа анхаарч ажиллаж байна.

Алба хаагчдаас гаргасан зөрчлийг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар болон хамт олны хурлаар хэлэлцэж урьдчилан сэргийлэх мэдээллийг тогтмол хүргүүлсэн. Мөн алба хаагчдын сахилга хариуцлагын чиглэлээр ирүүлсэн үүрэг даалгавар сэрэмжлүүлэгүүдийг бие бүрэлдхүүнд тухай бүрт нь хүргүүлж анхааруулга санамжуудыг тогтмол өгч ажиллаж байна.

Нийт 3 удаагийн албаны шалгалтыг тасгийн даргаас дээш албан тушаалтнаар явуулж дүнг зөвлөлийн хурлаар хэлэлцэж 10 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Дээрх албаны шалгалтуудын талаарх мэдээг сар бүрийн эцэст ЦЕГ-ын Дотоод хяналт шалгалт аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Дээрх үйл ажиллагаанд газрын удирдлагуудаас байнгын хяналт тавин ажиллаж байгаа болно.

Сахилга хариуцлагын зөвлөгөөнийг удирдамж төлөвлөгөөний дагуу улирал бүр зохион байгуулж алба хаагчдад сонсгол тавьж хэлэлцүүлсэн

Иргэний зөвлөлд цагдаагийн газрын 2015 оны сахилга хариуцлагын зөрчлийн мэдээний сонсголыг тавьж өмнөх оныхоос зөрчил гаргаж арга хэмжээ авагдсан алба хаагчдын тоо буурсан “Сайн” үзүүлэлтэй дүгнэгдсэн.

2.4. <u>Албаны сургалтын талаар:</u> Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар нь 2016 оны эхний хагас жилд Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтыг хангах, Цагдаагийн байгууллагаас эрхзүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2016 оны эхний хагас жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, тус газраас алба хаагчдын ажлын байранд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө боловсруулан, цагдаагийн газрын даргын тушаалаар төрөл мэргэжлийн албадын ахлах албан тушаалтнуудыг сургагч багшаар томилон, тушаалыг хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хүргүүлэн ажилласан ба сургагч багш нарыг календарчилсан төлөвлөгөөний дагуу сургалт явуулах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд тус газрын төвд ажиллаж буй бие бүрэлдэхүүнд “Хууль тогтоомжийн тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, “мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, үнэлэн шижлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарьлах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”, “Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагчид зориулсан зөвлөмж”, “Цагдаагийн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх журам”, “Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам”, “Гааль татварын ерөнхий газрын эрхзүйн байдлын тухай хууль”, “Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа”, “Алба хаагчийн аюулгүй байдал”, “Цагдаагийн алба хаагчийн галт зэвсэгтэй харьцах ажиллагаа”, “Гэмт хэрэг захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэх хойшлуулашгүй ажиллагаа”, “Эрэн сурвалжлах ASAP сан”, “Санхүүгийн аюулгүй байдал”, “Хн амын орлогын албан татвар”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”, “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх нь”, “Гэр бүлийн харилцаа”, “Гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлөх хүчин зүйл” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулан ажиллалаа.

Нийтийн хэв журам хамгаалах тасаг нь дотооддоо “Гэр бүлийн зөрчилдөөн, түүнийг шийдвэрлэх арга зам”, “Галт зэвсэг хадаглах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох журам”, “Сонгуулийн тухай хууль”, “Санал авах байр хамгаалах”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй цагдаагийн ажилтны гүйцэтгэх үүрэг, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил”, “Эрэн сурвалжлах ASAP сангийн ойлголт, ашиглалт”, “Захиргааны хяналтанд байгаа хүнтэй ажиллах аргазүй”, “Гэмт хэрэг захиргааны зөрчлийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах”, “Хэргийн газрын хамгаалалтад анхаарах асуудал”, “АКМ ПМ буугаар буудлага хийх, дадлага, сургуулилт”, “Жолоочийн 10 онооны тухай ойлголт”, “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”, “Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн иргэнийг хяналтандаа байлгах”, “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, мөн ахмад ажилтан цагдаагийн бэлтгэл хошууч Н.Цогт-Очиртой уулзалт зохион байгуулан ажилласан байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг нь дотооддоо “Түдгэлзүүлсэн, хугацаа сунгасан, удааширсан хэргийг шийдвэрлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид авах арга хэмжээ”, “Хэргийн газрын хамгаалалт авахад анхаарах асуудал”, “Хууль тогтоомжийн тухай хууль”, “Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл”, “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалтыг хэрэглэхэд анхаарах асуудал”, “Шүүхэд төрийг төлөөлөх хяналтын ажил, цаашид анхаарах асуудал”, “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, үнэлэн шижлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарьлах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”, “Хэргийн газрын үзлэг, анхаарах асуудал”, “Алба хаагчийн ажлыг үнэлэх”, “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх”, “Гадаадын байгууллага иргэнтэй харилцах журам”, “Эрэн сурвалжлах”, “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдэл, хариу авч үр дүнг тооцох”, “Залилан мэхлэх гэмт хэргийг иргэний эрхзүйн харилцаанаас ялгаж зүйлчлэх нь”, “Шүүх шинжилгээний албатай хамтран ажиллах, тулгамдаж байгаа асуудал, хүндрэл бэрхшээл”, “Улсын их хурлын ээлжит сонгууль болохтой холбогдсон цаг үеийн сургалт”, “Эрүүгийн хэргийг шилжүүлэх, хүлээн авах журам” сэдвүүдээр ахлах албан тушаалтнууд болон аймгийн шүүх, прокурор, шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтран тус тус сургалт зохион байгуулан ажилласан байна.

Эрүүгийн цагдаагийн тасаг нь дотооддоо “Захиргааны хэрэг бүртгэлтэд анхаарах асуудал”, “Гэр бүлийн хүчирхийлэлд захиргааны арга хэмжээ ногдуулах”, Захиргааны хяналт тавихад анхаарах зүйл”, “Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх нь”, “Тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд хяналт тавих”, “Зам тээврийн осол, хэрэг дээр ажиллахад анхаарах асуудал”, “Хэрэг бүртгэлтийн ажиллагаанд анхаарах асуудал”, “Мөрдөн шалгах аргачлалын тухай”, “Хялбаршуулсан журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах”, “Визийн

бүртгэл”, “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”, “Цагдаагийн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх болон ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам”, “Мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд гарч буй нийтлэг алдаа”, “Алба хаагчийн албаны бэлэн байдал, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажилд хамтарсан багийн оролцоо”, “Захиргааны хяналт тогтоох” “Эрүүгийн цагдаагийн газрын мэдээллийн сүлжээнд ажиллах”, “Туслах хүчний тоо бүртгэл”, “Эрэн сурвалжлах сангийн ашиглалт” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулсан байна.

Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс нь “Албаны автомашин ашиглах, хэрэглэх”, “Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх”, “Хэргээ илчлэн ирсэн хүний мэдээллийг хүлээн авах”, “Тэсэрч дэлбэрэх химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч ажиллах”, “Гэмт хэрэг зөрчил үйлдсэн хүнийг баривчлах төрийн байгууллагад хүргэх”, “ Нэг бүрийн тусгай хэрэгсэл мэх хэрэглэх”, “Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, “Хүүхэд хүмүүжүүлэх эрэг арга ба гэр бүлийн хүчирхийлэл”, “Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай ойлголт”, “Гэмт хэрэг зөрчлийн газрыг хамгаалах”, “Илтгэх хуудас, тэмдэглэл үйлдэх”, “Хүн барьцаалсан гэмт хэргийг таслан зогсох”, “Иргэн албан тушаалтнаас тайлбар авах, гаргуулах”, “Гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авах”, “Гэмт хэрэг зөрчилд холбогдсон гадаадын иргэнтэй харилцах”, “Албадан эмчилгээнд явуулах”, “Байгууллага иргэний орон байранд нэвтрэн орох”, “Замын хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх”, “Комьпютерийн болон цахим эд мөрийн баримтыг хураан авах”, “Тусгай болон дуут гэрлэн дохио хэрэглэх”, “Ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх”, “Хэлний бэрхшээлтэй хүнд туслах”, “Гэрч хохирогчийг хамгаалах”, “Тусгай бүлгийн үйл ажиллагаа”, “Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах”, “Гүйцэтгэх ажил явуулах”, “Хялбаршуулсан хэрэг бүртгэлт явуулах”, “Зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх”, “Төрийн албан хаагч нарын талаар заавал мэдэгдэх”, “Алба хаагчийн ажлыг үнэлэх”, “Согтууруулах ундаа, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгах”, “Авто эргүүл ажиллах”, “Галт хэрэгсэл хэрэглэх тусгай хэрэгслийг бүртгэх, олгох, хадгалах, хяналт тавих”, “Олон нийтийн байцаагч, нийтийн болон урамшилтай эргүүл жижүүрийг мэргэжлийн удирдлагаар хангах”, “Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”, “Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох”, “Богино долгионы радио холбоо хэрэглэх”, “Гэмт хэрэгтэй тэмцэхэд шинжлэх ухаан техникийн ололт амжилтыг ашиглах”, “Хэт богино долгионы радио холбоо хэрэглэх”, “Шийтгэвэр, торгуулийн хуудас зэрэг тооцооны хуудсаар хангах, олгох, хадгалах” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулан ажилласан байна.

Ханбогд сум дахь цагдаагийн тасаг нь “Гадаадын иргэдийг шалгахад анхаарах асуудал, визний ангилал”, “Алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, “Гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах ажиллагаа”, “Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл”, “Алба хаагчийн ажлыг үнэлэх”, “Хүний нөөцийн аюулгүй байдал”, “Галт зэвсэг хэрэглэх”, “Галт зэвсэг тээвэрлэх”, “Галт зэвсэг хэрэглэх ашиглах олон улсын чиг хандлага”, сэдвүүдээр тус тус сургалт зохион байгуулсан бөгөөд алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх зорилгоор долоо хоног бүрийн Пүрэв гаригт спорт зааланд 2 цагийн хугацаатайгаар хичээллэж байна.

Гурвантэс сум дахь цагдаагийн тасаг нь дотооддоо “Хууль тогтоомжийн тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, “Гааль татварын ерөнхий газрын эрхзүйн байдлын тухай хууль”, “Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа”, “Цагдаагийн алба хаагчийн галт зэвсэгтэй харьцах ажиллагаа” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулан ажилласан байна.

Тайлангийн хугацаанд тус газарт зохион байгуулсан албаны сургалтад алба хаагчийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт 33 удаа, 54 цаг, давхардсан тоогоор 713 алба хаагч, мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт 48 удаа, 79 цаг, давхардсан тоогоор 940 алба хаагч, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах сургалт 45 удаа, 74 цаг, давхардсан тоогоор 1155 алба хаагч, бие бялдрын бэлтгэлжилтийн сургалт 23 удаа, 34 цаг, 828 алба хаагчийг тус тус хамруулсан ба сургагч багш болон тасгийн даргаас дээш албан тушаалтан 174 цагийн 87 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1914 алба хаагчийг хамруулан ажилласан байна.

Нийт хичээл, сургалтыг нэгтгэн дүгнэвэл 149 удаагийн 241 цагийн сургалтад давхардсан тоогоор 3636 алба хаагчийг хамруулсан байна.

2015 онд Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2012-2016 оны үндсэн чиглэлд тус цагдаагийн газарт “Бүсийн сургалтын төв” нээх санал оруулсанаар 21 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлүүлсэн ба тус цагдаагийн газарт хийгдэж буй урсгал засварын ажлын хүрээнд 1 өрөөг сургалтын зориулалтаар тохижуулж эхлээд байна.

Тайлант хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын Сургалт дадлагын төвөөс ирүүлсэн чиглэл, нэрсийн дагуу 54 алба хаагчийг мэргэшүүлэх болон давтан сургалтад, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад 4 алба хаагчийг, 1 алба хаагчийг Бүгд Найрамдах Турк улсад зохион байгуулагдсан сургалтад тус тус хамруулсан байна.

Алба хаагчдын мэдлэг, боловсролын түвшинг ахиулах чиглэлээр анхааран ажиллаж байгаа ба 4 алба хаагч ХСИС-ийн Цагдаагийн сургуулийг бакалаврын зэрэгтэй, 1 алба хаагч магистрын зэрэгтэй төгссөн ба өнөөгийн байдлаар 2 алба хаагч суралцаж байна.

Мөн Хууль сахиулахын их сургуулийн 2016-2017 оны хичээлийн жилийн элсэлттэй холбогдуулан эчнээ 3 жилийн сургалттай хөтөлбөрт 3, 5 жилийн хөтөлбөрт 6 алба хаагч суралцах хүсэлт гарган шалгалтад хамрагдаж байна.

Цаашид тус газар нь цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, төв байгууллагын баталсан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээг шинэлэг байдлаар зохион байгуулж ажиллах болно.

2.5. <u>Соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:</u> Тус цагдаагийн газар нь 2016 онд алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор бие бүрэлдэхүүний дунд уралдаан тэмцээн, соён гэгээрүүлэх ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулан ажилласан.

Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд тасаг бүр нэрэмжит сарын аяныг зохион явуулж алба хаагчдын дунд зохион байгуулах ажил, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Тухай төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Даланзадгад сумын цэргийн хүрээнээс жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг спорт, марш тактикийн тэмцээнд алба хаагчдыг бэлтгэх, хамруулах ажлыг тасаг,албадын дарга нар хариуцан зохион байгуулж ажиллаа.

Тус тэмцээний эрэгтэй гар бөмбөгийн тэмцээнд мөнгө, эмэгтэй гар бөмбөг алт, ширээний теннес эрэгтэй алт, саг эрэгтэй алт, буудлагын эрэгтэй мөнгө, эмэгтэй буудлага алтан медаль тус тус хүртэж нийлбэр дүнгээр НЭГДҮГЭЭР байранд орж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулж баг тамирчид амжилттай оролцлоо.

Тус Цагдаагийн газрын “Ахмадын зөвлөл”-ийн хуримтлалын санг бий болгох зорилготойгоор цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүн мөнгөн дэмжлэг үзүүлж, 2 сая 500 мянган төгрөгний хандив өгснийг ахмадын зөвлөл өөрсдийн хандив дээр нэмж, хуримтлал үүсгэн гар урлал, ногоо тарьж борлуулах зэргээр өсгөн нэмэгдүүлж, ахмадын зөвлөлдөө шинээр гэр авч тохижуулсан

бөгөөд хуримтлалын мөнгөөр ахмадын баяр тэмдэглэх, хөдөлмөр алдар тэмдэглэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлж байна.

Аймгийн ИТХ, Засаг дарга нарт санал хүргүүлэн шийдвэрлүүлж, цагдаагийн газрын ахмадын зөвлөлийн нэр дээр Гурвансайхан уулын Шатын аманд амралт, сувилал байгуулах зорилготой газрыг эзэмшлээр авч, шороон замыг засварласан бөгөөд Цагдаагийн байгууллагын 95 жилийн ойн арга хэмжээний хүрээнд гэр, жижиг шовгор барих зэргээр тохижуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Ахмадууд чөлөөт цагаа өнгөрөөх, гар урлал эрхлэх боломжийг олгох зорилгоор Цагдаагийн газраас ахмадын зөвлөлд өөрсдийн хэрэгцээнд ашиглаж байсан гэрийг хүлээлгэн өглөө. “Цагаан сар” болон ахмадын баярыг Цагдаагийн газраас зохион байгуулж хэвшсэн.

Ахмад ажилтан бэлтгэл хошууч Сэрээгийн Батсүхийн оролцсон тус цагдаагийн газрын түүхийг өгүүлсэн “Сэргийлэгчийн дурдатгал” баримтат нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевизээр дамжуулан иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Ахмад настангуудын “Хөдөлмөр алдар” тэмдэглэх ажлыг зохион байгуулж, 8 ахмад ажилтны хөдөлмөр алдарыг тэмдэглэн өнгөрүүлэв.

Ахмадуудад өвөлжилтийг бэлтгэл ажилд тусламж үзүүлж тус бүр 2 тонн нүүрс үнэгүй тараан олгосон.

Монгол Улсын эдийн засгийн гол тулгуур болсон мал аж ахуй маань хүндрэл, бэрхшээлтэй байгаа нөхцөлд цагдаагийн байгууллагын албаа хаагчид бид цаг зуурын энэ бэрхшээлийг даван туулахад малчин түмэндээ сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг туслалцаа үзүүлэхээр “Сайн үйлсийн нэг сарын аян”-г өрнүүлж амжилтай зохион байгуулж ажиллаа.

Өмнөговь аймгийн хэмжээнд Хүрмэн, Баяндалай, Ноён, Гурвантэс сумдууд зудтай буюу цаг муу байсан. Тиймээс тус Цагдаагийн газрын албаа хаагчид 2 хэсэг болон хуваагдан Хүрмэн, Баяндалай сумдын 15 малчиндад хандив тусламж үзүүлэн сэтгэлийн дэм өгч ажилласан байна.
Мөн 2016 оны 05-р сарын 18-ны өдөр Цагдаагийн газар нь албаа хаагчдын ар гэрийн гишүүдийг хүлээн авч “Хишиг өдөр” уулзалт, өдөрлөг зохион байгуулах арга хэмжээг зохион байгууллаа.

Арга хэмжээнд 23 албаа хаагчийн ар гэр цагдаагийн албаны дүрэмт хувцастай ирж оролцсон бөгөөд тасгийн дарга, ахлах нар ар гэрийн гишүүдийг хүлээн авч цагдаагийн газрын хурлын танхимд уулзалт ярилцлага зохин байгуулж, өөрсдийн ажлын ололт амжилт, дутагдалтай байгаа зарим асуудлын талаар харилцан ярилцаж, албаа хаагчдын ар гэрээс санал асуулгын хуудас бөглүүлж, санал, сэтгэгдлийг хүлээн авах, шийдвэрлэх зорилгоор дэвтэр аялууллаа.

Албаа хаагчдын ар гэрийнхэнд зориулсан жижиг хэмжээний хүндэтгэлийн хүлээн авалт зохион байгуулсаны дараа албаа хаагчдыг гэр бүлийн гишүүний хамтаар цагдаагийн албаа хаагчийн дүрэмт хувцастай байгаа дурсгалын зураг авах, нийт арга хэмжээнд оролцогчдын дурсгалын зургийг авах арга хэмжээг зохион байгуулсан.

Гэр бүлийн гишүүдийн эргүүлийн үүрэг гүйцэтгэх арга хэмжээний явцыг орон нутгийн UCTV телевизтэй хамтран зурагжуулж, “Хишиг өдөр” нэвтрүүлэг бэлтгэх, нэвтрүүлгийн явцад албаа хаагчдын гэр бүлийн гишүүдэд өөрсдийн ажлын онцлог, нөхцөл байдлын талаар мэдээлэл өгч, үүрэг гүйцэтгэж байгаа зарим постуудын үйл ажиллагааг газар дээр нь сонирхуулах ажлыг зохион байгуулсан бөгөөд албаа хаагчдын ар гэрийн гишүүдийн зүгээс талархал илэрхийлж, хамтран ажиллахад бэлэн байгаа тухай сэтгэгдлээ хуваалцаж байлаа.

POLICE

ГАЗАР

ГАЗАР

POLICE

Цагдаагийн газрын алба хаагчид 2016 оны 05-р сарын 01-ний өдөр Цагдаагийн газрын баруун талбайд болон зүүн талбайд 120 ширхэг мод тарьсанаас гоёлын 40 мод болох гацуур, нарс, босоо арц зэрэг моднууд 80 ширхэг улиас, хайлаас нэмж тарьж, орчноо ногоон орчин болгох зорилт тавин тасаг тус бүр талбай хариуцан авч, усалгаа, арчилгаанд анхааран ажиллаж байна.

Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлд цагдаагийн газрын засварт 96 сая төгрөг тусгуулан шийдвэрлүүлж, 2016 оны 05-р сарын 14-ний өдөр засварын ажил эхэлж, цагдаагийн газрын дээвэр, нэг, хоёр, гурван давхарын коридор, хурлын танхим, бүсийн сургалтын танхимд засвар хийж байна.

Тус газраас ирүүлсэн “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг зохион байгуулах удирдамжийн дагуу 2016 оны 05-р сарын 24-ний өдөр салбар удирдамж боловсруулан аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗЗ-ийн дарга Л.Батчулуунаар батлуулан эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах зардлын асуудлыг шийдвэрлүүлж, удирдамжийг Дорноговь, Дундговь аймгийн Цагдаагийн газарт хүргүүлсэн.

Илтгэлийг сугалааны дараалал ёсоор Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мягмаррагчаа “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн эрүүгийн эрхзүйн шинж” сэдвээр, мөн аймаг дахь цагдаагийн газрын мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч Ш.Бямбасүх “Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн хулгайн гэмт хэргийн криминологи шинж, шалтгаан нөхцөл” сэдвээр, Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч н.Өлзийсүрэн “Гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутаг дахь шилдэг туршлага” сэдвээр, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч А.Төмөрмөнх “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мэргэшсэн хамт олон ажиллуулах нь” сэдвээр тус тус илтгэл тавьж, аймгуудын төлөөлөл, оролцогчдоос илтгэлтэй холбоотойгоор асууж, тодруулах, хариулт өгөх үйл ажиллагаа зохион байгуулагдсаны дараа говийн бүсийн цагдаагийн газруудын хамтын ажиллагаа, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар зөвлөгөөн зохион байгууллаа.

Мөн эрдэм шинжилгээний хурлын талаар мэдээллийг орон нутгийн Алтанговь, UCTV телевизэд өгч, “Өмнөговь Цагдаагийн газар” цахим хуудсанд байршуулж, сурталчлах ажлыг зохион байгууллаа.

“Амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриатай зохион байгуулагдаж байгаа аймгийн Цагдаагийн газрын “Нээлттэй хаалганы өдөр”, “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөр”-ийн арга хэмжээг 2016 оны 05-р сарын 13-ны өдөр аймгийн төв талбай болох Нутгийн удирдлагын ордоны өмнөх Батмөнх Даян Сэцэн хааны нэрэмжимт талбайд зохион байгуулав. “

Цагдаагийн газрын “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээнд хүндэтгэл үзүүлж, ёслолын жагсаалд оролцохоор хурандаа Р.Жигжидсүрэн захирагчтай Зэвсэгт хүчний 167-р ангийн төлөөлөл, хурандаа н.Батхүү захирагчтай Хилийн цэргийн 131-р ангийн төлөөлөл, хурандаа н.Баярсайхан захирагчтай Онцгой байдлын хэлтсийн төлөөлөл, дэд хурандаа Н.Энхбаяр даргатай ШШГА-ын төлөөлөл, 2015 оны “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээний тэргүүн байрын шагналт Даланзадгад сумын 4-р сургуулийн “Хангарьд” баг, 2016 оны “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээний тэргүүн байрын шагналт цэцэрлэгийн баг тамирчид, Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 сургуулийн “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн сурагчид, аймгийн Хөгжимт жүжгийн театрын хамт олон, амьд хөгжмийн “Тулга” хамтлагийн хамт олон болон бусад албан байгууллагын төлөөлөл нийт 250 орчим хүн хамрагдлаа.

“Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээнд дараах үйлчилгээг Нутгийн удирдлагын ордоны нэг давхарын иргэдэд үйлчлэх танхимд зохион байгуулж, иргэдэд газар дээр нь хүргэх ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Иргэд олон нийтэд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн лавлагаа, жолоодох эрх дуусгавар болох тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг сэргээх, үйлчилгээ үзүүлэх
2. Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох ажил, арга хэмжээг зохион байгуулах
3. Цагдаагийн албанд анх орох иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт болон Хууль сахиулах их сургуулийн Цагдаагийн сургуулийн элсэлтийн журмын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл зөвлөгөө өгөх
4. Иргэд олон нийтэд хууль эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах
5. Иргэд олон нийтээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчтай холбоотой санал хүсэл өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгөх
6. “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам”-ын талаар мэдээлэл зөвлөлгөөг иргэд олон нийтэд өгөх ажлыг зохион байгуулах
7. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тараах материал, санамж сэрэмжлүүлэг бэлтгэж хүргүүлэх
8. Цагдаагийн албаны дүрэмт хувцас, тусгай хэрэгсэл, техник хэрэгслээр үзүүлэн гаргах

Цагдаагийн газрын ахмад ажилтнуудын гар урлалын бүтээл, хэрэглэж байсан эд зүйл зэргээр үзүүлэн гаргах ажлыг зохион байгуулсан бөгөөд мөн Цагдаагийн газрын хамт олны урлаг соёлын арга хэмжээ болон үйл ажиллагаанд уригдан оролцож байгаа авьяаслаг бяцхан хүүхдүүд, дуучид, хамтлагийн тоглолтууд өсвөрийн цагдаа бүлгэмийн сурагчид, олон нийтийн цагдаагийн ажилтан нарын хамтарсан үзүүлэх тоглолт, Цагдаагийн газрын алба хаагчдын үзүүлэх тоглолтуудыг бэлтгэн хүргэлээ.

Талбайд цугласан иргэд, албан байгууллагын төлөөлөл нарыг хүндэтгэн урлаг соёлын нийт 13 дугаар бэлтгэн хүргэснээс уг үйл ажиллагаанд урилгаар оролцсон амьд хөгжмийн “Тулга” хамтлаг 2 дуу, аймгийн ХЖТ-ын дуучин Э.Галмандах 2 дуу, Говийн Жонон бүжгийн тэмцээний хүрэл медальт Даланзадгад сумын 4-р цэцэрлэгийн “Монголжин” хамтлагийн авьяаслаг бүжигчин хүүхдүүд 2 бүжгээр мэндчилгээ дэвшүүлсэн бөгөөд Цагдаагийн газрын алба хаагчид 7 дуу, хөгжмийн тоглолтоор мэндчилгээ дэвшүүллээ.

Иргэд хөдөлмөрчдөд Цагдаагийн газрын сүүлийн 5 жилд хийсэн ажлын талаарх танилцуулгыг видео хэлбэрээр бэлтгэн Нутгийн удирдлагын ордоны иргэдэд үйлчлэх танхимд дэлгэцээр хүргэх, Иргэний зөвлөл, Ахмадын зөвлөл, олон нийтийн цагдаагийн ажилтны ажлын тайлан танилцуулгыг хүргэх ажлыг зохион байгуулж, иргэдээс “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд 100 хүнээс санал асуулга авч дүгнэлээ.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар нь “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний хүрээнд олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг хамруулаад 96 алба хаагч оролцож, 30 төрлийн 1930 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, тараах материал хэвлэн тарааж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 8 удаагийн сурталчилсан мэдээ, мэдээлэл өгч, 100 иргэнээс санал асуулгын хуудас бөглүүлэн авч, 17 санал, 7 хүсэлт, 1 гомдол, 29 мэдээлэл хүлээн авч, газар дээр нь шийдвэрлэсэн бөгөөд давхардсан тоогоор 1100 орчим иргэнд цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг танилцуулан сурталчилж ажиллалаа. Мөн уг арга хэмжээний талаар аймаг орон нутгийн телевизүүдтэй хамтран мэдээлэл хүргэж, зам тээврийн осол бэртэл, өвчнөөс болж шаналж байгаа иргэдэд туслах зорилгоор “Цусаа хандивлая” сайн үйлсийн аяныг санаачлан бусад байгууллага, аж ахуйн нэгжүүдийг уриалсан нь иргэдэд тааламжтай сэтгэгдэл төрүүлсэн талаар сэтгэгдлээ илэрхийлж байлаа.

Мөн Цагдаагийн газрын бүх алба бие даасан хэлтэс тасгийг хамруулсан урлагын наадмыг зохион байгуулсан.

Аймаг орон нутгийн телевизүүдтэй цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор хамтран ажиллаж, “Хишиг өдөр”, “Сэргийлэгчийн дурдатгал” “Амрыг эрье гэж мэндчилдэг авьяастнууд 2” нэвтрүүлэг, “Хаашаа яарна вэ?” цуврал нэвтрүүлэг, малын хулгай, халаасны хулгай, орон байрны хулгай, үнэт эдлэлийн хулгай, мотоциклийн хулгай, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хар тамхи мансууруулах бодис, хүний наймааны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний шторк бэлтгэн хүргэсэн.

Цаашид алба хаагчдын чөлөөт цагыг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны найрсаг нягтрал бүхий уур амьсгалтай байлгах, ажиллах амьдрах таатай орчин нөхцөлийг бий болгох зорилгоор тодорхой ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ЦЕГ-аас гаргасан өвөлжилт хүндэрсэн аймаг сумдад хандив туслалцаа үзүүлэх талаар гаргасан “**Уриалга**”-ыг дэмжиж хамт олны дунд **“Сайн үйлсийн аян”** зохион байгуулан сайн дурын үндсэн дээр болон орон нутгийн дэмжлэгтэйгээр нийт 110 боодол өвс, 18 шуудай тэжээл, хуурай сүү 10 кг, малын нэмнээ,элгэвч, хошуувч, хурганы уут зэрэг 180 ширхэг, бээлий 18 ширхэг, улаан загалмайн тусламжийн хувцас 123 ширхэг ахуйн хэрэглээнд нь гурил 20 кг, будаа 13 кг, 5 ширхэг цай, ургамалын тос 10 ширхэг, 29 толгой лаа, 100 толгой шүдэнз, 20 ширхэг саван зэргийг цуглуулж аймгийнхаа өвөлжилт хүндэрсэн 4 сумын 23 айлд хандивлан тараан өгсөн.

Хүн хүч муу 2 айлын малын хашааг засч, 4 айлын хороог цэвэрлэж, өндөр настай нэг айлд нэг машин түлш аргал түүж өгч сайн үйлсийн аяныг зохион байгуулж орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж цагдаагийн албаа суртчилсан зэрэг ажлуудыг хийсэн.

ГУРАВ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

3.1. <u>Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:</u>

2016 онд Эрүүгийн цагдаагийн тасгаас нийт 1,127.765.0-н төгрөгний хохиролтой 149 материалаар 180 хэрэг үйлдлийг эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр болон нөхөн илрүүлж ТЕГ-ын МБА, ХБМБТ-т шилжүүлсэн байна.

Шилжүүлсэн материалын 29-ийг эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байсан хэргийг нөхөн илрүүлсэн, 11-г эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 109-д эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.

Шилжүүлсэн материалуудын шийдвэрлэлтийг харуулбал



Өмнөговь аймгийн хэмжээнд 2016 оны эхний 11 сарын байдлаар нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хүлээн авсан гэмт хэргийн болон захиргааны зөрчилийн шинжтэй гомдол мэдээлэл 2866 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 926 буюу 24.4 хувиар буурсан, үүнээс гэмт

хэргийн шинжтэй өргөдөл, гомдол, мэдээлэл 944 байгаа нь 42 буюу 4.5 хувиар өссөн нийт 371 гэмт хэрэг бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 1.1 өссөн илрүүлэлт 65.5 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд байгаа эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргүүдийг илрүүлэх чиглэлээр төлөөлөгч, мөрдөн байцаагч нарыг баг болгон хувиарлаж гэмт хэрэгт хийгдвэл зохих ажиллагаануудыг хийлгэн үр дүнг тооцон ажилласан. Мөн эзэнгүй хэргийн болон эрэн сурвалжлагдаж байгаа хүн эд зүйлсийн судалгааг нэг бүрчлэн гаргаж нийт алба хаагчдад танилцуулан мэдээ мэдээлэл олох emoirs.police.gov хаягт хэрхэн нэвтэрч мэдээ мэдээлэл оруулах талаар 1 цагийн сургалт орж цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 307 хэрэгжүүлж ажиллах чиглэлээр үүрэг чиглэл өгч үр дүнг тооцон ажилласан.

2016 онд тус тасгийн төлөөлөгч нараас илрүүлсэн ноцтой хэргүүдээс дурьдвал:

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвд Ми Ми гэх мансууруулах үйлчилгээтэй байж болзошгүй нунтаг цагаан бодисыг гар дээрээс хууль бусаар худалдан борлуулсан Б, Ц, А, Э нарт холбогдох хэрэг
- 2016 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр тус аймгийн Гашуун сухайт хилийн боомтоор Т нь нүүрс тээврийн авто машинд нуугадаж Монгол улсын хилээр хууль бусаар нэвтэрсэн.
- 2016 оны 09 дугаар сарын 19-ний өдөр М нь 10.6 кг Ми Ми гэх мансууруулах үйлчилгээтэй байж болзошгүй нунтаг цагаан бодисыг Гашуун сухайт хилийн боомтоор хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан.
- Өмнөговь аймгийн Сэврэй сумын харъяат Н, Д нар нь Сэврэй сумын нутаг Нурууны ар гэх газраас хууль бусаар гар аргаар алт олборлосон иргэдээс удаа дараагийн үйлдлээр гэмт хэргийн замаар олдсон нийт 3 кг алт худалдан авсан зэрэг хэргийг илрүүлэн ажилласан.
- 2016.03.07-08-ны өдөр зохион байгуулагдсан Монгол тэмээ-999 арга хэмжээний үеэр Э нь бусадтай бүлэглэн удаа дараагийн үйлдлээр автомашин болон иргэдийн халааснаас эд зүйл хулгайлсан.
- 2016.07.02-03-нд шилжих шөнө тус аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад гэх газарт Г гадны нөлөөтэй нас барсан хэргийг Б гэгч үйлдсэн болохыг тус тус илрүүлэн ажилласан.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасгаас 2016 онд эрэн сурвалжлах ажлыг зохион явуулахдаа Монгол улсын Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гүйцэтгэх ажлын заавар, Эрэн сурвалжлах ажлын журам Код-229 болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2016 оны эхний 12 дугаар сарын 10-ний өдрийн байдлаар тус цагдаагийн газраас эрэн сурвалжлах мэдээллийн ASAP санд 5400 маягтаар алга болсон хүн 6, оргодол 8, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 21, тээврийн хэрэгсэл 7, галт зэвсэг 1, мал амьтан 2, эд зүйл 24 нийт 69 мэдээллийг шивж оруулан ТТБ-д оруулан эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж үүнээс алга болсон хүн 3, оргодол 7, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 20, тээврийн хэрэгсэл 5, галт зэвсэг 1, мал амьтан 1, эд зүйл 16-г тус тус олж тогтоон эрэн сурвалжлах журам код-229.13.1-д заасан үндэслэлээр зогсоож бусад цагдаагийн газар хэлтсээс эрэн сурвалжлагдаж байсан 8 оргодол этгээд, 2 автомашин, 1 галт зэвсэг болон бусад эд зүйлийг олж тогтоон холбогдох байгууллага албан тушаалтанд нь хүлээлгэн өгч ажилласан байна.

Эрэн сурвалжилж байгаа хүн, эд зүйлсийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор Цагдаагийн газрын үүдний зааланд байх “Эрэн сурвалжлаж байна” гэсэн самбарт эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн талаарх мэдээллийг байршуулан зарлан мэдээлж, Мөн цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд долоо хоног бүрийн мягмар гаригт эрэн сурвалжлах ASAP санд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлсийн талаарх мэдээллийг танилцуулан ажиллаж байна. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сонин сэтгүүл, телевиз радио зэрэг олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тухай бүр хамтран ажиллаж шаардлагатай эрэн сурвалжлалтын мэдээллийг зарлан мэдээлэхээс гадна “Umnugovi tsagdaagiin gazar.facebook.com” цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд зарлан мэдээлж ажиллаж байна.

2016 ОНЫ ЭХНИЙ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖЛЫН ХҮСНЭГТЭН МЭДЭЭ

Маягтны дугаар	Эрэн сурвалжлалтын төрөл	Эрэн сурвалжлалт зарласан	Эрэн сурвалжлалт зогсоосон	Үлдэгдэл

5411	Алга болсон хүн	6	3	**3**
5412	Оргодол	8	7	**1**
5412	Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд	21	20	**1**
5417	Хэн болох нь тогтоогдоогүй цогцос	-	-	**1**
5421	Галт зэвсэг, сум хэрэгсэл	1	1	**2**
5422	Бодис	-	-	**-**
5423	Тээврийн хэрэгсэл	7	5	**6**
5424	Түүх, соёлын дурсгалт болон үнэт зүйлс	-	-	**2**
5425	Мал, амьтан	2	1	**1**
5426	Эд зүйл	24	16	**41**
5427	Аман зургаар	-	-	**-**
Нийт		69	53	**58**

Тайлангийн хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Сар шинэ-2016”, “Илрүүлэлт-Оргодол”, “Тулгалт-2”, “Зэвсэг 2016”, “Бодис-2016” “Бүртгэл- 2016” зэрэг нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд салбар төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж, үйлдэгдсэн гэмт хэргүүдийг илрүүлэх чиглэлээр Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах тасаг, болон бусад тасгуудтай хамтран “Эрэн сурвалжлалт”, “Хулгай”, “Хулгайн ан”, ”Цагаан гоёо” “Ми Ми” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, хамтарсан шалгалтуудыг тогтмол зохион үр дүнг тооцон ажилласан.

Дээрх арга хэмжээний хүрээнд үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 25 гэмт хэргийг нөхөн илрүүлж, эрэн сурвалжлах мэдээллийн ASAP сангаар эрэн сурвалжлагдаж байсан оргодол 5, гэмт хэрэгт сэрдэгдсэн 16 этгээдийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож, хариуцсан орон нутгийн нөхцөл байдалд тохирсон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг хэсгийн төлөөлөгч нартай хамтран зохион байгуулж хууль бусаар цагаан гоёо түүж хадгалсан 6, Хулгайн ан, ан агнуурын хууль тогтоомж зөрчсөн 8, БНХАУ-д үйлдвэрлэгдсэн “Ми Ми” гэх мансууруулах үйлчилгээтэй байж болзошгүй нутаг цагаан бодисыг хууль бусаар Монгол улсын хилээр оруулж ирсэн, гар дээрээс худалдан борлуулсан зэрэг 5 гэмт хэргийг илрүүлэн ажилласан байна

Хэсгийн төлөөлөгч нарын цугларалтыг сар бүр зохион байгуулан алба хаагчдыг ЭЦГ-ын мэдээллийн сүлжээнд ажиллуулан дүн мэдээг нэгтгэн авч, Цагдаагийн газрын даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл сургалтыг зохион байгуулж үр дүнг тооцон ажилладаг.

“Төлөөлөгч нарын цугларалтаар зохион” байгуулсан тэмцээний үеэр

Хэсгийн төлөөлөгч нарын сургалт

3.2. <u>Хэрэг бүртгэх Мөрдөн байцаах албаны чиглэлээр</u>

Хэрэг бүртгэлтийн чиглэлээр 2016 онд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэргийн шинж бүхий 702 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч, 488 өргөдөл, гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 202 өргөдөл, гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 12 өргөдөл, гомдол, мэдээллийг харьяалалын дагуу шилжүүлж, нийт өргөдөл, гомдол, мэдээллийнхээ 50,2 хувийг 5 хоногт, 49,8 хувийг 5-19 хоногт шалгаж 100 хувь хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

Мөн хэрэг бүртгэлтийн шатанд 205 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас мөрдөн байцаалтын харъяаллаар 12 хэргийг шилжүүлж, 66 хэргийг яллагдагчаар татах тогтоол батлуулахаар прокурорт шилжүүлж, 112 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлж, хялбаршуулсан журмаар 60 хэргийг прокурорт шилжүүлж, шалгасан хэргийнхээ 92,6 хувийг шалгаж шийдвэрлэсэн байна.

Хэрэг бүртгэлтийн шатанд иргэд байгууллагад нийт 368,1 сая төгрөгний хохирол учирсанаас 260,2 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 70,6 хувьтай байна.

Бүртгэхдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 35 хэргээс хэрэг бүртгэлтийн шатанд 16 хэргийг илрүүлж илрүүлэлт 45,7 хувьтай байна.

2016 онд мөрдөн байцаалтын чиглэлээр иргэд байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн гэмт хэргийн шинж бүхий 379 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч 164 өргөдөл, гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, 21 өргөдөл, гомдол, мэдээллийг бусад байдлаар шийдвэрлэж, 189 өргөдөл, гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж шалгаж, шалгасан өргөдөл, гомдол, мэдээллийн 98,6 хувийг шийдвэрлэсэн байна.

Энэ хугацаанд нийт 253 холбогдогчтой, 264 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 169 холбогдогчтой 141 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 11 хэргийг нэгтгэн шалгаж, 47 холбогдогчтой 81 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж, 18 холбогдогчтой 6 хэргийг харьяалалын дагуу шилжүүлж, 12 хэргийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн ба мөрдсөн нийт хэргийнхээ 88.2 хувийг шийдвэрлэж барагдуулсан байна.

Шалгаж шийдвэрлэсэн нийт хэргийнхээ 96.6 хувийг хуульд заасан анхны хугацаанд, 95.2 хувийг гологдолгүйгээр шийдвэрлэсэн ба одоо 12 холбогдогчтой 13 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна.

Бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 40 хэргээс мөрдөн байцаалтын шатанд 30 хэргийг буюу 75,0 хувийг илрүүлж шалгаж шийдвэрлэсэн байна.

Мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 3820.5 сая төгрөгний хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 9.0 сая төгрөгний эд хөрөнгө битүүмжилж, 2510.8 сая төгрөгний хохирлыг буюу 65.9 хувийг нөхөн төлүүлж ажилласан болно.

Хэрэг бүртгэлтэнд түдгэлзээтэй байсан 7 хэргээс, мөрдөн байцаалтанд түдгэлзээтэй байсан 71 хэргээс эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 12 хэргийг нөхөн илрүүлж, мөрдөн байцаалтаас оргон зайлсан 3 сэжигтэн, яллагдагчийг олж баривчлан нийт 38 хэргийг сэргээн шалгаж, 14 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 6 хэргийг нэгтгэн шалгаж, 18 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Одоо тус тасагт хэрэг бүртгэлтийн чиглэлээр яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 7 хэрэг, мөрдөн байцаалтын чиглэлээр яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 30 хэрэг, сэжигтэн, яллагдагч нь мөрдөн байцаалтаас оргон зайлсан 1 хэрэг, сэжигтэн, яллагдагч нь өвтэйгээс түдгэлзүүлсэн 2 хэрэг, нийт 40 түдгэлзүүлсэн хэрэгтэй байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн 2016 оны албаны сургалтын төлөвлөгөөг бүтэн жилээр боловсруулан, заагдсан төлөвлөгөө, сэдвийн дагуу явууллаа. Үүнд:

“Түдгэлзүүлсэн, хугацаа сунгасан, удааширсан хэргийг шийдвэрлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид авах арга хэмжээ”, “Хэргийн газрын хамгаалалт авахад анхаарах асуудал”, “Хууль тогтоомжийн тухай хууль”, “Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл”, “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалтыг хэрэглэхэд анхаарах асуудал”, “Шүүхэд төрийг төлөөлөх хяналтын ажил, цаашид анхаарах асуудал”, “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”, “Хэргийн газрын үзлэг, анхаарах асуудал”, “Алба хаагчийн ажлыг үнэлэх”, “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх”, “Гадаадын байгууллага иргэнтэй харилцах журам”, “Эрэн сурвалжлах”, “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн мэдэгдэл, хариу авч үр дүнг тооцох”, “Залилан мэхлэх гэмт хэргийг иргэний эрхзүйн харилцаанаас ялгаж зүйлчлэх нь”, “Шүүх шинжилгээний албатай хамтран ажиллах, тулгамдаж байгаа асуудал, хүндрэл бэрхшээл”, “Улсын их хурлын ээлжит сонгууль болохтой холбогдсон цаг үеийн сургалт”, “Эрүүгийн хэргийг шилжүүлэх, хүлээн авах журам” сэдвүүдээр ахлах албан тушаалтнууд болон аймгийн шүүх, прокурор, шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтран тус тус сургалт зохион байгуулан ажилласан байна.

Урьд онд мөрдөн байцаалтанд түдгэлзээтэй байсан 46 хэргээс эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 3 хэргийг нөхөн илрүүлж, мөрдөн байцаалтаас оргон зайлсан 1 сэжигтэн, яллагдагчийг олж баривчлан нийт 11 хэргийг сэргээн шалгаж, 4 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 7 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн байна.

Одоо тус тасагт мөрдөн байцаалтын чиглэлээр яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 42 хэрэг, сэжигтэн, яллагдагч нь мөрдөн байцаалтаас оргон зайлсан 1 хэрэг, сэжигтэн, яллагдагч нь өвтэйгээс түдгэлзүүлсэн 2 хэрэг, шаардлагатай гэрч хохирогч байхгүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 1 хэрэг нийт 46 түдгэлзүүлсэн хэрэгтэй байна.

3.3. <u>Хэв журам хамгаалах албаны чиглэлээр:</u>

Нийтийн хэв журам хамгаалах тасаг нь Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, Цагдаагийн ерөнхий газар, Нийтийн хэв журам хамгаалах алба, Цагдаагийн газраас 2016 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон Хууль зүй, дотоод хэргийн яам,Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал шийдвэрүүдийг тухай бүр бие бүрэлдэхүүнд танилцуулан судлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Архигүй Монгол” санаачилга, Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014-2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр” зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөр, санаачлага, чиглэл, даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан зохион байгуулж, дүгнэн хэрэгжилтийг улирал бүр холбогдох газруудад хүргүүлэн ажилласан байна.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2016 онд зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилт, удирдах дээд байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг чиглэл, албан даалгавар, заавар зөвлөмж, хэрэгжиж буй хөтөлбөр, бусад төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, газрын даргаар батлуулан, улирал бүр хэрэгжилт үр дүнг тооцон ажиллав. Алба хаагчдын хийж гүйцэтгэх ажлыг өдөр бүр төлөвлүүлэн баталж, үр дүнг тооцон, тасгаас зохион байгуулсан ажлыг улирал бүр газрын даргад нэгтгэн танилцуулж, Нийтийн хэв журам хамгаалах албанд тайланг хүргүүлж хэвшсэн.

Байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2016 онд зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөө, “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөр”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан газрын даргаар батлуулан, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр гарган Нийтийн хэв журамхамгаалах тасаг, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд цаг тухай бүр нь хүргүүлэн ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийн судалгаанд тулгуурлан зохион байгуулах ажил, арга хэмжээ, цаашид баримтлах бодлого, шийдвэрийн санал, төсөл, төлөвлөгөөг боловсруулан

аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Даланзадгад сум\хот\-ын ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ-т хүргүүлэн тухай жилд зохион байгуулах ажил, арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр, захирамж шийдвэрт тусгуулан хамтран хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллалаа. Цаг үеийн холбогдолтой гаргуулах шийдвэр, ажил арга хэмжээний саналыг ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, сумын ЗДТГ, ГХУСАЗСЗ-д газрын даргын албан бичгээр хүргүүлэн, төлөвлөгөөнд тусгуулах, төлөвлөгөөг боловсруулах ажлыг хамтран зохион байгуулж, батлагдсан төлөвлөгөөг нийт алба хаагч нарт танилцуулж, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллав.

Аймгийн ИТХ, ГХУСАЗЗ, ЗДТГ, Даланзадгад сум\хот\-ын ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ-т танилцуулж шийдвэрлүүлсэн асуудал: Аймгийн ГХУСАЗЗ, Даланзадгад сум\хот\-ын ГХУСАЗСЗ-ийн 2016 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг боловсруулан албан бичгээр холбогдох газруудад хүргүүлэн, тухайн онд зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулахад оролцон хамтран ажиллав. Даланзадгад сум\хот\-ын ГХУСАЗСЗ-ийн 1-р хурлаар 2016 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хэлэлцэж шийдвэрлэв.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, “Нийгэм эдийн засгийн хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгуулах саналыг нэгтгэн, боловсруулж ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-т албан бичгээр хүргүүлэн, аймгийн Засаг даргын 2017 оны үндсэн чиглэлд тусгуулав.

2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр идэвхитэй хамтран ажилласан, үр дүнтэй ажил, арга хэмжээг санаачлан зохион байгуулж, үнэтэй хувь нэмэр оруулсан албан тушаалтан, аж ахуй нэгж, байгууллага, алба хаагч, иргэдийг шалгаруулан шагнаж урамшуулах асуудлыг аймгийн ИТХ, ГХУСАЗЗ, Даланзадгад сум\хот\-ын ГХУСАЗСЗ-д танилцуулан шийдвэрлүүлэв.

Бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдал, сахилга хариуцлага, цэрэгжилч, жагсаалч байдал, алба хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх чиглэлээр:

-Тус Цагдаагийн газар нь2016 оны 1, 2, 3, 4-р улиралд бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдал, сахилга хариуцлага, цэрэгжилч, жагсаалч байдал, алба хаагчдын ёс зүйг төлөвшүүлэхэд анхаарч сургалтыг төлөвлөгөөний дагуу шалгах ажлыг зохион байгуулсан ба Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Цагдаагийн дотоод албаны дүрэм, Цагдаагийн алба хаагч биеийн хүч тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмаар тус тус нийт бие бүрэлдэхүүнд 4 удаагийн сургалт явуулж, алба хаагчдаар бие даан судлуулав. Тайлангийн хугацаанд дээрх хууль журмуудаар ахлагч бүрэлдэхүүнээс 1 удаа тестээр эрхзүйн мэдлэгийн шалгалт авч, үр дүнг тооцлоо.

2016 оны 1, 6 дугаар саруудад Цагдаагийн газрын ахлагч бүрэлдэхүүний цугларалт, сургалтыг зохион байгуулсан ба сургалтыг төлөвлөгөө, удирдамжийн дагуу явуулж хууль эрх зүйн мэдлэг олгох, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан тэмцээн, уралдааныг явуулж, алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Гурвансайхан байгалийн цогцолборт газарт аялуулах зэрэг ажлыг зохион байгуулж ажилласан байна.



- Цагдаагийн алба хаагчдын хоорондоо албаны харьцаагаар харьцах, цэрэгжилч жагсаалч байдал, бие биендээ хүндэтгэлтэй хандаж байгаа эсэхэд газрын удирдлагууд болон ёс журам сахиулах эргүүлүүд тогтмол хяналт тавин илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд нийт бие бүрэлдэхүүнд 4 удаа, тасгийн бүрэлдэхүүнд 12 удаа болон Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжих, хамгаалалт, зохицуулалтад ажиллах бүрт жагсаалын үзлэг, бэлтгэлийг хийлгэж, илэрсэн зөрчлийг тухай бүр нь арилгуулж ажиллав.

-Алба хаагчдын дундаас үйлдэгдэж болзошгүй сахилга, ёсзүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус газрын сэтгэл зүйчтэй хамтарч нийт ахлагч бүрэлдэхүүнийг ганцаарчлан уулзаж, зөвлөгөө өгөх, баталгаа авах, гэр бүлийн гишүүдтэй нь уулзаж ярилцах зэрэг арга хэмжээнүүдийг авч, тасгийн алба хаагчдын ар гэрийнхэнтэй харьцах аялах дэвтэрийг нээж, алба хаагчдын ахуй амьдрал, санал хүсэлтийг авч, шийдвэрлэх боломжтой асуудлыг шийдвэрлэн ажилласан байна.

Орон нутгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд болон алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тасгийн даргаас хяналтыг тогтмол тавьж, алба хаагчдын ажлын үр дүнгийн биелэлтийг 7 хоног, сар, улирал, бүтэн жилээр тооцон, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Даланзадгад сумын баг хариуцсан хэсгийн байцаагч нарын үйл ажиллагаанд 2 удаа газрын даргаар батлагдсан төлөвлөгөөны дугуу хяналт, шалгалтыг явуулсан ба Цагдаагийн газрын Албадан саатуулах, баривчлах байрны дарга эмч, ГБХХГХУСАБ-гч, АСТАХАБ-гч, ОНХАБ-гч, ХЖАХАБ-гч, Жижүүрийн ахлах офицер, хэсгийн байцаагч, төлөөлөгч нарт үйл ажиллагаатай нь холбогдуулан үүрэг, ажлын чиглэлийг бичгээр өгч, хэрэгжилт үр дүнг улирал болон заасан хугацаанд авч тооцон ажилласан.

<u>Гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх чиглэлээр:</u>

Даланзадгад сумын 8 багийн нутаг дэвсгэрийг хамруулан хөдөлгөөнт эргүүл, явган эргүүлийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байгаа бөгөөд гэмт хэрэг, эрхзүйн зөрчлийн нөхцөл байдалд 7 хоног тутам Криминалоги судалгааны багаас үнэлэлт, дүгнэлт хийж, урьд оны мөн үетэй харьцуулан өгсөн “зөвлөмж”-ийн дагуу эргүүлийн чиглэл, байршлыг тодорхойлон, өдөр бүрийн томилгоогоор баталгаажуулан, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгах, урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэхчиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Мөн сар бүрийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээнд дүгнэлт хийж онцлог бүхий сар, цаг хугацаанд тохируулан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: "Сар шинэ", "Эргүүл", "Зөрчил", "Шимийн архи", "Шинэ жил", “Зэвсэг-2016”, “Захирамжийн хэрэгжилт”, "Илрүүлэлт" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг дангаар болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээнд 2 удаа цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч цаашид авах арга хэмжээний талаар албадууд санал гарган хамтран ажилласан байна. Гэмт хэрэг, зөрчил голлон үйлдэгддэг газруудад Даланзадгад суманд 3, Цогтцэций суманд 2, Гурвантэс, Ханбогд сумдад

тус бүр 1 хөдөлгөөнт эргүүл тогтмол ажиллаж байгаа ба бусад сумдад хэсгийн төлөөлөгч, цагдаа нар машинт болон явган эргүүлд гарч ажиллаж байна.

Тус Цагдаагийн газраас явган эргүүлийг хэсгийн байцаагч, цагдаа, Олон нийтийн цагдаа, байгууллагуудын нийтийн эргүүл гэсэн төрлүүдээр зохион байгуулж байгаа ба Олон нийтийн цагдаа, байгууллагуудын нийтийн эргүүлийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллага олон нийтийн хамтын ажиллагааг сурталчлах чиглэлээр түлхүү ажиллуулж байна.

Гэмт хэрэг, зөрчөөс урьдчилан сэргийлэх, Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар:

Цагдаагийн газрын хэмжээнд 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулан улирал бүр хэрэгжилтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэн танилцаж, цаашид хийх ажлын талаар сумдад чиглэл, зөвлөмж хүргэх ажлыг тогтмолжуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөр, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл судалгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн даргын зөвлөлийн хуралд танилцуулан НХЖХА-д хүргүүлэн ажиллалаа. Тухайлбал:

Аймгийн ИТХ, ГХУСАЗЗ, ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “АВТОМАШИНГҮЙ ӨДӨР”, “ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛООР ХОХИРОГСДОД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ДЭЛХИЙ НИЙТИЙН ӨДӨР” арга хэмжээг аймгийн хэмжээнд 15 суманд нэгэн зэрэг 2016 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр зохион байгуулж аймгийн Маанийн хийдийн лам нар зам тээврийн ослын улмаас хохирогсдод хүндэтгэл үзүүлэн ном хурж, 108 зул өргөх ажиллагааг зохион байгууллаа. Мөн арга хэмжээнд Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг хамруулан оролцууллаа. Уг арга хэмжээг авто ослоор амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, сэтгэл санааны болон бусад хохирол амсаж суугаа тэдний ар гэр, ойр дотныхонд гашуудал илэрхийлэх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, зам тээврийн ослын хор уршгийг олон нийтэд таниулах, осол хэргийн үр дагавар нь маш хүнд, хохирогсдын ар гэрийнхэнд нөхөж баршгүй уй гашуу авчирдаг, амьдралын нөхцөл эрс дордоход хүргэж байдаг тул амь нас, эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн ар гэр, тэдний дуу хоолойг олон нийтэд хүргэх, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд иэдэвхитэй оролцсон байгууллага, иргэдийн дунд тайван жагсаал, Спортын болон Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг шалгах тэмцээн уралдаан зохион байгуулагдаж “Эрүүл агаар эрчимтэй хөдөлгөөн” сэдэвт олс таталтын төрөлд ШШГА, ДЗ сумын ЗДТГ-ын хамт олон нэгдүгээр, БТСГ хоёрдугаар, ӨБЦТС ТӨХК гуравдугаар байруудад орж, уг арга хэмжээнд идэвхи санаачилгатай оролцож зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг сайн зохион байгуулсан шилдэг байгууллагыг шалгаруулсан ба хурандаа Ө.Эрдэнэ-Очир захирагчтай Зэвсэгт хүчний 167-р анги шалгарч аймгийн ГХУСАЗЗөвлөлийн талархал мөнгөн шагналаар шагнагдлаа.

Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан жил бүр уламжлал болгон зохион байгууллагддаг **“Замын хөдөлгөөний цагаан толгой-2016”** тэмцээнийг сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд соёлтой оролцох дадлыг багаас нь эзэмшүүлэх, зорилготойгоор Замын цагдаагийн газраас ирүүлсэн удирдамжийн дагуу салбар төлөвлөгөө гаргаж аймгийн ГХУСАЗЗ-н даргаар батлуулан Даланзадгад, Цогтцэций суманд зохион байгуулалаа.

“Замын хөдөлгөөний цагаан толгой-2016” тэмцээнийг Аймгийн ГХУСАЗЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Насан туршийн боловсролын төв, Албан журмын даатгагчдын холбоо, Улаан загалмайн хороо, Даланзадгад сумын ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, автосургуулиудтай хамтран 2016 оны 04-р сарын 29-ны өдөр Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй 2-р цэцэрлэг, 8-р цэцэрлэг, 9-р цэцэрлэг, 11-р цэцэрлэг, 23-р цэцэрлэг, Цогтцэций сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 6-р цэцэрлэг, 7-р цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж идэвхитэй оролцож, хамтран ажилласан. Замын цагдаагийн тасгаас тэмцээнд оролцох багуудад зөвөлгөө тусламж үзүүлэн цэцэрлэгийн эрхлэгч нарт болон багш ажиллагсад, эцэг эх хүүхдүүдэд бага насны хүүхдийг аюулгүй тээвэрлэх, аюулгүйн суудлыг хэрэглэж хэвших ач холбогдол сэдвээр 5 удаагын сургалтыг зохион байгуулан ажиллаа. Шүүгчид тэмцээний дүнг нэгтгэн танилцуулж 1, 2, 3-р байр эзэлж алт, мөнгө, хүрэл медал хүртсэн баг, хамт олонд шагналыг гардуулан өгч баяр хүргэв.

Бага насны хүүхдүүдийн дунд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд соёлтой оролцох дадлыг багаас нь эзэмшүүлэх, зорилготойгоор ерөнхий боловсорлын хоёрдугаар сургуулийн 2-5 ангийн нийт 130 сурагчдын дунд “Ногоон гэрэл цагаан шугам-2016” тэмцээнийг зохион явууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчидад Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, замын хөдөлгөөнд соёлтой оролцож хэвших ач холбогдлыг өсвөр үе, иргэдэд сурталчилах ажлыг эрчимжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Ногоон гэрэл цагаан шугам-2016” тэмцээнийг Аймгийн ГХУСАЗЗөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын төв, автосургуулиудтай хамтран 2016 оны 11-р сарын 18-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд 4 сургуулийн 5 баг 65 сурагч 5 багш оролцсон бөгөөд 1-р байранд 4-р сургуулийн “Шонхор” баг, 2-р байранд 1-р сургуулийн “Traffic policeman” баг, 3-р байранд Эрдмийн гэгээ сургуулийн “Хүчирхэг-13” багууд тус тус байр эзэллээ.

Өмнөговь аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагуудад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг алба хаагч нартаа судлуулан үр дүнтэй сургалт зохион байгуулж хамтран ажиллах талаар албан бичгийг 65 байгууллагад хүргүүлэн 116 аж ахуй нэгжид 4250 иргэнд сургалтыг үр дүнтэй зохион байгуулан ажилласан.Замын цагдаагийн тасгаас аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 24 алба хаагч, Мэдээлэл холбоо сүлжээний газрын 18 алба хаагч, Татварын хэлтсийн 21 алба хаагч, Зэвсэгт хүчний 167-р ангийн 69 алба хаагч хаагч, жолооч бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг “Дэгжих говь” авто сургуулын 36 сонсогч, Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн 18 сонсогч, Тэнгэрийн хүрд автосургуулийн 8 сонсогчидод Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тасгийн ахлах зохицуулагч цагдаагийн ахмад О.Чулуунбаатар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хууль зүйн сайдын 2015 оны А/178 дугаар тушаал жолоочийн зөрчлийн оноо тооцох журмаар тус тус 2 цагийн сургалтыг зохион байгуулан ажиллаа.

Аймгийн боловсролын газартай хамтран дунд сургуулийн сурагчдад замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Б.Оюунчимэг, архидан согтуурахтай тэмцэх ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Д.Гэрэлт-Од, хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Г.Өнөржаргал, олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч А.Төмөрмөнх нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Хуульзүйн хэлтсийн мэргэжилтэн Н.Нарангарав нартай хамтран гадаадын иргэн харьяатын албатай хамтран 2016 оны 05-р сарын 16-19 Гашуунсухайтын хилийн боомтын ажилчин алба хаагчдад, 05-р сарын 20-23-ний өдрүүдэд Шивээхүрэн хилийн боомтын ажилчин алба хаагч нарт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх сургалт”, “Хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, анхаарах асуудал”, “Хар тамхи, мансууруулах бодис, анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтанд 80 төрийн албан хаагч, 150 орчим иргэд хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх зорилгоор албадан сургалтын хөтөлбөрийг аймгийн гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран баталж, эрх хязгаарлуулах арга хэмжээ авагдсан 3 иргэнд уг сургалтыг зохион байгуулан ажиллалаа.

Гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийг бууруулах талаар сургуулийн сурагч, өсвөр насны хүүхдүүдийн мэдлэгийг нэмэгдүүлж хандлагыг өөрчлөх зорилгоор аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дэргэдэх Залуучууд хөгжлийн төвтэй хамтран “Жендэр ба өөрчлөлт” төслийн хүрээнд

“Хүчирхийллээс ангид байя” нэгдсэн арга хэмжээг 2016,03,10-25-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд аймгийн нийт сум, багийн Засаг дарга нарт “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн 14-р зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаар сум, багийн Засаг даргын үүргийн талаар сургалт орж, ярилцлага зохион байгуулсан.

Мөн сумдын нийгмийн ажилтнуудад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн 10-р зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх нийгмийн ажилтны үүрэг сэдвээр сургалт зохион байгуулж, ярилцлага хийсэн.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Хүчирхийллээс ангид байя” сэдвийн дор “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд уг тэмцээнд Ерөнхий боловсролын 3 дунд сургууль, Политехник коллежийн оюутан нийт 32 сурагч хамрагдаж, сургууль бүрийн “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн сурагчид хөгжөөн дэмжигчээр оролцсон ба ЕБ-ын 1-р дунд сургууль 1-р байрыг, ЕБ-ын 2-р дунд сургууль 2-р байр, ЕБ-ын 3-р дунд сургууль 3-р байрыг, Политехник коллежийн оюутнууд тусгай байрыг эзэллээ. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хүүхдийн дүрслэх сэтгэхүйг зурсан зургаар дамжуулан өөрийн үзэл бодлоо уран зургийн аргаар илэрхийлэх зорилгоор “ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙЯ” сэдэвт гар зургийн уралдааныг ЕБС-ын 1-5-р ангийн сурагчдын дунд зарлаж дүнгээ гаргалаа. Уралдаанд нийт хар зураг, усан будаг, тосон будаг, гуашан будгаар зурж ирүүлсэн 95 бүтээлийг хүлээн авч шалгаруулаа. Нэгдсэн дүнгээр шалгарч шагналт байранд орсон сурагчдыг “Жендэр ба өөрчлөлт” төслийн хүрээнд өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Нэгдсэн арга хэмжээнийхүрээнд хүүхэд багачуудыг Монгол хэлний үгсийн урлагийн гайхамшигт ертөнцөөр аялуулан, үг хэллэгийн арвин баялаг сантай танилцуулж, санасан бодсоноо сэтгэн хөгжүүлэх, зохиох, бүтээх, туурвих урлагт сургах зорилгоор ЕБС-уудын 6-9-р ангийн сурагчдын дунд “ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙЯ” шүлгийн уралдааныг зарлаж амжилттай зохион байгуулагдлаа.Уралдаанд нийт ЕБС-ын дунд ангийн сурагчдын 42 шүлэг дээрх хугацаанд ирүүлснийг ХГБХХ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран шүүн явуулж дүнгээ гаргасан. Ар гэртээ агсан тавьж Цагдаагийн газрын албадан саатуулах байранд шүүхийн шийдвэрээр баривчлагдсан 5 иргэнд аймгийн Залууд хөгжлийн төвэй хамтран “Жендэрт суурилсан хүчирхийлэл” “ Архи уудаг хүний хүүхэд” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. “Амжилт азжаргалын нууц” ТББ-тай хамтран цагдаагийн газрын АСББ-нд баривчлагдсан иргэдэд сар бүрийн сүүлчийн 7 хоногийн Баасан гаригт зан үйлд нөлөөлөх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Уг арга хэмжээнд нийтдээ 80 орчим хүн хамрагдсан байна.

Аймгийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, цагдаагийн газар, аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн баривчлах байранд байгаа 7 хүнд “Ухаарал” сэдэвтэй сургалт хийж, санал сэтгэгдлийг сонсох ажлыг зохион байгуулсан.

Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлд 50 сая тусгуулан шийдвэрлүүлсэний дагуу гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд болон тэдний бага насны хүүхдийг хамгаалах түр байрыг бий болгон тохижуулж, аймгийн тахарын албанд хүлээлгэн өгсөн бөгөөд цагдаагийн газар хамтран ашиглаж байна. Тус аймагт 2016 оны 4-р сард аймгийн Засаг даргад хүсэлт тавьсны үндсэн дээр “Гэрч хохирогчийг хамгаалах байр” шийдэгдэн тахарын албанд харъяалагдан ажиллаж байгаад 2016 оны 8-р сард тус Цагдаагийн газрын харъяанд ирсэн байна. Тус байраар үйлчлүүлэх хүсэлт гаргасан иргэн байхгүй байна.

Аймгийн ГХУСАЗ-ийн 2016 онд хийх ажлын төлөвлөгөө болон аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлд аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хамтарсан хяналт шалгалтыг уул уурхайн аж ахуйн нэгж, хилийн боомтод хийхэд зориулж 2 сая төгрөг тусгуулан шийдвэрлүүлсэний дагуу 2016 оны 04-р сарын сүүлээр зүүн сумдууд болох Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Манлай зэрэг сумдын иргэдэд сургалт хийх, байгаль орчины эсрэг гэмт хэргийн талаарх сумдын ГХУСАЗСЗ-ийн ажлыг шалгаж, зааварчлах, уул уурхайн компанийн үйл ажиллагаатай танилцаж, шалган заарчилах, хилийн боомтын нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцаж, улсын хилээр хууль бусаар эд зүйл ялангуяа алт, чулуу гаргахгүй байх талаар хамтран ажиллах төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлыг зохион байгуулсан. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 10-р сарын 08-ны өдрийн 136 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн нутаг дэсвгэрт металл хайгч ашиглахыг хориглох шийдвэрийг хууль тогтоомж зөрчсөн гэж улсын дээд шүүхээс үзсэн тул түдгэлзүүлээд байна. Мөн байгаль орчны эсрэг гэмт хэрэг, хууль бус агнуур худалдааны талаар мэдээлэл авах шуурхай утас 97177000 дугаар, аймгийн цагдаагийн газрын иргэдээ сонсох утас 70533321 дугаарыг сурталчилсан наалтыг тус бүр 500 ширхэг хэвлүүлэн олшруулж сумдад хүргүүлсэн.

2016 оны 3-р сард аймгийн Прокурорын газар, хуульзүйн хэлтэс, говийн бага дархан цаазат газрын орон унтгийн захиргаа, говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын захиргаатай хамтран “Нэн ховор ургамал болох цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо хууль бусаар түүж бэлтгэх, худалдах, хил нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагаанд учирч байгаа хүндрэл бэрхшээл цаашид анхаарах асуудал” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалт хийсэн.

Хулгайн ан, агнууртай тэмцэх чиглэлээр мэдээлэл авах утасны дугаартай наалтыг олон нийтийн үйлчилгээний газруудад байрлуулсан. Хулгайн ангийн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1200 гаруй гарын авлага тараах материалыг хэсгийн төлөөлөгч нараар дамжуулан сум орон нутгийн иргэдэд хүргэж, орон нутгийн “Алтан говь”, “Best TV” зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 30-40 минутын сэрэмжлүүлэг нэвтрүүлгийг иргэдэд хүргэх ажлыг улиралд 1 удаа зохион байгуулж ажилласан. Өмнөговь аймгийн мэргэжлийн хяналтын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах гэрээнй дагуу Цагдаагийн байгууллага, БОАЖГазар, Тусгай хамгаалалтай газаруудтай хамтран “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Газрын тухай”, “Тэсэрч дэлбэрэх бодис, “Газрын хэвлийн тухай”, “Усны тухай”, “Хог хаягдлын тухай”, “Химийн хорт болон аюултай бодисын тухай”, “Амьтны тухай”, “Ойн тухай” хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам стандартын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийлээ.

Мэргэжлийн хяналтын газар, БОАЖГазар, Тусгай хамгаалалтай газар, Цагдаагийн газар, Даланзадгад сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч нар хамтран “Хулгайн ан, хууль бус мод, модон бүтээгдэхүүн бэлтгэх” хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсуулан 2016 оны 11 дүгээр сарын 28, 29, 30-ны өдрүүдэд сум, аймгийн гарах, орох зам дээр таван чиглэлд пост гарган нэг өдөрт цагдаагийн байгууллагаас 4, МХГ-аас 4 бусад байгууллагаас 2-4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа. Хяналт шалгалтаар нийт 100 гаруй машинийг хяналтанд хамруулсан шалгалтын явцад 2063 дуа улсын дугаартай ногоон өнгийн фургон машинаас Голд мастер метал хайгч хураан авч фото зураг авч баримтжуулан машин техник хэрэгслийг цагдаагийн байгууллагад түр саатуулаад байна. Мөн бусад тээврийн хэрэгсэлийн тээвэрлэн яваа ачаа, мах махан бүтээгдэхүүнд хяналт хийж гарал үүслийн гэрчилгээ бусад бичиг баримтанд хяналт тавин ажилласан. Хяналт шалгалтын явцад мэдээлэл авах шуурхай утсанд ирсэн иргэний мэдээллийн дагуу цагдаагийн байгууллагатай хамтран шалгалт хийхэд Номгон, Ханхонгор сумын зааг Гэдэргийн хэц гэх газар /кординат N43.22911 E104.885222/ дээр хууль бус хулгайгаар аргаль хонь агнасан нь тогтоогдож фото зургаар баримтжуулж, эрүүгийн хэрэг үүсгэн ажиллалаа.

2016 оны 05-р сарын 30-ний өдөр Дорноговь, Дундговь аймгийн Цагдаагийн газрын алба хаагчдын төлөөллийг хүлээн авч, аймгийн Нутгийн удирдлагын ордоны Сүлд танхимд “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Мөн эрдэм шинжилгээний хурлын талаар мэдээллийг орон нутгийн Алтанговь, UCTV телевизэд өгч, “Өмнөговь Цагдаагийн газар” цахим хуудсанд байршуулж, сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Э.Мөнх-Эрдэнэ, хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Г.Өнөржаргал нар 2016 оны 03-р сард Даланзадгад сумын 8-р багийн малчин өрхүүдэд шинэчлэгдэн батлагдсан эрүүгийн хуулийн мал хулгайлах гэмт хэргийн талаарх зааltыг сурталчлах ажлыг багийн хурлын үеэр зохион байгуулсан бөгөөд 2016 оны 05-р сарын 13-ны өдөр аймгийн төв талбай болох Нутгийн удирдлагын ордоны өмнөх Батмөнх Даян Сэцэн хааны нэрэмжимт талбайд зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний хүрээнд мэдээлэл өгч, иргэдээс санал, хүсэлт, гомдол, мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулсан.

Өмнөговь цагдаагийн газар цахим хаягаар дамжуулан хүүхэд, залуучуудад хар, тамхи мансууруулах бодисоос сэрэмжлүүлэх мэдээ, мэдээлэл, богино хэмжээний шторкыг хүргэсэн. Өмнөговь Цагдаагийн газар цахим хаяган дээр **“**Шинэ үеийн сонголт лав эдгээр биш**”** нэртэй нээлттэй бүлгэм үүсгэн хар тамхи, мансууруулах бодис, архи, тамхины хэрэглээ, хорт зуршлын талаар мэдээ, мэдээлэл тавин ажиллаж байна. Хүүхэд залуучуудын соёл мэдээллийн төв буюу Галакси кинотеатртай хамтран аймгийн ГХУСАЗ, Даланзадгад сумын ГХУСАЗС3-ийн санхүүжилтээр шийдвэрлүүлж, иргэдэд болон хүүхэд залуучуудад кино үзвэр үйлчилгээгээр үйлчлэхийн өмнө хүлээлгийн хугацаанд хар тамхи мансуурулах бодис, хүн худалдаалах гэмт хэргийн талаар бэлтгэсэн богино хэмжээний шторкыг хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭЦГ-ын Цахим гэмт хэрэгтэй тэмцэх цахим хаяг болон “CYBER DIVISION” группэд байршуулсан интернэт залилан, секс сүрдүүлгээс

урьдчилан сэргийлэх агуулага бүхий шторк, сэрэмжлүүлгүүдийг Өмнөговь аймгийн “Цагдаагийн газар”, “Өмнөговь зарын нэгдсэн групп” зэрэг олон нийтийг хамарсан цахим хуудсанд байршуулж иргэдэд хүргэн ажилласан. Цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж бүхий зурагт хуудас, тараах метариал хэвлэх, олшруулах зэрэг ажилд зарцуулагдах тодорхой хөрөнгө, мөнгийг шийдүүлэх зорилгоор орон нутгийн удирдах байгууллага болон төрийн бус байгууллагуудын тусламж дэмжлэгийг авахаар санал санаачлага гарган ажиллаж байна.

Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ЭЦГ-ын Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн цахим хаяганд байршуулсан сэрэмжлүүлэг мэдээллийг Өмнөговь Цагдаагийн газар цахим хаягт байршуулан иргэдэд хүргэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулж байна. Тус цагдаагийн газрын цахим хаяг нь байнгын 6000 орчим дагагчтай болоод байна. Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 16 цахим тоглоомын газар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Даланзадгад суманд 12, Цогтцэций суманд 2, Ханбогд, Гурвантэс сумдад тус бүр 1 цахим тоглоомын газар тусгай зөвшөөрөлийн дагуу ажиллаж байгаа ба хяналтын камертай болох, үйлчлүүлэгчдийн бүртгэл хөтлөж байх талаар албан мэдэгдэл хүргүүлэн биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран “Цахим тоглоом”,”Тоглоомын газар”, “Кибер аюул” зэрэг нэртэй арга хэмжээнүүдийг 2016 оны 2, 5, 9,11 саруудад тус бүр нэг удаа нийтдээ 4 удаа зохион байгуулж, интернэт төв, цахим тоглоомын газруудад 410 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж ажилласан. Төлөвлөгөөт шалгалтын хүрээнд Даланзадгад сумын төвд зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан “Өнөр баян” тоглоомын газрын үйл ажиллагааг зогсоон ЗХТХ-ын дагуу 20.000 төгрөгний торгууль оногдуулан, цагийн хувиар хэтрүүлэн ажилласан “Sonic”, “Cyber” зэрэг цахим тоглоомын газруудад ЗХТХ-ын дагуу тус бүр 8000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч, давтан зөрчил дутагдал гаргасан тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авах болохыг сануулан ажилласан. Хяналт шалгалтын үр дүнгээр Цахим тоглоомын газруудаас гаргасан зөрчил, дутагдал нь 2016 оны эхний хагас жилийн үзүүлэлтээс сүүлийн хагас жилд буурсан эерэг үзүүлэлттэй байна.Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний дунд “Цахим гэмт хэргийн ойлголт, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, албаны болон өөрийн гэр бүлийн нууцлал аюулгүй байдлыг олон нийт, цахим орчинд задруулахгүй байх талаар анхааруулга сэрэмжлүүлэг өгсөн. Даланзадгад сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын 5 сургууль, Политехникийн коллеж зэрэг албан байгууллагуудын нийгмийн ажилтнуудтай хамтран 1-2 дугаар курсын оюутан, 9-11 дүгээр ангийн сурагчдын дунд “”Цахим донтолтоос сэргийлье, “Бидний Facebook хэрэглээ болон амьд харилцаа”, “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг 8 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 1760 гаруй оюутан, сурагчдыг хамруулан ажилласан байна.

Алба хаагчдын дунд цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч И.Золбообаатар 1 удаа зохион байгуулсан бөгөөд алба хаагчдыг цахим хаяганд өөрийн албаны дүрэмт хувцастай болон гэр бүлийн гишүүдийн талаарх зураг, бичлэг тавихгүй байх, цахимаар үзэл бодлоо илэрхийлэхгүй байх талаар чиглэл өгсөн. Цагдаагийнгазрыналбаныхэрэгцээндашиглажбайгаакомпъютерийгнууцкодтойболгохажлыгзохион байгуулж, дууссан ба холбооны инженер цагдаагийн ахлах дэслэгч С.Батцэнгэлээр нийт алба хаагчидад Microsoft Lync-2010 мессенжер, Outlook программ, сүлжээний аюулгүй байдал, компъютерийн зөв хэрэглээний талаар нийт алба хаагчидад 2 цагийн сургалт орсон байна.

Цагдаагийн байгууллагын болон ЭЦГ-ын дотоод сүлжээ холбогдсон албаны компьютерт аюулгүй байдлыг хангаж ажиллах талаас нь интернэт холболтыг салгуулсан байна. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тус цагдаагийн газрын эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Өнөрбаярт хариуцуулан 2016 оны 10 сарын 03-ны өдрөөс 10 сарын 05-ны өдрийн хооронд Эрүүгийн цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, ХБНГУ-ын Эрүүгийн цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх” сэдэвт гэрчилгээ олгох сургалтанд хамруулсан байна. Мөн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн “CYBER DIVISION” хаалттай facebook группэд нэгдэн цаг тухай бүрийн мэдээ, мэдээлэлтэй танилцан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөн Цагдаагийн газар, Архидалтгүй Өмнөговь цахим хаягуудаар дамжуулан иргэдээс хууль зөрчсөн үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах ажлыг хэрэгжүүлж байна. 2016 оны байдлаар Өмнөговь аймагт Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, зэрлэг амьтдын хулгайн ан, түүний эд, эрхтэний хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчины газар, Тагнуулын газар, Говийн бага дархан цаазат газар, Прокурорын газрын алба хаагчидтай хамтран баг болон ажиллаж улирал бүр төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулан, иргэдээс төлбөртэй мэдээлэл авах 98900016 дугаарын утсыг ажиллуулан мэдээллийн дагуу хулгайн ангийн 2 гэмт хэргийг илрүүлж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1200 гаруй гарын авлага тараах материалыг хэсгийн төлөөлөгч нараар дамжуулан сум орон нутгийн иргэдэд хүргэж, орон нутгийн “Алтан говь”, “Best TV” зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 30-40 минутын сэрэмжлүүлэг нэвтрүүлгийг иргэдэд хүргэх ажлыг улиралд 1 удаа зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн байгууллагын 95 жилийн ойн болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” уриатай зохион байгуулагдаж байгаа аймгийн Цагдаагийн газрын “Нээлттэй хаалганы өдөр”, “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөр”-ийн арга хэмжээг 2016 оны 05-р сарын 13-ны өдөр аймгийн төв талбай болох Нутгийн удирдлагын ордоны өмнөх Батмөнх Даян Сэцэн хааны нэрэмжимт талбайд зохион байгуулав. “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг аймгийн ИТХ-ын дарга бөгөөд Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх ажлыг Зохицуулах Зөвлөлийн дарга Л.Батчулуун нээж үг хэлсэн бөгөөд аймгийн Засаг даргын орлогч Н.Нацагдорж, Даланзадгад сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга Д.Улам-Өрнөх, бусад агентлаг, албан байгууллагын дарга эрхлэгч нар алба хаагчдын хамтаар оролцов. Цагдаагийн газрын “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээнд хүндэтгэл үзүүлж, ёслолын жагсаалд оролцохоор хурандаа Р.Жигжидсүрэн захирагчтай Зэвсэгт хүчний 167-р ангийн төлөөлөл, хурандаа н.Батхүү захирагчтай Хилийн цэргийн 131-р ангийн төлөөлөл, хурандаа н.Баярсайхан захирагчтай Онцгой байдлын хэлтсийн төлөөлөл, дэд хурандаа Н.Энхбаяр даргатай ШШГА-ын төлөөлөл, 2015 оны “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээний тэргүүн байрын шагналт Даланзадгад сумын 4-р сургуулийн “Хангарьд” баг, 2016 оны “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээний тэргүүн байрын шагналт цэцэрлэгийн баг тамирчид, Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 сургуулийн “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн сурагчид, аймгийн Хөгжимт жүжгийн театрын хамт олон, амьд хөгжмийн “Тулга” хамтлагийн хамт олон болон бусад албан байгууллагын төлөөлөл нийт 250 орчим хүн хамрагдлаа.

Мөн Даланзадгад сумын ГХУСАЗСЗ-өөс нийтийн эргүүлд иэдвхи санаачлага гарган бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг манлайлан ажиллаж байгаа “Гүний ус ХХК”, “Мэдээлэл холбоо, сүлжээ” ТӨК, “Дэгжих говь” автосургуулийг өргөмжлөл, мөнгөн шагналаар, үе тэнгийн хүүхдүүддээ зөв үлгэр дуурайл үзүүлж байгаа “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн 4 хүүхдийг цагдаагийн газрын даргын өргөмжлөл,гарын бэлгээр, School police арга хэмжээнд идэвхи санаачлагатай сайн ажиллаж байгаа ерөнхий боловсролын 3-р сургуулийг өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнаж, урамшуулав.

Цагдаагийн газрын сум дундын Цагдаагийн хэлтэс, тасагт “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулах чиглэл хүргүүлсэний дагуу сумдын хэлтэс, тасаг зохион байгуулж, танилцуулгыг хүргүүлсэн. Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар нь “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний хүрээнд олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг хамруулаад 96 алба хаагч оролцож, 30 төрлийн 1930 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, тараах материал хэвлэн тарааж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 8 удаагийн сурталчилсан мэдээ, мэдээлэл өгч, 100 иргэнээс санал асуулгын хуудас бөглүүлэн авч, 17 санал, 7 хүсэлт, 1 гомдол, 29 мэдээлэл хүлээн авч, газар дээр нь шийдвэрлэсэн бөгөөд давхардсан тоогоор 1100 орчим иргэнд цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг танилцуулан сурталчилж ажиллалаа. Мөн уг арга хэмжээний талаар аймаг орон нутгийн телевизүүдтэй хамтран мэдээлэл хүргэж, зам тээврийн осол бэртэл, өвчнөөс болж шаналж байгаа иргэдэд туслах зорилгоор “Цусаа хандивлая” сайн үйлсийн аяныг санаачлан бусад байгууллага, аж ахуйн нэгжүүдийг уриалсан нь иргэдэд тааламжтай сэтгэгдэл төрүүлсэн талаар сэтгэгдлээ илэрхийлж байлаа.

“Цахим донтолтоос сэргийлье” сургалтыг бэлтгэж, 1-р дунд сургуулийн 8-12 ангийн нийт 578 сурагчийг, 2-р дунд сургуулийн 9-12 ангийн 188 сурагч, 3-р дунд сургуулийн 190 сурагч, Политехник коллежийн 2-р курсийн 186 оюутан, нийт 1142 сурагчийг хамруулан зохион байгууллаа.2016 оны 2-р хагаст “Цахим донтолтоос сэргийлье” сургалтыг бэлтгэж, 10 удаа 659 сургуулийн сурагчийг хамруулан зохион байгуулсан байна.

Тус аймаг нь Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөрийг иргэд, олон нийтэд сурталчлах, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар, дадал суулгах, гэмт хэрэг, зөрчлийг үл тэвчих нийгмийн ухамсар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн “Иргэн ба хууль” цогцолбор тэмцээнийг 13 жил зохион байгуулж байгаа бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн дунд хууль сурталчлах дэвжээ, мэдлэг сорих АХА, гар бөмбөг, буухиа тэмцээнийг 2016 оны 10-р сард зохион байгуулсан. ӨмнөговьаймгийнЦагдаагийнгазрын архидан согтуурахтай тэмцэх ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийнхошууч Д.Гэрэлт-Од аймгийн ЗДТГ-ийн Хуульзүйн хэлтэс, БОЭТ-ийн наркалогийн тасаг, Тахарын алба, Хөгжимт жүжгийн театр, “Говийн наран” телевиз зэрэг байгууллагуудтай хамтран “Архигүй хөдөө” нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа. Тус Цагдаагийн газраас“Архигүй Өмнөговь” хөтөлбөрийг сурталчлах, энэ чиглэлээр сумдын салбар зөвлөлүүдийн хийсэн ажлыг шалгах, Хууль зүйн хэлтсээс Авилгын болон хүн худалдаалах гэмт хэргийн талаар сургалт явуулах, Тахарын албанаас албаа сурталчлах, БОЭТ-ийн наркалогын тасгаас архаг архичидтай уулзаж зөвлөгөө өгөх, Хөгжимт жүжгийн театраас хөдөөгийн иргэдэд урлаг уран сайхнаар үйлчлэх гэсэн тус тусийн чиглэл зорилготой хөдөөгийн 14 суманд 2016.04.05-2016.04.18-ний өдрүүдэд ажилалаа. Дээрхи арга хэмжээний хүрээнд “Архи тамхигүй орчин” бүрдүүлэх аяны хүрээнд идэвхи санаачлагатай ажиллаж байгаа Даланзадгад сумын ЗДТГ, Цагдаагийн газар, Говийн наран бүлгийн үйл ажиллагааг сурталчлах, туршлага хуваалцах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулав.

Мөн хэсгийн төлөөлөгч нарын ажил байдалтай танилцах, тэдний ажил, иргэд байгууллагын хамтын ажиллагааны талаар сумдын удирдлагын санал дүгнэлтийг сонсох, хэсгийн төлөөлөгч цагдаа нарт өөрийн хариуцсан ажлын чиглэлээр зөвлөгөө өгөх зэрэг үүрэг гүйцэтгэж ирлээ. Баяндалай сумаас эхлэн сум тус бүрт нэг хоног ажилласан бөгөөд 14 цагаас сумдын төрийн болон төрийн бус байгууллагууд, архи согтууруулах ундаа зарж борлуулах эрхтэй дэлгүүрүүдийн эзэд, нийт иргэдийг цуглуулан ажлын хэсгийн зорилго, аймгийн цагдаагийн газраас явуулж буй үйл ажиллагаа, эхний улирлын гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдал, “Архигүй Өмнөговь” хөтөлбөрийн явц үр дүнг танилцуулж Хууль зүйн хэлтсээс сургалт зохион байгуулж, Тахарын алба албаа сурталчлах үйл ажиллагаагаар өндөрлөх гэх мэт хөтөлбөр дарааллаар явуулж ирлээ.

Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлд олон нийтийн цагдаагийн ажилтаны урамшуулал, санхүүгийн асуудлыг тусгуулан шийдвэрлүүлж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 11-р сарын 27-ний өдрийн 202 тоот тогтоолоор 2016 онд 30 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулахаар батлуулан 2016 оны 1-р сард шинээр олон нийтийн цагдаагийн ажилтан болох хүсэлтэй иргэдэд сургалт хийж, 14 хүнийг олон нийтийн цагдаагийн ажилтнаар нэмж томилон ажиллуулсан. 2016 оны 05-р сарын 01-ний өдрөөс олон нийтийн цагдаагийн ажилтны сургалтыг шинээр зохион байгуулан 4 иргэнийг сургалтанд хамруулсан. Одоогоор тус аймгийн Даланзадгад, Ханбогд, Гурвантэс, Цогтцэций сумдад олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллаж байна. 2017 онд тус аймгийн хэмжээнд ажиллах олон нийтийн цагдаагийн ажилтны тоог 30 байхаар тогтоон санхүүжилтийн 196 сая төгрөгийг үндсэн чиглэлд тусгуулан шийдвэрлүүлсэн. 2016 оны 11-р сард олон нийтийн цагдаагийн ажилтны сургалтыг 2

удаа зохион байгуулан ажилласан. 2017 оны 1-р улиралд олон нийтийн цагдаагийн ажилтны сургалтыг дахин зохион байгуулж, дутуу орон тоонд нөхөн хангалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Орон байрны, халаасны, малын, үнэт эдлэлийн, мотоциклийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний шторк, хараа хяналтгүй хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн талаар сэрэмжлүүлэг тус тус видео хэлбэрээр бэлтгэн иргэдэд хүргэж байгаа бөгөөд архины хор хөнөөлийг ойлгуулах зорилготой тараах материал “Иргэнд хүргэх захидал” 500 ширхэг, “Монгол тэмээ-999”, “Баяр, наадам”, ”Говийн бүсийн хурдан морины уралдаан”, “Улсын их хурлын, аймаг нийслэлийн, сум, дүүгийн сонгууль” зэрэг арга хэмжээний хүрээнд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 300 ширхэг санамж хэвлүүлэн тараасан.Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, гэмт хэрэг зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 төрлийн санамжийг сурагчдын хичээлийн хуваарь хэлбэрээр 1000 ширхэгийг, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус бүр 2 зурагт хуудсыг 200 ширхэг аймгийн ГХУСАЗ3-ийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэн тараасан.Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, хууль бус агнуур худалдааны талаар мэдээлэл авах шуурхай утас 97177000 дугаар, аймгийн цагдаагийн газрын иргэдээ сонсох утас 70533321 дугаарыг сурталчилсан наалтыг тус бүр 500 ширхэг хэвлүүлэн олшруулж сумдад хүргүүлсэн.

Даланзадгад сумын банкны салбаруудын төв болон тооцооны салбарууд, ШТС, ломбардуудын удирдлага, ажиллагсад иргэдтэй уулзалт хийж, уулзалтын үеэр “Олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Даланзадгад сум\хот\-ийн ЗДТГ, ГХУСАЗСЗ-тэй хамтран “Иргэний танхим”, “Эрх зүйн сургалт мэдээллийн төв”-ийг байгуулан иргэд олон нийтэд хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хамтран зохион байгуулж байна. Мөн аймгийн “Эрх зүйн туслалцааны төв”, “Иргэдийг хүлээн авах хууль сурталчлах эрх зүйн танхим”-д иргэд олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгаа, эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж ажиллалаа. Мөн сумдын Цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгийн албан байр\кобан\-ны нэг өрөөг хууль, эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх танхим болгож тохижуулан, төрөл бүрийн хууль, эрх зүйн акт, сурталчилгааны материал, гарын авлагаар ханган иргэдэд зөвлөгөө зөвлөмж өгөх, эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулав.

Аймгийн “Эрх зүйн туслалцааны төв”, Даланзадгад сум\хот\-ын “Иргэний танхим”, “Эрх зүйн сургалт мэдээллийн төв”-ийн үйл ажиллагаа, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах тэргүүний бүлэг нөхөрлөл, “Иргэний зөвлөл”, “Өсвөрийн цагдаа бүлэг”-ийн үйл ажиллагаа, арга туршлагыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан иргэд, олон нийтэд тогтмол сурталчлан ажиллалаа.

Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, зохион байгуулж буй ажил, арга хэмжээний явц, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөн, иргэд олон нийтэд гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг сурталчлах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл хүргэх чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж, 7 хоногт 2-оос доошгүй анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээ мэдээлэл боловсруулан олон нийтэд хүргэлээ. Уламжлалт баяр ёслолын өмнө болон тасгийн нэрэмжит сарын ажлыг олон нийтэд сурталчлах, цаг үеийн холбогдолтой мэдээлэл сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр:

“Архидалтгүй Өмнөговь”, “Өмнөговь Цагдаагийн газар” цахим хаягаар дамжуулан иргэдэд архидан согтуурхаас урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл хүргэж байна. Өмнөговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа согтууруулах ундаа зарж борлуулах тусгай зөвшөөрөлтэй цэгүүдийн судалгааг гаргасан бөгөөд одоогоор 273 цэг үүнээс Даланзадгад хотын хэмжээнд 110 цэг байгаа ба тусгай зөвшөөрлөөр зарж борлуулдаг дэлгүүр 68, үйлчилдэг караоке, зоогийн газар, баар цэнгээний газар 32 байна. Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын цугларалтанд 2 удаа архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр, цагдаагийн газрын нийт алба хаагчдад тамхины хяналтын тухай хуулиар сургалт зохион байгуулав.Даланзадгад сумын хэмжээнд байнга архидан согтуурдаг архаг архичдын судалгааг шинээр хийж зурагжуулах, утасны дугаарыг бүртгэх зэрэг баяжилт хийж ажиллав.“Шинэ жил” нэгдсэн арга хэмжээний үр дүнг тооцож тайланг НХЖХГ-т хугацаанд нь явуулав.

Мөн сар бүр архидан согтуурахтай болон тамхины хор хөнөөлтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлаа бичмэл болон хүснэгт мэдээгээр Нийтийн хэв журам хамгаалах газарт хүргүүлж ажиллав.

Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын цугларалтанд 3 удаа архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр, цагдаагийн газрын нийт албаа хаагчдад тамхины хяналтын тухай хуулиар сургалт зохион байгуулав.

Сонгуулийн өдрүүдэд МУ-ийн АСТТХ, болон Засаг даргын захирамжыг хатуу чанд мөрдөж ажиллах талаар тусгай зөвшөөрөл бүхий дэлгүүр аж ахуйн нэгжүүдэд 100 гаруй мэдэгдэл, шаардлага хүргүүлж ажиллав.

Намрын найр наадмын цаг болж буйтай холбогдуулан иргэдийг сэрэмжлүүлэх зорилгоор “Иргэн бүрт илгээх захидал” хэвлүүлэн гаргаж “Архигүй Өмнөговь” хөтөлбөрийн мөнгөнөөс 400.000 төгрөгний асуудлыг шийдвэрлүүлж 500 ширхэг захидал хэвлүүлэн иргэдэд тарааж сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулав.

Орон гэргүй гудамж талбайд архидан согтуурдаг 12 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулсан бөгөөд 2 сард очиж хүлээн авч аймгийн хөдөлмөрийн хэлтэс, хууль зүйн хэлтэстэй хамтран ажлын байраар хангах, төрийн бус байгууллагуудад хариуцуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулав.

1 этгээдийг сайн дурын эмчилгээнд хамруулж эмчилгээний дараа Архичид аминчилахуй нийгэмлэгийн “Говийн наран” бүлэгт хамруулж архинаас гарах арга замаа олоход нь туслах арга хэмжээ авлаа. Хийсэн ажлуудыг Архидалтгүй Өмнөговь цахим хаягт байршуулан иргэдэд мэдээлж байна.

Аймгийн ЗДТГ-ийн Хуульзүйн хэлтэс, БОЭТ-ийн наркалогийн тасаг, Тахарын алба, Хөгжимт жүжгийн театр, “Говийн наран” телевиз зэрэг байгууллагуудтай хамтран “Архигүй хөдөө” нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа. Тус Цагдаагийн газраас“Архигүй Өмнөговь” хөтөлбөрийг сурталчлах, энэ чиглэлээр сумдын салбар зөвлөлүүдийн хийсэн ажлыг шалгах, Хууль зүйн хэлтсээс Авилгын болон хүн худалдаалах гэмт хэргийн талаар сургалт явуулах, Тахарын албанаас албаа сурталчлах, БОЭТ-ийн наркалогын тасгаас архаг архичидтай уулзаж зөвлөгөө өгөх, Хөгжимт жүжгийн театраас хөдөөгийн иргэдэд урлаг уран сайхнаар үйлчлэх гэсэн тус тусын чиглэл зорилготой хөдөөгийн 14 суманд 2016.04.05-2016.04.18-ний өдрүүдэд ажилалаа. Дээрхи арга хэмжээний хүрээнд “Архи тамхигүй орчин” бүрдүүлэх аяны хүрээнд идэвхи санаачлагатай ажиллаж байгаа Даланзадгад сумын ЗДТГ, Цагдаагийн газар, Говийн наран бүлгийн үйл ажиллагааг сурталчлах, туршлага хуваалцах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулав.

Мөн хэсгийн төлөөлөгч нарын ажил байдалтай танилцах, тэдний ажил, иргэд байгууллагын хамтын ажиллагааны талаар сумдын удирдлагын санал дүгнэлтийг сонсох, хэсгийн төлөөлөгч цагдаа нарт өөрийн хариуцсан ажлын чиглэлээр зөвлөгөө өгөх зэрэг үүрэг гүйцэтгэж ирлээ. Баяндалай сумаас эхлэн сум тус бүрт нэг хоног ажилласан бөгөөд 14 цагаас сумдын төрийн болон төрийн бус байгууллагууд, архи согтууруулах ундаа зарж борлуулах эрхтэй дэлгүүрүүдийн эзэд, нийт иргэдийг цуглуулан ажлын хэсгийн зорилго, аймгийн цагдаагийн газраас явуулж буй үйл ажиллагаа, эхний улирлын гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдал, “Архигүй Өмнөговь” хөтөлбөрийн явц үр дүнг танилцуулж Хууль зүйн хэлтсээс сургалт зохион байгуулж, Тахарын алба албаа сурталчлах үйл ажиллагаагаар өндөрлөх гэх мэт хөтөлбөр дарааллаар явуулж ирлээ. Ханбогд суманд улаан бурхан өвчний дэгдэлт их байгаа гэсэн мэдээлэлтэй байсан учир олон нийтийг цуглуулах үйл ажиллагаа явуулаагүй алгасав. Хэсгийн төлөөлөгч цагдаа нартай хамтран ажиллаж байгаа сум бүрийнхээ архи согтууруулах ундаа зарж борлуулах эрхтэй дэлгүүр, үйлчилгээний газруудыг шалгах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох зэрэг үйл ажиллагааг зохион байгуулав. Баяндалай суманд Тамхины хяналтын тухай хууль зөрчиж ажиллаж байсан нэг дэлгүүрийг илрүүлж 50 ш тамхи хураан авч уг дэлгүүрт хариуцлага тооцов. Булган суманд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчин зөвшөөрөлгүй архи худалдаалж байсан 2 дэлгүүрийг илрүүлэн 17 шил архи, 20 ш тамхи хураан авч хуулийн зохих заалтын дагуу арга хэмжээ тооцлоо. Орон гэргүй гудамж талбайд архидан согтуурдаг 12 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулсан бөгөөд 2 сард очиж хүлээн авч аймгийн хөдөлмөрийн хэлтэс, хууль зүйн хэлтэстэй хамтран ажлын байраар хангах, төрийн бус байгууллагуудад хариуцуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулав.

15 этгээдийг сайн дурын эмчилгээнд хамруулж эмчилгээний дараа Архичид аминчилахуй нийгэмлэгийн “Говийн наран” бүлэгт хамруулж архинаас гарах арга замаа олоход нь туслах арга хэмжээ авлаа.

"Архигүй Өмнөговь" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 30 сая төгрөг тусгуулсанаас иргэдэд сургалт сурталчилгаа зохион байгуулах, архины хамааралтай иргэдийг албадан эмчилгээнд хамруулах зардлыг шийдвэрлүүлэн ажиллаж байна.

Архигүй орчин бүрдүүлж чадсан, идэвх, санаалчлага гаргасан байгууллага, хамт олныг жилийн эцэст шалгаруулж урамшуулах зардлыг "Архигүй Өмнөговь" хөтөлбөрийн санхүүжилтээс шийдвэрлэн Даланзадгад сумын ЗДТГ, Гүний ус ХХК-ийн хамт олныг шалгаруулан Талархал, мөнгөн шагналаар шагнасан. Мөн сонгуулийн үеэр архи, согтууруулах ундаа зарж борлуулахгүй байх талаар аймгийн засаг даргын захирамж гаргуулан 110 дэлгүүр, зоогийн газар, баар караоке тарааж урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авлаа.

Аймгийн Хууль зүйн хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Архидан согтуурал, мансуурал, донтолтоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан ажилласаны зэрэгцээ тус Цагдаагийн газраас хөтөлбөрийн хүрээнд хийх ажлын саналаа хүргүүлэв.

Аймгийн ЗДТГ-ын Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зөвлөлийн гишүүнээр сонгогдож 3 удаагийн хуралдаанд оролцож 7 аж ахуйн нэгжид шинээр зөвшөөрөл олгох, 1 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлах, 3 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх санал гаргаж ажиллав.Цагдаагийн газрын даргын өгсөн үүргийн дагуу Цогтцэций сумаас Гашуунсухайтын боомт хүртэлх нүүрсний зам дагуу нөхцөл байдлыг судлах, гарч буй гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцлийг тодруулах зорилгоор “Нүүрсний замын нөхцөл байдал” тусгай арга хэмжээний төлөвлөгөө гарган 2016.11.24-нөөс 2016.11.25-ны өдрүүдэд ажиллаж Цогтцэций сумаас Гашуунсухайт хилийн боомт хүртэл 800 гаруй км явж, нүүрсний зам дагуух хүндрэл бэрхшээлийг тодруулахаар нийт 14 хүнээс ярилцлага авч 2 цаг орчим хугацааны бичлэг хийж 50 кадр зураг авч нөхцөл байдлыг баримтжуулж ажиллав.

АА-ын “Говийн наран” бүлгийн зохицуулагч Дашцэрэн, Алтанмандах нараар 7 хоног бүрийн 5 дахь өдөр шүүхээр 7-30 хоногоор баривчлагдсан 60 гаруй этгээдүүдэд архины эсрэг яриа таниулга, ухуулга сурталчилгаа хийлгэв.

Согтууруулах ундаа зарж борлуулах эрх бүхий аж ахуйн нэгжүүдийг бүртгэлд бүрэн хамруулах зорилгоор шинээр судалгаа явуулж улсын нэгдсэн санд 12 аж ахуйн нэгж, 40 архаг архичинг шивж бүртгэлд хамруулав.

Согтууруулах ундаа зарж борлуулах эрх бүхий 35 аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл сунгах тодорхойлолт хийж өгсөн байна.

Өмнөговь аймгийн Цагдаагийн газраас улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Архи тамхигүй ирээдүй” тусгай арга хэмжээний хүрээнд тусгай төлөвлөгөө гарган 2016.05.14-нөөс 2016.05.23-ны өдөр хүртэл доорхи ажлуудыг зохион байгуулав.

Удирдамжийг хөдөөгийн 14 суманд хүргүүлж дээрх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах талаар үүрэг чиглэл өглөө.

Даланзадгад сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа архи тамхи зарж борлуулах тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд үзлэг шалгалт явуулснаар “Этүгэн” дэлгүүр насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдан борлуулсан зөрчил илэрч 150.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох асуудлыг таслан зогсоох чиглэлд хүч тавьж ажилласнаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 13 зөрчил илрүүлж 8 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг тус бүр 2 жилээр хасч 4,348,000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна.

Мөн 21 насанд хүрээгүй этгээд согтууруулах ундаа хэрэглэсэн 11 зөрчил илрүүлж нийт 195.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авлаа.

Согтуугаар ахуйн хүрээнд танхайрсан 12 этгээдийг 60.0 төгрөгөөр торгож арга хэмжээ авчээ.

Даланзадгад сумын Ерөнхий боловсролын 1-4-р дунд сургуулийн 8-12-р ангийн 1500 хүүхдийг хамруулан согтууруулах ундааны хор уршгийг сурталчлах зорилгоор “Нэг л алдвал” тусгай арга хэмжээний хүрээнд “Нар жаргасны дараа” видео зохиомжийг үзүүлж хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллав.

Аймгийн төвөөс 25 км-т орших Ханхонгор суманд очиж хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран “Хүүхэд ба хууль” дэвжээ тэмцээнийг зохион байгуулж, АСТТХ, ТХХТХ-иудыг сурталчлах ажил зохион байгууллаа.

Дүн шинжилгээ мэдээллийн ахлах байцаагчтай хамтран согтууруулах ундаа хэрэглэсэнтэй холбогдуулан гэмт хэрэг, зөрчилд холбогдсон насанд хүрээгүй хүмүүс, оюутан залуучуудын судалгааг гаргаж алба хаагчдад танилцуулав. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох асуудлыг таслан зогсоох чиглэлд хүч тавьж ажилласнаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 13 зөрчил илрүүлж 8 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг тус бүр 2 жилээр хасч 4,348,000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна.

Мөн 21 насанд хүрээгүй этгээд согтууруулах ундаа хэрэглэсэн 11 зөрчил илрүүлж нийт 195.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авлаа.

Согтуугаар ахуйн хүрээнд танхайрсан 12 этгээдийг 60.0 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

Хорих болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн хүмүүст тавих захиргааны хяналтын талаар:

Цагдаагийн газрын олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч А.Төмөрмөнх захиргааны хяналтыг биечлэн тавьж байгаа хэсгийн төлөөлөгч, байцаагч нарт зааварчилгаа өгч, аймгийн туслах прокурор О.Батнасан хэсгийн байцаагч нарт Улсын Ерөнхий Прокурор, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын хамтарсан 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05, А/09 тоот тушаалаар батлагдсан “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”-аар сургалт зохион байгуулав. 2016 оны 02 дугаар сарын хэсгийн төлөөлөгч нарын ээлжит цугларалтын үеэр Улсын Ерөнхий Прокурор, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын хамтарсан 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05, А/09 тоот тушаалаар батлагдсан “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”-аар сургалт зохион байгуулсан. Мөн ХААН банкны дотоод сүлжээг ашиглан сумдын хэсгийн төлөөлөгч нарт дээрх журам болон зааварчилгааг судлуулахаар хүргүүлсэн. Туслах прокурор О.Батнасангийн хамтаар хэсгийн байцаагч нарын сар бүрийн ээлжит цугларалтаар хувийн хэргийг татаж хянадаг, сургалт явуулж, зөвлөгөө өгдөг ажлыг хэвшүүлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн захиргааны хяналтанд байгаа иргэдийн дунд хууль сурталчлан таниулах, дахин гэмт хэрэг зөрчил үйлдүүлэхгүй байх зорилгоор Даланзадгад сумын ГХУСАЗСЗ-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хамтран “Итгэл-Зүтгэл” уулзалт өдөрлөг, сургалтын арга хэмжээг улирал бүрт зохион байгуулж байна.

2016 оны 02-р сарын 02-ны өдөр "Итгэл-зүтгэл" уулзалт өдөрлөгийг зохион байгуулж, захиргааны хяналтанд иргэдийг хамруулж, Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч А.Төмөрмөнх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Б.Оюунчимэг нар сургалт зохион байгуулж, хэсгийн байцаагч нар хяналтанд байгаа хүнээс сар шинийн баярын өдрүүдэд захиргааны зөрчил гаргахгүй байх талаар баталгаа гаргуулан авч, хувийн хэрэгт тэмдэглэл хөтөлж, шүүхийн шинжилгээний албанд генетик мэдэллийн нэгдсэн санд хамруулах ажлыг зохион байгуулсан. Хэсгийн төлөөлөгч нарын сар бүрийн ээлжит цугларалтаар хувийн хэргийг татаж хянадаг ажлыг зохион байгуулж хэвшсэн бөгөөд 2016 оны 03-р сарын цугларалтаар туслах прокурор О.Батнасан шинэчилэн батлагдсан журмаар сургалт зохион байгуулсан. 2016 оны 02-р сарын 23-ны өдөр прокурорын газар, цагдаагийн газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Даланзадгад сумын ЗДТГ-ын захирагчийн ажлын алба хамтарсан хорихоос өөр төрлийн ялын биелэлт, гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2016 оны 11-р сарын 11-ны өдөр аймгийн нутгийн удирдлагын ордоны Сүлд танхимд захиргааны хяналтанд байгаа болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гадуур шалгагдаж байгаа 77 хүнийг хамруулан “Итгэл-Зүтгэл” уулзалт, өдөрлөг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Х.Сугир, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа П.Оростогоо, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дэд дарга Ц.Сувдмаа, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Золжаргал нар урилгаар оролцлоо.

Цагдаагийн байгууллагын бичсэн шаардлага, мэдэгдлийн талаар:

Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэгтэй тэмцэх албаны дарга, туслах комиссар Д.Батсайханы 2016 оны 01-р сарын 15-ны өдрийн 5/205 дугаартай үүрэг, ажлын чиглэл хүргүүлэх тухай албан бичгийг хүлээн авч, тус аймгийн Цагдаагийн газраас үүргийн хэрэгжилтийг хангах, 2015 оны 12-р сарын 30-ний өдөр аймгийн банк, санхүүгийн байгууллага, шатахуун түгээх станцад өгсөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохин байгуулах тухай 99, 101 дугаартай албан мэдэгдлийн хариуг газар дээр нь шалгах зорилгоор “Шалган зааварчилгаа-1” хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулж, 2016 оны 01-р сарын 21-ний өдрөөс 01-р сарын 28-ний өдрийн хугацаанд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг банк, шатахуун түгээх станц, ломбардуудыг хамруулан шалган зааварчлах, албан мэдэгдлийн хариуг газар дээр нь шалгах ажлыг зохион байгууллаа. Шалгалт эхлэхийн өмнө Монгол банкны Өмнөговь аймаг дахь салбарын захиралд банкны салбаруудад гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх зорилготой шалган зааварчлах арга хэмжээ зохион байгуулах гэж байгааг мэдэгдэн хамтран ажиллах санал хүргүүлэхэд тус банкны ажилтан нар хоёр банкинд иж бүрэн шалгалт төлөвлөгөөний дагуу явуулж байгаа тул хүн хүчний хүрэлцээ байхгүй талаар мэдэгдсэн. Арга хэмжээний хүрээнд ХААН банкны дотоод сүлжээг ашиглан төлөвлөгөө, зааварчилгааг сум дундын цагдаагийн хэлтэс, тасаг, сумдын хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж, хийгдсэн ажлын танилцуулгыг нэгтгэн хүлээн авч ажиллалаа.

Даланзадгад сумын төвд үйл ажиллагаа явуулдаг банк, шатахуун түгээх станц, ломбардуудын аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чигэлээр хэрэгжүүлж байгаа ажилтай танилцах зорилготой тус цагдаагийн газрын ЭЦТ, НХЖХТ-ийн албаа хаагчдаас бүрдсэн 3 ажлын хэсэг гарган ажиллав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд шалгалтын зорилго, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх аргачлалын талаар олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч А.Төмөрмөнх зааварчилгаа өгч, удирдан ажиллав. Банкны дотоод нууцлал, үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлтэй танилцах, шаардах үйл ажиллагааг явуулахгүй, гадна орчны хамгаалалт, гэрэлтүүлэг, хяналтын болон дохиоллын системийн хэвийн ажиллагаа, банкны зузаатгал, АТМ цэнэглэх ажлын аюулгүй байдал, гэрээт хамгаалагч нарын үйл ажиллагаа, зэвсэг, техник, тусгай хэрэгсэл, ур чадвар зэрэг нь шаардлагын төвшинд хүрч байгаа эсэхэд шалгалт хийж, зааварчилгаа өгөх, албан мэдэгдлээр зөрчилийг арилгуулах арга хэмжээ авахуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон цаг үеийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар яриа таниулга хийх ажлыг зохион байгууллаа. Улсын болон аймаг орон нутгийн чанартай баяр ёслол, нийтийг хамарсан арга хэмжээнүүдийн үед үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн онц чухал обьектууд, банк, ШТС-ийн салбарууд, сургууль, цэцэрлэгүүдэд албан мэдэгдэл тогтмол хүргүүлж, хариуг авч, биелэлт тооцон ажилласан бөгөөд 2016 онд давхардсан тоогоор нийт 560 аж ахуйн нэгж байгууллагад албан мэдэгдэл өгч, хариуг авч ажилласан.

Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсан байдлын талаар:

Засгийн газрын 2013,12,14-ний өдрийн 410 дугаар тогтоолоор баталсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2016 оны 2-р, 5, 10-р саруудад тус бүр нэг удаа аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжилзүйн газартай хамтран “Цахим тоглоом, “Тоглоомын газар” зэрэг нэртэй арга хэмжээнүүдийг нийт 3 удаа зохион байгуулж, интернет төв болон цахим тоглоомын газруудад 410 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж ажилласан. Дээрх шалгалтуудаар Даланзадгад сумын Дундсайхан хороололд зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан “Үйлс”, “Өнөрбаян” нэртэй 2 тоглоомын газрыг илрүүлэн үйл ажиллагааг нь зогсоож, ЗХТХ-д заасны дагуу 20,000 төгрөгний торгууль, ажиллах цагийн хуваарь хэтрүүлэн ажилласан нэртэй нэг тоглоомын газрыг илрүүлж, ЗХТХ-ийн 42,2-д заасны дагуу захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, үйл ажиллагааг нь зогсоолоо.

Мөн ажиллах цагийн хуваарь хэтрүүлэн ажиллаж байсан “Sonic”, “Кибер” нэртэй цахим тоглоомын газруудад ЗХТХ-д заасны дагуу тус бүр 8,000 төгрөгний торгуулийн арга хэмжээг тус тус оногдуулан ажиллалаа. Одоо тус аймгийн төвд дээрх журмын дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан 8 цахим тоглоомын газар, 1 интернеткафе зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байна . Засгийн газрын дээрх журмыг хэрэгжүүлж ажиллахын тулд тус Цагдаагийн газар нь шинээр нээгдэж үйл ажиллагаа явуулах саналтай цахим тоглоомын газарт аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газраас гаргасан байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороонд албан бичгээр санал хүргүүлэн, зохих зөвшөөрлийн гэрчилгээ авсан газруудыг бүртгэл судалгаанд хамруулан өдөр бүр эргүүлийн чиглэлд оруулан хяналт тавин ажиллаж байна.

Хяналт шалгалтын арга хэмжээний үйл явцыг фото зургаар баримтжуулан Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын фэйсбүүк хаягаар сурталчилсан болно.

Ар гэртээ агсан тавьсан иргэдийн дуудлага мэдээлэлд “Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг шийдвэрлэх богино хугацааны нөхцөл байдлын үнэлгээг хийж, хохирогчид болон хүчирхийлэл үйлдэгчид ГБХТТ хуулийн “эрх хязгаарлах арга хэмжээ”-г тайлбарлан өгч, хохирогчид танилцуулсан тэмдэглэл хөтлөн ажиллалаа. Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай

удирдлагын албаны офицеруудад гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн богино хугацааны үнэлгээг хийх аргачлалыг зааварчилж албан бичгээр танилцуулж ажилласан. Хэсгийн төлөөлөгч нарт гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт хандлагыг сайжруулах сургалт зохион байгуулсан.

Тус Цагдаагийн газарт 2016 онд 1363 дуудлага мэдээлэл хүлээн авснаас ар гэртээ агсан тавьж АСББ-нд саатуулагдсан 58 хүнийг шалгаж шийдвэрлэн ажиласан

Мөн аймаг сумдын нийт багуудад гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хамтарсан багийг шинэчлэн байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн талаар эрсдлийн үнэлгээ гаргах, дуудлага мэдээлэл, ирсэн кейст хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулан зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас нярай хүүхдээ алахыг завдсан 16 настай Хонгорзулын асуудлыг харъяа сумын Засаг дарга, аймгийн ХГБХХ-т албан бичгээр мэдэгдэн, хамтарсан багийг ажиллуулан, шаардлагатай ажил арга хэмжээг хамтран зохион байгуулсны дүнд Хонгорзулыг тусдаа өрийн гэсэн гэртэй болгон, хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн 1 хохирогчийг хамгаалах байранд байлгаж, ар гэрийнхэнд нь хүлээлгэн өгсөн.

Шүүхээр эрх хязгаарлуулах хүсэлт гаргасан 3 хохирогчийн хүсэлтийг ханган шийдвэрлэж, хохирогчийг ар гэрийнхнийг нь хамгаалалтанд өгч ажилласан

Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг идэвхтэй ашиглах зорилгоор хэсгийн төлөөлөгч нарын цугларалтын үеэр 2 удаа “ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд цагдаагийн ажилтны үүрэг” сэдвээр сургалт зохион байгуулан ажиллалаа.

ГБХТТХ-иар 3 иргэнд эрх хязгаарлах арга хэмжээг шүүхээр оногдуулан дахин хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлж, хяналт тавин ажиллаж байна.

Мөн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч нарт ГБХТТ хуульд заасан “Эрх хязгаарлах арга хэмжээ”-г танилцуулсан бланк бэлтгэж, ар гэртээ агсан тавьсан дуудлагаар ирсэн хүмүүсийн ар гэрийхэнд танилцуулан ажиллаж байна.

Тус Цагдаагийн газраас аймгийн Засаг дарга, ИТХ-д удаа дараа санал тавьсны үр дүнд 2016 оны 4-р сард “Хохирогч хамгаалах түр байр”-ны асуудал шийдэгдсэн бөгөөд “Хамгаалах байр”-ны ажиллах журмыг аймгийн ГХУСАЗЗ-өөр хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 3 төрлийн зурагт хуудас, санамж бэлтгэн, уг зурагт хуудас, санамжин дээр Цагдаагийн газрын жижүүрийн 7053102, 70533221 дугаарын утсыг нийтэд хүртээмжтэй болгох зорилгоор нийтлэн тараан ажиллаж, дээрх дугаарын утсаар 24 цагийн туршид гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авч ажиллаж байна.

Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн 70532205 дугаарын утсыг гэр бүл, хүүхэд хамгааллын асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх утас болгон ажлын цагаар мэдээлэл хүлээн авч, харилцан мэдээлэл солилцон ажиллаж байна.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг сурталчилах, хүчирхийлэл үйлдэгчид авах “Эрх хязгаарлах арга хэмжээ”-г сурталчилах, олон нийтэд тайлбарлан таниулах зорилгоор аймгийн “Алтан говь” телевизтэй хамтран нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд хүргэсэн.

Мөн Гэр бүлийн хүчирхийллийн талаарх цаг үеийн нөхцөл байдлын мэдээг орон нутгийн радио телевизтэй хамтран сар бүр мэдээлэл болгон нэвтрүүлэн ажиллаж байна.

Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 2 төрлийн зурагт хуудас, 1 төрлийн санамж бэлтгэн тараан ажиллаж байна.

2 төрлийн зурагт хуудас хэвлүүлэх асуудлыг аймгийн ГХУСАЗЗ-ийн 2016 оны төсөвт тусгуулсны дүнд А3 хэмжээтэй өнгөт хэвлэлийг 500 ширхэг хэвлүүлэн тараан ажилласан.

Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран ГБХТТХ-д заасны дагуу хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр боловсруулан 2 байгууллагын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн аймгийн Залуучууд хөгжлийн төвтэй хамтран албан бус тухайлбал ”Гэр бүл дэх харилцаа”, “Эрэгтэйчүүдийн эрхэм чанар”, “Эмэгтэйчүүдийн эрхэм чанар”, “Архинаас гарахаар шийдсэн бол”, “Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэл, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд”, “Шийдвэр гаргалт” “Архи уудаг хүний хүүхэд” зэрэг 40 модуль сургалтуудыг 41 байгууллагатай хамтран 6000 гаруй хүүхэд, 3600 гаруй иргэдэд 76 удаагийн сургалт зохион байгуулсан байна.

Мөн ГБХТТХ-ийг хэрэгжүүлэх субьектуудэд эрх зүйн мэдлэг олгох зорилгоор аймаг, сумдын нийт багийн засаг дарга, нийгмийн ажилтнуудад тус бүр 1 удаа сургалт зохион байгууллаа.

“Амжилт азжаргалын нууц” ТББ-тай хамтран Цагдаагийн газрын АСББ-нд баривчлагдсан иргэдэд 5 дахь өдөр болгон зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулж байна. Захиргааны

хяналтанд байдаг болон согтуурах донтой иргэдийг нийгэмшүүлэх зорилгоор зохион байгуулсан “Итгэл зүтгэл” арга хэмжээнд ГБХ-ийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх сургалтыг 70 гаруй иргэдэд зохион байгуулсан.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг сурталчилах, хүчирхийлэл үйлдэгчид авах “Эрх хязгаарлах арга хэмжээ”-г сурталчилах, олон нийтэд тайлбарлан таниулах зорилгоор аймгийн “Алтан говь” телевизтэй хамтран нэвтрүүлэг бэлтгэн, нэвтрүүлгийг улиралд 1 удаа нэвтрүүлэн ажилласан.

Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 2 төрлийн зурагт хуудас, 1 төрлийн санамж бэлтгэн тараан ажиллаж байна.

2 төрлийн зурагт хуудас хэвлүүлэх асуудлыг аймгийн ГХУСАЗ-ийн 2016 оны төсөвт тусгуулсны дүнд А3 хэмжээтэй өнгөт хэвлэлийг 500 ширхэг хэвлүүлэн тараан ажиллаж байна.

Мөн аймгийн ГХУСАЗ-ийн 2016 оны төлөвлөгөөнд оруулсны дагуу аймгийн ХГБХХ-тэй хамтран гэр бүлийн талаарх иргэдийн ойлголт, хандлага, ухамсрыг сайжруулах, тогтвортой гэр бүлийг сурталчилах зорилгоор 2 дахь жилдээ “Азжаргалтай гэр бүл” нэвтрүүлгийг аймгийн “Алтанговь” телевизтэй хамтран зохион байгуулж байгаа бөгөөд 2016 онд 12 нэвтрүүлгийн бэлтгэн иргэдэд хүргэсэн байна.

Тус аймагт хэрэгжиж байгаа “Архидалтгүй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд “Архигүй хөдөө” арга хэмжээг 14 суманд зохион байгуулан, хууль тогтоомжийг сурталчилах ажлыг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээний хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх сургалтуудыг зохион байгуулан ажилласан бөгөөд уг арга хэмжээнд хөдөөгийн 14 сумын 1800 гаруй иргэд хамрагдсан байна.

Амжилт азжаргалын нууц” ТББ-тай хамтран Цагдаагийн газрын АСББ-нд баривчлагдсан иргэдэд 5 дахь өдөр болгон зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулж байна. Захиргааны хяналтанд байдаг болон согтуурах донтой иргэдийг нийгэмшүүлэх зорилгоор зохион байгуулсан “Итгэл зүтгэл” арга хэмжээнд ГБХ-ийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх сургалтыг 70 гаруй иргэдэд зохион байгуулсан.

Зөвшөөрлийн системийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байдал

-Галт зэвсгийн бүртгэл, гэрчилгээжүүлэлт, түүнд тавих хяналт, хураагдсан галт зэвсгийн шийдвэрлэлт:

МУ-ын “Галт зэвсгийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 503 тоот тушаалаар батлагдсан “Галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээ олгох журам” /код-602/, галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, эрэн сурвалжлагдаж байгаа алдагдсан, олдож ирсэн галт зэвсгийн судалгааг шинэчлэх, галт зэвсэг, сумны хууль бус наймааг таслан зогсоох, нуугдмал бүртгэлд хамрагдаагүй галт зэвсгийг илрүүлэх, галт зэвсгийн тооллого явуулж бүртгэлд хамрагдаагүй галт зэвсгийг илрүүлж гэрчилгээжүүлэх ажлыг ханган биелүүлэх зорилгоор дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Улмын хэмжээнд зохион байгуулагдсан “Зэвэг 2016” нэгдсэн арга хэмжээний хүрээнд салбар төлөвлөгөө болвсруулан, сумдад ажлын чиглэлийн хамт хүргүүлж, арга хэмжээг зохион байгуулах мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, галт зэвсгүүдийг нүд үзэн тоолж, гэрэл зурагжуулан ажилласан ба аймгийн хэмжээнд бүртгэлтэй 1098 галт зэвсэг байгаа бөгөөд “Зэвсэг 2016” арга хэмжээний хүрээнд Цагдаагийн байгууллагын мэдээлийн санд 1045 галт зэвсгийн мэдээллийг шивж оруулаад байна.

- Гэрээт харуул хамгаалалтад тавьж байгаа хяналт шалгалт

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 503 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын код 605-д заасан журмын хэрэгжилтийг ханган биелүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт гэрээт харуулын үйл ажиллагаа эрхэлж буй Гурван тэс сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Монгол алт /МАК/” ХХК, “Саусгоби сэндс” ХХК, Мандал-Овоо сумын нутаг дэвсгэрт үйл ажиллага эрхэлж буй “Монгол газар” ХХК, Цогтцэций сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй “Таван толгой транс”, “Энержи ресурс”, Даланзадгад сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Тэнгэрийн мэлмий” ХХК-уудад гэрээт, харуул хамгаалалт эрхэлж буй аж ахуй нэгжийн судалгааг шинэчилэн.

--Тэсэрч дэлбэрэх бодис, хүчтэй үйлчлэх химийн болон цацраг идэвхит бодис техник хэрэгслийн бүртгэл, түүнд тавих хяналт

Тус аймгийн нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй “МИРА” ХХК-ны Таван толгой салбар, “БЛАСТ” ХХК-ны Таван толгой салбар, “BMG” ХХК, “Спейшл майнинг сервис” ХХК-ны тэсэрч дэлбэрэх бодисын гэрээт үйлдвэр агуулах, гэрээт харуул хамгаалалтын “MCS-армор” ХХК, “Бамбай СС” ХХК-ний “Эрдэнэс таван толгой” салбар, “Хөдөлгөөнт бай” ХХК, “Геомандал секьюрити” ХХК, “Бумбат зүрх” ХХК, “Мянган дуут” ХХК, “Баатар ван” ХХК”, “Очир”, “Илд бамбай сервис”, “MPSS”, “Эрчим”, “Ийгль”, “Секум”, “Зэвс”, “Хос харцага” зэрэг харуул хамгаалалтын албад, “ХААН”, “Хас”, “Голомт”, “Капитал”, “Капитрон”, төрийн банкны салбар тооцооны төв, “Петровис”, “Шунхлай”, “МТ”, “Сод Монгол”, “Жаст-ойл” ХХК-ний салбар ШТС-ууд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд хяналт тавин ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан ба энэ үеэр хураагдсан насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа зарж борлуулсан “Хишиг буян” дэлгүүр болон гар дээрээс зөвшөөрөлгүй худалдан борлуулж байсан 1 иргэнийг илрүүлэн 35 литр шимийн архийг хураан авч холбогдох этгээдүүдэд хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авлаа.

Монгол Улсын их хурлын сонгуультай холбогдуулан “Хяналт” тусгай арга хэмжээг зохион байгуулж 65 дэлгүүр аж ахуйн нэгжийг шалгав.

Хөдөө сумдад хууль зөрчиж ажилласан 3 дэлгүүрийг хэсгийн төлөөлөгчөөр шалгуулж 700.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ тооцуулж санд бүртгэж оруулав.

Шөнийн цагаар хууль бусаар архи, согтууруулах ундаа зардаг зөрчлийг илрүүлэх зорилгоор “Шөнийн дэлгүүр” тусгай арга хэмжээг тасгийн бие бүрэлдэхүүний хүчээр зохион байгуулав.

Согтууруулах ундаа хууль бусаар зарж борлуулсан “Андууд” “Хишиг буян” дэлгүүрүүдийг 400.000 төгрөгөөр, гар дээрээс хууль бусаар согтууруулах ундаа зарж борлуулж байсан Төртүвшин, Б.Цогбаяр, П.Отгонцэцэг нарыг илрүүлж 33 шил архи, 13 шил хятад пиво хураан авч нийт 130.000 төгрөгөөр торгож арга хэмжээ тооцов.

Согтууруулах ундаа хууль бусаар зарж борлуулсан айлуудад үзлэг хийж Мөнхбаяр гэгчээс 124,25 литр 39 ш тамхи, Цагаан хадан дахь “Баян хангай” дэлгүүрээс 12 ш архи, 15 пиво 150 хайрцаг тамхи хураан авч Даланзадгад сумын Засаг даргын дэргэдэх Захиргааны зөвлөлийн устгалын комисст шилжүүлэв.

Булган суманд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчин зөвшөөрөлгүй архи худалдаалж байсан 2 дэлгүүрийг илрүүлэн 17 шил архи, 20 ш тамхи хураан авч хуулийн зохих заалтын дагуу арга хэмжээ тооцлоо.

Нийт хууль бусаар зарж борлуулж байсан 99.35 л архи, 225.6 л пиво, 209 хайрцаг тамхи хураан авч Даланзадгад сумын Засаг даргын дэргэдэх Захиргааны зөвлөлийн устгалын комисст устгуулахаар хүлээлгэн өглөө.

Даланзадгад сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа архи тамхи зарж борлуулах тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд үзлэг шалгалт явуулснаар “Этүгэн” дэлгүүр насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдан борлуулсан зөрчил илэрч 150.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

Захиргааны журмаар хураасан эд зүйлийн талаар:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан ба энэ үеэр хураагдсан насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа зарж борлуулсан “Хишиг буян” дэлгүүр болон гар дээрээс зөвшөөрөлгүй худалдан борлуулж байсан 1 иргэнийг илрүүлэн 35 литр шимийн архийг хураан авч холбогдох этгээдүүдэд хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авлаа.

<u>Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагааны талаар:</u>

Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, гэмт хэрэг зөрчилийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагын мэдээллийн санд оруулан 2016 онд жижүүрийн шуурхай албанд нь нийт 1197 дуудлага мэдээлэл хүлээн авсан ба үүнээс гэмт хэргийн шинжтэй 570, сум орон нутгийн Цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгээс 157 өргөдөл гомдол хүлээн авч рапортанд тусган, эрх зүйн зөрлийн 548 дуудлага мэдээлэл хүлээн авч ажилласан байна. Эрх зүйн зөрчлийн 548 дуудлагаас гудамж талбай, олон нийтийн газар, ахуйн хүрээнд бусдын амгалан тайван байдал алдагдуулж, жижгээр танхайрч, хэрүүл маргаан хийсэн 432 хүнийг Цагдаагийн газрын Албадан саатуулах байранд тогтоол тэмдэглэл үйлдэн, хүнийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэн ар гэр, өмгөөлөгч болон аймгийн сум дундын анхан шатны эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчид мэдэгдэн саатуулж ажилласан байна. Эрх зүйн зөрчлийн 57 дуудлагыг газар дээр нь зохицуулан, хуулийн зөвөлгөө өгч, 88 хүнийг ар гэр, асран хамгаалагч нарт нь хүлээлгэн өгсөн ба 8 дуудлага худлаа байсан тул хариуцлага тооцсон болно. Жижүүрийн офицерууд нь үүрэг гүйцэтгэх хугацаандаа дуудлагаар саатуулагдсан хүмүүст захиргааны арга хэмжээ авч шийдвэрлэн ажиллаж байгаа ба мөн жижүүртэй байх хугацаанд бүртгэгдсэн харъяаллын гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж шалгаж байна.

Жижүүрийн шуурхай албанд үүрэг гүйцэтгэх хугацаанд үйлдэгдсэн онц хүнд, гэмт хэргийн талаарх, мэдээг Цагдаагийн Газрын дарга болон тасгийн дарга нарт, ЦЕГазрын Шуурхай удирдлагын штаб, Мэдээлэл Шуурхай удирдлагын төвийн ерөнхий зохицуулагчид хэргийн талаар танилцуулан үүрэг чиглэл авч, гэмт хэргийн газар ажиллах бүрэлдэхүүнийг түргэн шуурхай явуулах, тасаг албадтай ажлын уялдаа холбоотой ажиллан, гарсан гэмт хэргийг илрүүлэх, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан сум орон нутгийн Цагдаагийн хэлтэс, тасаг, хэсэгт болон хил залгаа аймаг, сумдын Цагдаагийн газар, хэлтэс, тасаг, хэсэгт зарлан мэдэгдэх, бүслэн хаах, мэдээлэл солилцон ажиллаж Цагдаагийн газрын дарга, удирдлагуудад танилцуулан мэдээллээр ханган ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчил гарсан газар цаг хугацаа алдалгүй ажлын шуурхай байдлыг ханган хэрэг, зөрчил гарсан газар орчимд цагдаагийн хөдөлгөөнт болон тухайн чиглэлд эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийг ажиллуулан, Олон нийтийн цагдаагийн ажилтан нарыг үүрэгжүүлэн, хэргийн газрыг хамгаалалтанд авах гэмт хэрэг зөрчлийн талаар хойшлуулшгүй ажиллагаа явуулах болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох баривчлах саатуулах, алдагдсан эд зүйлийг эрэн сурвалжлах, бусад орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, тасаг, хэсэгт түргэн шуурхай мэдээлэл өгч удирдлагыг мэдээллээр хангах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тус аймгийн нутагт гар аргаар хууль бусаар алт болон бусад төрлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд тавигдаж байгаа хяналт, хамгаалалтын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж хамгаалалтанд ажиллаж байгаа алба хаагч нарын мэдээг хүлээн авч хоногийн рапортонд тусган, анхаарал татсан, онцлог мэдээллийг цаг тухай бүрт нь ЦГ-н дарга, удирдлагуудад мэдэгдэн арга хэмжээ авч ажиллаж байна.

Цагдаагийн Газрын аюулгүй байдлыг ханган дотоод дэг журмыг сахиулах, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, баривчлах, албадан саатуулах байрны дотоод дэглэм журмыг тогтмол сахиулж, үүрэг гүйцэтгэж байгаа албаа хаагчийн аюулгүй байдалд хяналт тавин, үүрэг чиглэл өгөх, мэргэжлийн удирдлагаар ханган утас станц, теле камераар байнгын хяналт тавих ажлыг зохион байгуулж, байгууллагын албан конторын гадна доторх эд аж ахуй, байгууллагын автомашины парк ашиглалт, галт зэвсэг буу, сум, нэг бүрийн тусгай хэрэгсэлүүд, нөхцөл байдлын мэдээ, алба хаагчдын түлхүүр тавилтын бүртгэл хөтлөн хүлээлцэн тасгийн даргаар хянуулж гарын үсэг зуруулан ажиллаж байна.

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүний хүч хэрэгсэлийн тооцоог гаргах, төлөвлөгөөний тодотголыг улиралд нэгээс доошгүй удаа хийж бие бүрэлдэхүүнд танилцуулан гарын үсгээр баталгаажуулан авч, алба хаагч нарын гэрийн хаяг, холбоо барих утас, цагдаагийн газрын харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгсэл, албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, автомашины ашиглалтын бэлэн байдал, техник хэрэгсэлд тодотгол хийж төлөвлөгөөнд хавсарган бие бүрэлдэхүүнд нэгээс хоёр удаа ЦБҮАЖ-415 кодоор сургалт зохион байгуулан ажилласан байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн болон насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн талаар:

2016 оны эхний улиралд насанд хүрээгүй хүмүүсээс 2 гэмт хэрэг үйлдэгдэж, 3 хүүхэд холбогдон шалгагдсаныг урьд оны мөн үетэй харьцуулбал гэмт хэрэг 6-аар буюу 75 хувиар, холбогдогч хүүхдүүдийн тоо 12-аар буюу мөн 80 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний хагас жилд насанд хүрээгүй согтууруулах ундаа хэрэглэсэн 13 хүүхдэд захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, АСТТХ-ийн дагуу арга хэмжээ оногдуулж ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2 дахин их байна.

2016 оны эхний хагас жилд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 15 гарсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2-өөр буюу 11,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн 2015 онд болон 2016 оны эхний хагас жилд хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эрх ашиг хохироосон гэмт хэргийн судалгааг нарийвчлан хийж, графикаар харуулан сургалт, мэдээлэл хийхэд ашиглан ажиллаж байна.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн судалгааг гаргаж, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, сургалт мэдээлэлд тогтмол ашиглан ажиллаж байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газруудын судалгааг шинэчлэн гаргасан.

Насанд хүрээгүй согтууруулах ундаа хэрэглэсэн 13, гэмт хэрэгт холбогдсон 3, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээгээр шийтгүүлсэн 3, эрх хязгаарлуулах арга хэмжээ авагдсан 1 хүнийг, Даланзадгад суманд үйл ажиллагаа явулж байгаа шашны 16 сүм хийдийг бүртгэл судалгаанд хамруулсан.

Насанд хүрээгүй согтууруулах ундаа хэрэглэсэн 16 хүүхэд, насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа зарж борлуулсан 2 аж ахуйн нэгж, цагийн хуваарь хэтрүүлэн ажилласан 2 цахим тоглоомын газар, зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 1 цахим тоглоомын газар, танхайрах зөрчил гаргасан 5 хүнд захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагааг явуулж, холбогдох хуулийн дагуу 25 хүнд 736,000 төгрөгний торгууль оногдуулж ажилласан.

- “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг бэлтгэж, 4 бүлгийн 125 хүүхдэд зохион байгуулан ажилласан.
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15,5,8, 7-р зүйлийн 7,1 дэх заалтуудыг хэрэгжүүлэх, ЦЕГ-ын НХЖХА-наас ирүүлсэн 6/464 тоот ажлын чиглэлийг хэрэгжүүлж, хариуцсан нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүйгээр төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэнийг илрүүлэн, үйл ажиллагааг нь таслан зогсоох, иргэдэд энэ төрлийн хуультогтоомжийг сурталчилах чиглэлээр 2015,02,02-ны өдөр “Тоглоомын газар” нэртэй хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулсан.

Арга хэмжээнд НХЖХТ-ийн 2 офицер, 4 цагдаа, 4 олон нийтийн цагдаа хамрагдаж, Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг тоглоомын газруудад хяналт шалгалт хийж ажиллалаа.

Хяналт шалгалтын хүрээнд тусгай зөвшөөрөлтэй 8 цахим тоглоомын газар хамрагдаж, бооцоот тоглоом тоглуулдаг байж болзошгүй 3 цэгт шалгалт хийж ажилласнаас зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 1 цахим тоглоомын газрыг илрүүлж үйл ажиллагааг нь зогсоож, захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагааг явуулж, ЗХТХ-ийн 42,2-д заасны

дагуу 20,000 төгрөгний торгуулийн арга хэмжээ оногдуулж, 8 тоглоомын газарт мөрийтэй бооцоотой тоглоом тоглуулахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, хариуг 100 хувь авч ажиллалаа.

Хэсэгчилсэн арга хэмжээгээр тус аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, иргэн илрээгүй болно.

- Уламжлалт цагаан сарын баяртай холбогдуулан орон нутгийн UCTV телевизэд нөхцөл байдлын мэдээлэл хийж, урьдчилан сэргийлэх анхааруулга яриа хийж ажиласан.
- “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн ажлыг идэвхжүүлэх чиглэлээр аймгийн төвийн Ерөнхий боловсролын 4 дунд сургуулийн “Өсвөрийн цагдаа” бүлгэмд хийж гүйцэтгэх ажлын чиглэлийг бичгээр хүргүүлсэн.

- Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн хүмүүжлийг төлөвшүүлэх зорилготой “Азжаргалтай гэр бүл” теле цуврал нэвтрүүлгийн анхны дугаарыг аймгийн ХГБХХ, “Алтан говь” телевизтэй хамтран бэлтгэж нэвтрүүлсэн.
- Сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэг олгох, сумын иргэд, багш, сурган хүмүүжүүлэгч нарт хууль сурталчилах, хүүхдийн гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах зорилгоор сургалт, зөвлөгөөнийг 2016.02.25-26-ны өдрүүдэд Цогтцэций, Ханбогд сумдад зохион байгуулан ажиллалаа.

Уг арга хэмжээг аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулсан бөгөөд сумын нийт иргэд, сургуулийн багш, эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг зохион байгуулсан ба 190 гаруй иргэд хамрагдсан ба иргэдэд Цогтцэций сумын Цагдаагийн хэлтсээс сум орон нутгийн гэмт хэрэг, зөрчлийн талаар статистик мэдээллийг танилцуулснаас гадна ХГБХХ-ийн ахлах мэргэжилтэн Т.Золжаргал “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд”, “Цахим донтолт” сэдвүүдээр, Залуучууд хөгжлийн төвийн сургагч багш Отгонжаргал “Жендерт суурилсан хүчирхийлэл” сэдвээр, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн ахмад Б.Оюунчимэг би “Аймгийн хэмжээнд насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эцэг эхчүүд бид юуг анхаарах вэ” сэдвүүдээр мэдээлэл, сургалтыг зохион байгуулсан.

Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор баталсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж байгаа 2 цахим тоглоомын газарт иргэд, хүүхдүүдээс авсан мэдээллийн дагуу

шалгалт хийхэд ямар нэгэн зөрчил илрээгүй зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байсан болно.

Гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийг бууруулах талаар сургуулийн сурагч, өсвөр насны хүүхдүүдийн мэдлэгийг нэмэгдүүлж хандлагыг өөрчлөх зорилгоор аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дэргэдэх Залуучууд хөгжлийн төвтэй хамтран "Жендэр ба өөрчлөлт" төслийн хүрээнд "Хүчирхийллээс ангид байя" нэгдсэн арга хэмжээг 2016,03,10-25-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах байцаагч, цагдаагийн ахмад Б.Оюунчимэг би "Хүчирхийллээс ангид байя" нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан аймгийн Залуучууд хөгжлийн төвтэй холбогдон зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

-Арга хэмжээний хүрээнд аймгийн нийт сум, багийн Засаг дарга нарт "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийн 14-р зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаар сум, багийн Засаг даргын үүргийн талаар сургалт орж, ярилцлага зохион байгуулсан.

-Мөн сумдын нийгмийн ажилтнуудад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийн 10-р зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх нийгмийн ажилтны үүрэг сэдвээр сургалт зохион байгуулж, ярилцлага хийсэн.

-Нэгдсэн арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд "Хүчирхийллээс ангид байя" сэдвийн дор "Дэвжээ" тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд уг тэмцээнд Ерөнхий боловсролын 3 дунд сургууль, Политехник коллежийн оюутан нийт 32 сурагч хамрагдаж, сургууль бүрийн "Өсвөрийн цагдаа" бүлгэмийн сурагчид хөгжөөн дэмжигчээр оролцсон ба ЕБ-ын 1-р дунд сургууль 1-р байрыг, ЕБ-ын 2-р дунд сургууль 2-р байр, ЕБ-ын 3-р дунд сургууль 3-р байрыг, Политехник коллежийн оюутнууд тусгай байрыг эзэллээ.

-Дээрх арга хэмжээний хүрээнд хүүхдийн дүрслэх сэтгэхүйг зурсан зургаар дамжуулан өөрийн үзэл бодлоо уран зургийн аргаар илэрхийлэх зорилгоор "ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙЯ" сэдэвт гар зургийн уралдааныг ЕБС-ын 1-5-р ангийн сурагчдын дунд зарлаж дүнгээ гаргалаа.

Уралдаанд нийт хар зураг, усан будаг, тосон будаг, гуашан будгаар зурж ирүүлсэн 95 бүтээлийг хүлээн авч шалгарууллаа. Нэгдсэн дүнгээр шалгарч шагналт байранд орсон сурагчдыг "Жендэр ба өөрчлөлт" төслийн хүрээнд өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

-Мөн хүүхэд багачуудыг Монгол хэлний үгсийн урлагийн гайхамшигт ертөнцөөр аялуулан, үг хэллэгийн арвин баялаг сантай танилцуулж, санасан бодсоноо сэтгэн хөгжүүлэх, зохиох, бүтээх, туурвих урлагт сургах зорилгоор ЕБС-уудын 6-9-р ангийн сурагчдын дунд "ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙЯ" шүлгийн уралдааныг зарлаж амжилттай зохион байгуулагдлаа.

Цахим тоглоомын 8 газарт Засгийн газрын баталсан журмыг хэрэгжүүлж ажиллах талаар албан мэдэгдэл хүргүүлж хариуг 100 хувь авч ажилласан.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд холбогдох болон өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, согтууруулах ундааны хор уршгийг таниулах, эрх зүйн мэдлэг олгох, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, хуулийг дээдлэх, ёс зүй, харилцааны соёлыг төлөвшүүлэх зорилгоор 2016,04,05-ны өдрөөс 2016,05,06-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд "Нэг л алдвал" нэртэй нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Мөн дээрх арга хэмжээний хүрээнд насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх 2 төрлийн санамж сэрэмжлүүлгийг хичээлийн хуваарь хэлбэрээр өнгөтөөр 1000 ширхэгийг аймгийн ГХУСАЗЗ-ийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэн эхний хэсгийг аймгийн 1-р дунд сургуулийн 8-а ангийн 28 хүүхдэд гардуулан өгч ажилласан.

Нэгдсэн арга хэмжээг зохион явуулсан талаар гэрэл зургаар баримтжуулан ажилласан болно.

Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран албадан сургалтын төлөвлөгөө гарган Шүүхээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар "Эрх хязгаарлуулах арга хэмжээ" ногдуулсан 1 хүнд, Цагдаагийн газрын албадан саатуулах байранд баривчлагдсан 5 хүнд сургалт зохион байгуулан ажилласан.

Өрх толгойлон буюу түр болон удаан хугацаагаар хараа хяналтгүй амьдарч байгаа хүүхдүүдийн гэрээр хяналт тавьж, хүүхдүүд бөөгнөрөх, улмаар согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх асуудлыг илрүүлэх, таслан зогсоох, ахуй амьдралтай нь танилцаж, зөвлөгөө өгөх зорилгоор "Хараа хяналтгүй хүүхэд" хэсэгчилсэн арга хэмжээг

2016,05,06-ны өдөр зохион байгуулан ажиллалаа. Арга хэмжээнд дунд сургуулиудын нйигмийн ажилтнуудыг хамруулан НХЖХТ-ийн алба хаагчид хамтран 4 хэсэг болон ажилласан. Арга хэмжээний хүрээнд эцэг эхийн хараа хяналтгүй түр болон удаан хугацаагаар амьдардаг 52 хүүхдийнхээр орж, хяналт шалгалт хийж, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хяналт шалгалтын явцад гудамж талбайд болон хараа хяналтгүй амьдарч байгаа хүүхдүүдийн гэрээр ямар нэгэн зөрчил илэрсэнгүй.

Сургуулийн сурагчдын төгсөлтийн баяртай холбогдуулан насанд хүрээгүй хүмүүсийг согтууруулах, мансууруулах бодис хэрэглэх болон гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэх, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, согтууруулах ундааны зөвшөөрөлтэй дэлгүүр, бар, ресторан, цахим тоглоомын газруудад хяналт тавих, гудамж талбайд олон нийтийн эргүүлийг чанартай зохион байгуулах зорилгоор “Хонхны баяр” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулав.

Сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчил үйлдэх, гэмт хэрэг зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх ажилд хүүхдийн өөрөө удирдах байгууллага болох “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, оролцоо, нөлөөллийг сайжруулах, харилцан туршлага солилцох зорилгоор аймгийн ГХУСАЗЗ-ийн 2016 онд төлөвлөгөөнд тусгагдсан “ӨСвөрийн цагдаа” бүлгэмийн “Бие биенээсээ суралцаж хөгжье” нэртэй чуулга уулзалтыг 2016,05,19-20-ны өдрүүдэд аймгийн “Буянт хотхон” хүүхдийн зусланд аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй хамтран зохион байгууллаа.

Нэг бүрчилсэн арга хэмжээний талаар:

2016 оны эхний хагас жилд насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 44 хүүхэдтэй нэгбүрчилсэн уулзалт хийж, эрх зүйн зөвлөгөө авахыг хүссэн 49 иргэн, эцэг эхтэй нэгбүрчлэн уулзаж, тэмдэглэл хөтөлж ажилласан.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын чиглэлийг бичгээр гаргаж, нийт хэсгийн төлөөлөгч, байцаагч нарт хүргүүлсэн.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй дуудлага мэдээлэл хүлээн авсан цагдаагийн алба хаагч хэрхэн ажиллах талаар зааварчилгааг жижүүрийн 4 офицер, 3 хэсгийн байцаагчид бчгээр өгсөн.
- Нярай хүүхдээ алахыг завдсан насанд хүрээгүй Хонгорзулын асуудлаар Даланзадгад сумын 1-р багийн хамтарсан багийг хуралдуулан дээрх асуудлаар аймгийн ХГБХХ, НХХ-т албан бичиг хүргүүлэн, шалтгаан нөхцлийг тодруулан аймгийн Өрх гэрийг дэмжих хөтөлбөрөөс гэр олгуулсан.
- Аймгийн төвийн ЕБ-ын 4 дунд сургуульд сургуулийнхаа сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүмүүжлийн чанартай тодрхой ажил арга хэмжээ зохион байгуулах талаар албан мэдэгдэл хүргүүлж, хариуг 100 хувь авч ажилласан.
- Аймгийн Хууль зүйн хэлтэс, бусад холбогдох байгууллагуудтай хамтран сүм хийдийн судалгаа гаргах ажлын хэсэгт ажиллаж, Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа шашны сүм хийдүүдийн судалгааг гаргаж ЦБ-ын мэдээллийн санд шивж ажилласан.

1. МҮОНР-д аймгийн хэмжээнд насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээллийг 2 удаа, Говийн наран телевизэд нөхцөл байдлын мэдээллийг 1 удаа өгсөн.

<u>Саатуулах, баривчлах байрны үйл ажиллагааны талаар</u>

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Албадан саатуулах, баривчлах байр нь дарга, эмч 1 /Ц.х/ч Б.Алдармаа/, жижүүрийн 2 эмч /Ц.д/ч С.Эрдэнэочир энг Г.Амартүвшин/, ээлжийн 3 цагдаа /Ц.а/ч Г.Мягмаржав, Ц.д/а Д.Өлзийбаяр, Ц.д/а Л.Наранбадрах/-ийн орон тоотой 24 цагийн томилгоотойгоор үүрэг гүйцэтгэж байна.

ЦЕГ-аас 2016 онд дэвшүүлсэн зорилт болон Цагдаагийн газрын зорилтыг гол удирдлагаа болгон Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль тогтоомж, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 13 дугаар зүйл, НҮБ-аас баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”, Хууль зүйн сайдын 2014.12.08-ны өдрийн А/227 тоот тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр биелүүлэх журам”, ЦЕГ-ын даргын 2015.01.10-ны өдрийн А/15 дугаар душаалаар баталсан “Захиргааны зөрчил хянан шийдвэрлэх журам” код 408 болон ЦЕГ-ын даргын 2016 оны 05 сарын 12-ны өдрийн А/53 дугаар тушаалаар баталсан код 408-д нэмэлт өөрчлөлт оруулсан/, тэдгээрийг биелүүлэхэд нийцүүлэн гаргасан журам, заавар, тушаал, шийдвэрүүдийг биелүүлж, АСББ-нд хүргэгдэн ирсэн этгээдүүдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хамгаалах цагдаагийн болон эмчийн ёс зүй

хэм хэмжээг баримтлан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЦЕГ-ын даргын 2014 оны 429-р тушаалаар батлагдсан “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс, дэд хэсгийн байранд тавих ерөнхий шаардлагын CS11-0244-2014”-ын 6.3-т заасан нөхцөл шаардлага хангасан албадан саатуулах байранд эмэгтэйг эрэгтэйгээс, насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгчдээс нь тусгаарласан 4 өрөөтэй, эрэгтэй баривчлах 1 өрөө, эмэгтэй баривчлах 1 өрөө, албадан саатуулах 1 өрөө, өрөөний хяналтын дүрс бичлэгийн 7 телекамертай, 15 хүний модон наартай, бүх өрөө төмөр хаалгатай тэр нь хянах шагайвартай, гадна талаасаа цоожтой өрөөнүүд байдаг ба энгэрийн камер болон өөрийн биеэр хяналтыг тавьж, рапорт болон энгэрийн камерын бичлэгээ өдөр тутам НХЖХТ-ийн дарга болон Цагдаагийн газрын даргад танилцуулж, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэн ажиллаж байна.

Албадан саатуулах, баривчлах байрны өрөөнүүдийн дулаан 18,5 градустай, чийглэг 40,2%, баривчлах өрөө нь 1 хүнд 2 мкв-аас багагүй талбай ноогддог, 15 хүний багтаамжтай, хүн тус бүр унтлагын дэвсгэр, хучлагатай байдаг бөгөөд саатуулах өрөө нь талбайн ноогдох хэмжээ нь стандартын дагуу, 4 өрөө байна.Саатуулагдсан этгээдийг хүлээн авсан жижүүрийн цагдаа, эмч нь байрны дотоод журмыг танилцуулан, биед нь үзлэг хийж, эд зүйлсийг номерлосон уутанд хийж хадгалан эрүүл мэндийн үзлэг хийж энэ тухайгаа тэмдэглэл хөтлөн саатуулах байр болон баривчлах байрнаас гарахад нь эд зүйлсийг буцаан олгож гарын үсэг зуруулан баталгаажуулж, шийдвэрлэх албан тушаалтанд нь хүлээлгэн өгч хэвшсэн байна.

Мөн 24 цагийн үүрэг гүйцэтгэж байгаа албаа хаагчдын харилцааны соёлд онцгой анхаарч, иргэдтэй зүй бус дээрэнгүй харьцах, хууль бус шаардлага тавих, эрх чөлөөнд нь халдахгүй байх албаа хаагч, ажилтануудад ажил, үүрэг гүйцэтгэх явцад үүсч болох хүндрэл бэрхшээл, алдаа дутагдал, эрсдлээс урьдчилан сэргийлэх санамж зөвлөмжийг тасгийн даргаас өдөр тутам өгч, баталгаа гарын үсэг зуруулж хэвшлээ.

Төрийн албаа хаагчдыг халдварт бус болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх түргэвчилсэн шинжилгээнд хамруулж, өвчлөлийг эрт илрүүлэх, эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлүүдийг тогтоож, эрүүл зан үйл төлөвшүүлэх зорилготой “Та оролц-Бид таныг дэмжье” ажлын хүрээнд байгууллагын 42 албаа хаагчдыг үзлэг шинжилгээнд хамруулаа.

Албадан саатуулах байрны талаар:

Саатуулах байр нь Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, ЦЕГ-ын даргын 2015.01.10-ны өдрийн А/15 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны зөрчил хянан шийдвэрлэх журам” код 408 болон ЦЕГ-ын даргын 2016 оны 05 сарын 12-ны өдрийн А/53 дугаар тушаалаар батлагдсан код 408-д нэмэлт өөрчлөлт оруулсан/, тэдгээрийг биелүүлэхэд нийцүүлэн гаргасан журам, заавар, тушаал, шийдвэрүүдийг биелүүлж, АСБ-нд хүргэгдэн ирсэн этгээдүүдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хамгаалах цагдаагийн болон эмчийн ёс зүй хэм хэмжээг баримтлан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

2016 оны байдлаар саатуулан байр нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдон ар гэртээ түгшүүр төрүүлсэн, жолоодох эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн нийт 632 хүн саатуулснаас 619 эрэгтэй, 13 эмэгтэй, насанд хүрээгүйчүүд саатуулагдаагүй байна.

Саатуулсан этгээдээс авч буй төлбөрийн хэмжээг Хууль зүйн дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 58/62 тоот тушаалаар батлагдсан “Эрүүжүүлүүлэхийн үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-ыг мөрдлөг болгон нийт 632 хүнээс төлбөр төлсөн 618 хүний зардал болох 2.564.700 төгрөг /хоёр сая таван зуун жаран дөрвөн мянга долоон зуун/-ийг төрийн сангийн 110012001 дансанд тушааж, баримтыг байгууллагын нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн байх ба төлбөр төлөөгүй 14 хүн, төлбөр төлөлт 97,7 %-тай байна.

Баривчлах байрны талаар:

Баривчлах байр нь НҮБ-аас батлагдсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”, Хууль зүйн сайдын 2014.12.08-ны өдрийн А/227 тоот тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр биелүүлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.Тус байр нь

тусгай агааржуулагчтай, өрөөний хяналтын камертай, 15 хүний модон наартай, хянах шагайвартай, 1 хүнд оногдох талбайн хэмжээ 2,4 м/кв байгаа ба чөлөөт цагаа өнгөрүүлэх телевиз, ном сонин сэтгүүлийн булан, эрх зүйн ном товхимол зэргээр үйлчилж байгаа нь “Баривчлах шийдвэр биелүүлэх журам”-ын 8.2, 8.4-д заасан заалтуудыг хэрэгжүүлж байгаа болно.

Энэ журмын 8.5, 8.9-ыг үндэслэн баривчлагдсан хүнийг 7 хоногт 1 удаа халуун усанд оруулж, өдөрт 1 удаа 1 цагаас доошгүй хугацаагаар салхилуулж, биеийн тамрын дасгал хөдөлгөөн хийх боломжоор хангаж, 7 хоногийн баасан гараг бүр 15-20 минутын хугацаатай гэр бүлийн гишүүн, найз нөхөдтэй нь хүндэтгэн үзэх шалтгаантай бусад тохиолдолд байгууллагын дарга, тасгийн дарга нарын зөвшөөрлөөр эргэлт, уулзалтыг зохион байгуулж байна.

Байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээний ерөнхий шаардлага стандартын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг үндэслэн аймгийн МХГ-т хүсэлт гарган МХГ-ын ариун цэврийн хяналтын улсын байцаагч З.Хашбатаар TES 1360 багажаар хэмжилт хийхэд өрөөнүүдийн дундаж дулаан 18,5 градус, чийглэг 40,2 %-тай байгаа нь ЦЕГ-ын даргын 2014 оны 429-р тушаалаар батлагдсан “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс, дэд хэсгийн байранд тавих ерөнхий шаардлагын CS11-0244-2014”-ын 6.3-т заасан нөхцөл шаардлага хангасан байна гэсэн дүгнэлттэй ажиллаж байна.

2016 оны байдлаар Захиргааны журмаар баривчлах шийтгэл эдлэсэн нийт 63 хүн байгаагаас:

-ЗХТХ-ийн 21-ээр 37 хүн, -ЗХТХ-ийн 22-оор 18 хүн -ЗХТХ-ийн 30.2-оор 7 хүн -ЗХТХ-ийн 31-ээр 1 хүн тус тус баривчлах байранд баривчлах шийтгэл эдлэсэн байна.

Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 10,1-д “Баривчлагдсан этгээдийн байранд байсан хугацааны шууд зардлыг Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон хэмжээгээр тооцож төлүүлнэ” гэсэн заалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон нийт 63 хүнээс төлбөр төлсөн 56 хүний 2146760 төгрөгийг төрийн санд тушааж, төлбөр төлөөгүй 7 хүн, төлбөр төлөлт 88,89%-тай байна.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын даргын 2016.04.09-ны өдрийн А/15 тоот тушаалаар шүүхийн шийдвэрээр баривчлах шийтгэл эдлэн баривчлах байрны шууд зардал төлөөгүй хүмүүсийн материалыг бүрдүүлэн хүргүүлж, Цагдаагийн газраас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр албадан саатуулах, баривчлах байрны дарга, эмч цагдаагийн хошууч Б.Алдармааг томилж, шүүхээр 5 хүний шууд зардал болох 319710 төгрөгийг нөхөн гаргуулж, төрийн сангийн 110012001 дансанд тушаалаа.Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлсэн 12 хүний эмчилгээний хугацаа дуусаж, цагдаагийн хошууч Б.Алдармаа би, цагдаагийн ахмад Х.Намидын хамт эмчилгээнд хамрагдсан хүмүүсийг харгалзан авчирч, аймгийн Хууль зүйн хэлтэс, Хөдөлмөрийн хэлтсийн алба хаагчидтай хамтран уулзалт, өдөрлөгийн арга хэмжээг зохион байгууллаа.

2016 оны 04 сарын 07-нд Дэлхийн эрүүл мэндийн өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд зохион байгуулагдах “Чихрийн шижин өвчний эсрэг хамтдаа тэмцье” сэдэвт арга хэмжээнд саатуулах, баривчлах байрны 2 эмч хамрагдсан.

Баривчлах шийдвэр биелүүлэх журмын 8.7-д “Баривчлагдсан этгээд нь Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан хоолоор хангагдана.Үүнд баривчлагдсан этгээдэд өдөрт 2 удаа 500гр-аас багагүй хэмжээтэй халуун хоол, 1 удаа гурилан бүтээгдэхүүн, 3 удаа цай өгөх ба 1 удаад олгох цай нь 1-1.5 литр байна” гэсэн заалтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн Аймгийн засаг даргын захирамжаар байривчлах байрны шууд зардлыг 2010 оны мөн үеийн хоолны тарифыг өөрчлөн шинэчилж, 1 хоногийн шууд зардлын хэмжээг өдрийн 4260 төгрөг болголоо.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газраас “Улаан бурхан, улаанууд” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин хийлгэх 18-30 насны нийт 31 алба хаагч байгаагаас 26 алба хаагч вакцин хийлгэж 83,8 % нь хамрагдсан байна.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойн тохиолдуулан бүтээлч ажлын хүрээнд Саатуулах, баривчлах байрны гадна орчин гадаад үзэмжийг сайжруулан 213.250 төгрөгний гэрэлтүүлэгтэй хаяг байрлуулж, 90000 төгрөгөөр “Талст” барилгын материалын дэлгүүрээс материал авч байрны гадна хаалгыг будаж өнгийг сэргээн бариул болон түгжээг шинэчлэн, үүдний хэсгийн дээврийг ус дусахаас хамгаалан хучилт хийж өнгийг сэргээн будсан ба саатуулах баривчлах байрны үүдний хэсгийн цонхийг шиллэж гадна орчинг гэрэлтүүлдэг шонг будлаа.

Мөн Саатуулах, баривчлах байранд хэрэглэх шаардлагатай эмийн жагсаалтыг журмын дагуу гаргаж “Монос” эмийн сангаас 105500 төгрөгний эмийн хангалт авч эм тариагаа сэлбэлж, саатуулах баривчлах байрны үүдний хэсгийн цонхийг шиллэсэн.Саатуулах байрандаа дотоод сүлжээ тавиулан саатуулагдсан этгээдийн мэдээлэлийг ЦЕГ-ын санд хугацаа алдахгүй шивж, захиргааны хяналтанд байгаа болон эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийг хянах боломжтой боллоо.

”Шим билэг” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, их эмч Б.Лхагвасүрэн, “Өнө орших” өрхийн эмнэлгийн их эмч Ц.Нарантуяа нартай, аймгийн БОЭТ-ийн эмч нартай хамтарч байгууллагын алба хаагчдад “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” сэдэвт сургалт болон нарийн мэргэжлийн эмчнарын үзэг, шинжилгээнд алба хаагчдыг бүрэн хамруулан ажиллав

Сургалт, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:

2016 оны 03-р сард Цагдаагийн байгууллага, ажил албаа сурталчлах, бусад байгууллага аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор “Монгол цэрэг”-ийн баярын өдөрт зориулж “Гарнизон”-ы аварга шалгаруулах олон төрөлт тэмцээнд бэлдэн байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан, зохион байгуулж оролцууллаа.

Тэмцээнд Зэвсэгт хүчний 3 анги байгууллага, Хилийн цэргийн анги, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн шүүх, Онцгой байдлын хэлтэс гэх мэт 14 байгууллагууд сагсан бөмбөг, гар бөмбөг, буудлага, ширээний теннис, дартс, биллиярд, марш тактик гэх мэт төрлүүдэд оролцсон ба тус Цагдаагийн газар нь багаараа 3 дугаар байранд шалгарч оролцлоо.

Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу өөрсдийн нөөц бололцоог ашиглан ар талын өрөөнд жижүүрийн офицерууд үйл ажиллагаагаа явуулах, орчин бүрдүүлэн тохижуулах зорилгоор ширээ сандал, шинээр самбар, алба хаагчийн түлхүүр тавих савыг шинээр хийж, Цагдаагийн газрын коридорт алдартнуудын хэлсэн үгс болон Цагдаагийн газрын тасгуудаас хийсэн ажлын зурагт мэдээллийн самбар хийж байрлууллаа.Цагдаагийн байгууллагын 95 жилийн ойг угтан зохион байгуулж байгаа бүтээлч ажлын хүрээнд тус цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгаас 21 заалт бүхий ажлын төлөвлөгөө боловсруулан даргаар батлуулан, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэв.

Мөн Цагдаагийн газрын баруун талбайд болон зүүн талбайд 150 ширхэг мод тарьсанаас гоёлын 8 мод болох гацуур, босоо арц зэрэг моднууд тарьж, орчноо ногоон орчин болгох зорилт тавин хариуцсан талбайн усалгаа, арчилгаанд анхааран ажиллаж байна.Цагдаагийн газрын арын хашааг янзалж, өнгө үзэмжтэй болгох ажлыг төлөвлөн зохион байгуулж, нурсан хашааг нэмж өрөн, цементэн цацлага хийж, хашааг буулган шинэ блокоор засаж өнгө үзэмжтэй хашаатай боллоо. Албан өрөөг тохижуулах аяны хүрээнд нийтийн хэв журам хамгаалах тасгийн зарим өрөөнд бүрэн засвар хийж, алба хаагчдаас өрөөг цэцэгжүүлэх ажлыг зохион байгуулж, олон нийттэй харилцах ахлах байцаагч, олон нийтийн цагдаа нарын өрөөнд алжаал тайлах булан хийж, модон цэцэгийн суурь хийлгэж, цэцэгжүүлэн, загас тэжээн, шинээр хөшиг, цаг суурилуулан өөрдсийн албан өрөөг тохижуулсан.

Алба хаагчдын ар гэр, ахуй нөхцлийг судлах, санал хүсэлтийг авах зорилгоор “Аялах дэвтэр”-ийг нээж санал хүсэлтийг авч байгаа ба 2016 оны 06-р сард тасгийн алба хаагчдын ар гэрийн гишүүдийг хүлээн авах уулзалт, өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, “Хишиг өдөр” арга хэмжээг зохион байгуулж, гэр бүлийн гишүүдэд Цагдаагийн ажилтаны 1 өдрийн ажлыг танилцуулав. Мөн алба хаагчдыг сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх, ар гэр, ажил

албанд нь туслуулах, дэмжлэг өгөх зорилгоор ахлах байцаагч, офицер, ахлагчаар нэг баг болгон хуваарилан ажиллуулж байна.

Цагдаагийн алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2016 оны 06 дугаар сард алба хаагчдыг Говь гурван сайхан байгалийн үзэгслэнт газарт салхинд гаргаж, хөгжөөнт тэмцээн уралдааныг зохион байгуулав

Алба хаагчдын албандаа итгэх итгэл үнэмшлийг бий болгох, ажлыг сайжруулах зорилгоор тус байгууллагын Ахмадын зөвлөлийн дарга, бэлтгэл хошууч Г.Цогт-Очир, Ахмадын зөвлөлийн гишүүн, бэлтгэл хошууч С.Батсүх нартай уулзалт өдөрлөгийн арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, ажиллаж байсан үеийн туршлага болон заавар, зөвлөгөөг өгүүлэв.

Тус тасаг нь үйл ажиллагаандаа орчин үеийн мэдээлэл технологийн хэрэгсэл, албаны тусгай хэрэгслийг өргөн ашиглаж, алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, бие бялдрыг хөгжүүлэхэд анхаарал хандуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тасгийн алба хаагчид нь улс, аймаг орон нутгийн хэмжээнд зохион явагддаг урлаг, спортын арга хэмжээнүүдэд амжилттай оролцсон байна.

Захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн талаар

Тус Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасаг нь захиргааны зөрчлийн дуудлага бүрийг хүлээн авч, захиргааны зөрчлийн тоо бүртгэлийн санд шивж, хоногийн мэдээнд тусган, 256 зөрчилд захиргааны хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 3379000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч хариуцлага тооцон ажилласан ба нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт хөдлөгөөнт болон явган эргүүлийг ажиллуулан 2207 захиргааны зөрчил илрүүлэн, Захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалтаар 45525000төгрөгний торгуулийн арга хэмнээ ноогдуулан ажилласан байна.

Хамгаалалт зохицуулалтын талаар:

Өмнөговь аймгийн хэмжээнд 2016 онд Монгол улсын Их хурлын дарга З.Энхболд, Монгол улсын Ерөнхий сайд, Шадар сайдын айлчлалын үеийн хамгаалалт, дэлхийн геннисийн номонд бичигдэх “Монгол тэмээ-999” хурдан 1000 тэмээний уралдааны арга хэмжээ, “Говийн бүсийн их хурд” хурдан морины уралдаан, Монгол улсын Их хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийг сонгох сонгуулиуд, сар шинэ, баяр, наадам болохтой холбогдуулан Цагдаагийн газраас хамгаалалт зохицуулалтын төлөвлөгөө зураглал гарган, хамгаалалт зохицуулалт хийж ажиллалаа. Дээрх арга хэмжээний хамгаалалт зохицуулалтыг тус цагдаагийн газар орон нутгийн хүчний байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бөгөөд хамгаалалтын үеэр алба хаагчдаас цагдаагийн алба хаагчдын сахилга, ёс зүйг зөрчсөн үйлдэл гаргалгүй, хамгаалалтыг сайн зохион байгуулсан ба аймаг орон нутгийн удирдлагуудаас талархал дэвшүүлсэн.

Мөн УИХ-ын болон аймаг орон нутгийн сонгууль, төрийн өндөрлөгүүдийн хамгаалалт, аймаг, сумдын баяр наадмын хамгаалалт, зохицуулалт зэрэг арга хэмжээний үеэр ажиллах хамгаалалтын төлөвлөгөө зураглал гарган удирдан зохион байгуулж ажилласан ба уг арга хэмжээнүүдэд гэмт хэрэг, эрх зүйн зөрчилгүй явуулах, орон нутгийн хэмжээнд эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндрэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдлыг хангаж, хамгаалалтын үед ажиллах алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлага, нэгдсэн зохион байгуулалтаар тасралтгүй хангаж ажиллалаа. Дээрх хамгаалалт зохицуулалтын талаарх мэдээг тухай бүр нь танилцуулж ажилласан болно.

Тус аймгийн Ханхонгор сумын Жаргалант, Хондот багуудын нутаг дэвсгэрт малын халдварт өвчин “Цэцэг” 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гарсантай холбогдуулан аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, ХХААГ-тай хамтран 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд 11 шалган нэвтрүүлэх пост, 12 хөдөлгөөнт эргүүл гаргаж, нийт 1565 тээврийн хэрэгсэл, 2325 хүнд үзлэг хийж, ариутгалжуулж, гарал үүслийн бичиггүй 350 кг махыг хураан авч, МХГ-т шилжүүлэн өгч, хорио цээрийн дэглэм сахиулан ажилласан байна.

Арван нэг: Бусад

Тус тасаг нь үйл ажиллагаандаа орчин үеийн мэдээлэл технологийн хэрэгсэл, албаны тусгай хэрэгслийг өргөн ашиглаж, алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, бие бялдрыг хөгжүүлэхэд анхаарал хандуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тасгийн алба хаагчид нь аймаг орон нутгийн хэмжээнд зохион явагддаг урлаг, спортын арга хэмжээнүүдэд амжилттай оролцсон байна.

- 2016 оны 1-р улиралд Цагдаагийн байгууллага, ажил албаа сурталчлах, бусад байгууллага аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор “Монгол цэрэг”-ийн баярын

өдөрт зориулж “Гарнизон”-ы аварга шалгаруулах олон төрөлт тэмцээнд бэлдэн байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулж оролцууллаа.

Тэмцээнд Зэвсэгт хүчний 3 анги байгууллага, Хилийн цэргийн анги, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн шүүх, Онцгой байдлын хэлтэс гэх мэт 14 байгууллагууд сагсан бөмбөг, гар бөмбөг, буудлага, ширээний теннис, дартс, биллиярд, марш тактик гэх мэт төрлүүдэд оролцсон ба тус цагдаагийн газар нь багаараа 3 дугаар байранд шалгарч оролцлоо.

3.4. <u>Олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн чиглэлээр</u>*:*

Тус хэсэг нь Улсын онц чухал объект болох Даланзадгад сумын “Гүний ус” компаний цэвэр усны объектуудыг гадны гэмт халдлага, хорлон сүйтгэх ажиллагаанаас хамгаалж, үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор ханган, үндсэн чиг үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байна

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсэг нь Даланзадгад хотын цэвэр усны эх үүсвэрийг хэсгийн дарга 1, ээлжийн зохицуулагч 4-н офицер, харуулчин цагдаа 8-н ахлагч бүрэлдхүүнтэй тус объектыг ямар нэг зөрчил дутагдалгүй хамгаалж харуулчдыг удирдан харуулын бэлтгэл бичиг баримт тусгай хэрэгсэлийг шалган ямар нэгэн зөрчил гаргуулахгүй аюулгүй арга хэмжээний дүрэм зааварчилагаатай танилцуулж ажилласан. Ажиллах хугацаанд ердийн цагийн

байдлаар объектыг 24:72 цагаар 4 офицер , 3 ахлагчийн бүрэлдэхүүнтэй хамгааллаа. Хамгаалах хугацаанд гүний 2,3,4,5-р худаг нөөцийн санг камераар хянаж ажиллалаа.

3.5. <u>Замын цагдаагийн албаны чиглэлээр:</u>

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн замын хяналт шалгалтаар нийт 10375 зөрчил илрүүлж, нэмэлт нотлох баримт, материал шаардлагатай 1206 зөрчилд захиргааны материал бүрдүүлэн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явсан 617 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж 236 сая 928 мянган төгрөгний торгуулийн арга хэмжээ авч тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 147 иргэнд захиргааны зөрчлийн материал бүрдүүлэн цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн санд шивсэн байна. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодож явсан 442 зөрчил илрүүлэн 442 иргэнийг 86 сая 208 мянган төгрөгний торгуулийн арга хэмжээ авч захиргааны зөрчлийн материал бүрдүүлэн ажилласан ба газар дээр нь буюу бэлэн бус хэлбэрээр 9169 иргэнд 472 сая 128 мянган төгрөгний торгуулийн арга хэмжээ ногдуулж нийт 10375 зөрчлийг захиргааны мэдээллийн санд оруулсан байна. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 764 зөрчлийг илрүүлж гарч болзошгүй зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлж ажилласан байна

Цагдаагийн газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 46/1857 дугаарт үүрэг ажлын чиглэлийг бүх сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт өгч цагийн менежменттэй эргүүл гаргах талаар удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байгаа ба Facebook-н хаалттай групп нээж өдөр бүрийн ажлын мэдээ, шалгасан тээврийн хэрэгслийн бүртгэлийг авч хоногийн рапортанд тусган ажиллаж байна.

2016 онд иргэд байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 269 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж 225 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай хуулийн анхын хугацаанд шалгаж прокурорт шилжүүлж, 10 гомдол мэдээллийг Замын цагдаагийн тасаг дээр эрүүгийн хэрэг үүсгэж хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн ба 34 гомдол мэдээллийг харъяалалын дагуу мөрдөн байцаах тасагт шилжүүлэн эрүүгийн хэрэг үүсгүүлэн гэмт хэргийн санд оруулан шийдвэрлэсэн ба газар дээр нь буюу даатгалын кампаниар 105 ослыг шийдвэрлэсэн байна. Хэргийн улмаас 19 иргэн нас барж, 24 иргэн хүнд, хөнгөн хэлбэрээр гэмтсэн ба иргэн, аж ахуй нэгж, байгууллагад нийт 284 сая 217 мянган төгрөгний хохирол учирсаныг хэрэг бүртгэлтийн шатанд 284 сая 217 мянган төгрөгний хохирол буюу 100 хувийг нөхөн төлүүлж ажилласан байна.

Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд тус тасаг нь 2015 он, 2016 оны 1,2,3 дугаар улиралын үйл ажиллагааны тайланг аймаг орон нутгийн 35 мянган үзэгчтэй Алтанговь, USTV, Best, Говийн наран телевизүүд, Засаг даргын тамгийн газрын олон нийттэй харилцах алба, монцамэ агентлагт мэдээлэл хийж, мөн ХАБЭГХэрэг, ослоос урьдчилан сэргийлэх иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Southgovi tpolice” facebook хаягаар ард иргэдийн санал хүсэлтийг авч ажиллав. Нэгдсэн шалгалтын хуваарийн дагуу “Согтуу-1”, “Сар шинэ-2016”, “Хяналт шалгалт-1”, “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх үзлэг”, “Хяналт шалгалт-2”, “Март-8”, “Мотоцикль”, “Хөдөлгөөнт эргүүл”, “Оюутан тээвэр-1” “Оюутан тээвэр-1”, “Согтуу”, “Хөдөлгөөнт эргүүл”, “Хяналт шалгалт”, “Хамгаалах бүс, хамгаалалтын суудал”, “Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх”, “Автотээврийн хэрэгслийн стандарт шаардлага-2016”, “Согтуу-3”, “Согтуу-4”, “Хяналт шалгалт-4”, “Тусгай дуут болон гэрэл дохио”, “Гэрэл”, “Зөрчлийн илрүүлэлт”, “Шинэ жил”, “Хог хаягдал тээвэрлэдэг тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг аймаг орон нутгийн хэмжээнд бусад албад болон төрийн, төрийн бус байгууллага аймгийн автотээврийн төв, Онцгой байдлын газар, Албан журмын даатгагчдын холбоотой хамтран зохион явуулж үр дүнг тооцон ажиллаж зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг аймаг орон нутгийн хэмжээнд бусад албад болон төрийн, төрийн бус байгууллага аймгийн онцгой байдлын газар, албан журмын даатгагчдын холбоотой хамтран зохион явуулж үр дүнг тооцон ажиллаж гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийг гарахад нөлөөлж буй нэг шалтгаан нөхцөл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон аж ахуй нэгж, байгууллагын жолооч нарын удирдлагуудад “Онцгой байдлын газар-2”, “Төрийн банк-1”, “Зэвсэгт хүчний 167-р анги-5”, “Хилийн цэргийн 0131-р анги-5”, “Байгаль орчин аялал жуулчлалын газарт-1”, “Чинхуа-Мак нарийн сухайт ХХК-1”, “Гуравдугаар тойргын тахарын алба-1”, “Хөгжимт жүжгийн театерт-3”, “4-р сургуульд-1”, “Заланзадгад сумын захирагчын алба-3”, “Өмнөд бүс дэх цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит компанид-1” “Хүнс хөдөө аж ахуйн газар”-2, “Ус цаг уур орчны шинжилгээний алба”-

1, “төрийн үйлчилгээний алба”-1, “Мэргэжлийн хяналтын газар”-1, “Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар”-1, “Улсын бүртгэлийн хэлтэс”-1, “Мэдээлэл холбоо сүлжээний газар”-1, “Төрийн банк”-1, “Чинхуа мак нарийн сухайт ХХК”-1, “Бериун ложистик ХХК”-1, “Дээжийн өргөө ХХК”-1, “Дэжин сэке ХХК”-1, “Цэхэ ерөн ХХК”-1, “Роёол маунт ХХК”-1, “Дөрвөн зам транс ХХК”-1, “Набаз ХХК”-1, “Тэргүүн тоорой ХХК”-1, “Жинзинг ХХК”-1, “Таван толгой шин ХХК”-1, “Онцгой байдлын газар-2”, “Бүсийн оншилгоо эмчилгээний төвд-1”, “23 дугаар цэцэрлэгт-1”, “Хилийн цэргийн 0131-р ангид-1”, “Дулааны цахилгаан станцад-1”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд-1”, “Татварын хэлтэст-1” тус тус 52 албан мэдэгдэл, шаардлага хүргүүлж хамтран сургалт зохион байгуулан ажиллаж байна. Мөн аймгийн шатахуун түгээх станцуудын дарга удирдлагад “Онц чухал объект, тэдгээрт ажиллаж буй иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, гарч болзошгүй Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах” зорилгоор албан мэдэгдэл хүргүүлж ажилласан.

Аймгийн хэмжээнд жолооны сургалт явуулж байгаа 6 курсуудын сургалтанд хяналт тавиж ажилласан ба Хууль зүйн сайд, Хөдөлмөрийн сайдын хамтарсан 2015 оны А/180, А/217 тоот тушаалыг баримтлан жолооны үнэмлэхээ үрэгдүүлсэн 100 иргэний материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж жолооны үнэмлэхийг нөхөн олгосон, мөн жолоочийн хуучин үнэмлэх солиулах хүсэлт гаргасан 1140 иргэний материалыг бүрдүүлэн авсан, өршөөлийн тухай хуулийн 4-3-т заасан үндэслэлээр тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ сэргээлгэхээр хүсэлт гаргасан 93 иргэн, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ сэргээлгэхээр хүсэлт гаргаж давтан сургалтанд хамрагдаж шалгалт өгч тэнцсэн 121 иргэний материалыг тус тус авч ЦЕГ-н Лицензийн төвд албан тоотоор хүргүүлэн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь сэргээлгэсэн. Нийт 498 иргэнд жолооны үнэмлэхний лавлагааг гарган өгч үйлчилсэн байна. Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэхь заалтыг зөрчиж тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ 6 сараас 2 жилийн хугацаагаар хасуулсан 616 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох үнэмлэхийг TPS программд хаалт хийж эрхийг түдгэлзүүлэх, эрхийг хасах арга хэмжээг тухай бүрт хийж хүснэгтийн дагуу ЦЕГ-н лицензийн төвд албан бичгээр хүргүүлэн ажиллав. Жолооч бэлтгэх сургалт эрхэлсэн “Дэгжих говь” авто сургуулын шалгалтын графикийн дагуу үндсэн А ангилалын 11 тушаалын 137 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 128 иргэн, үндсэн В ангилалын 14 тушаалын 297 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 267 иргэн, үндсэн ВС ангилалын 8 тушаалын 80 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 78 иргэн, мэргэжил дээшлүүлэх В-ВС ангилалд 15 тушаалын 119 жолоочоос 117, ВС-ВСД ангилалд 14 тушаалын 105 жолоочоос 102, ВС-ВСЕ ангилалд 9 тушаалын 47 жолоочоос 46 жолооч, 7,21 хонгын давтан курсын 5 тушаалын 8 иргэнээс 8 иргэн тус тус тэнцэж ЦЕГ-ын Лицензийн төвд холбогдох материалыг хүргүүлсэн байна. Жолооч бэлтгэх сургалт эрхэлсэн “Аривжих говь” авто сургуулын шалгалтын графикийн дагуу үндсэн А ангилалын 3 тушаалын 35 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 32 иргэн, үндсэн В ангилалын 12 тушаалын 142 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 124 иргэн тэнцэж, үндсэн ВС ангилалын 3 тушаалын 36 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 31 иргэн, мэргэжил дээшлүүлэх В-ВС ангилалд 6 тушаалын 27 жолоочоос 27, ВС-ВСД ангилалд 5 тушаалын 36 жолоочоос 36, ВС-ВСЕ ангилалд 4 тушаалын 17 жолоочоос 15 жолооч, 21 хонгын давтан курсын 2 тушаалын 4 иргэнээс 4 иргэн тус тус тэнцсэн ЦЕГ-ын Лицензийн төвд холбогдох материалыг хүргүүлсэн байна. Жолооч бэлтгэх сургалт эрхэлсэн “Задлин” авто сургуулын шалгалтын графикийн дагуу үндсэн А ангилалын 4 тушаалын 36 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 36 иргэн, үндсэн В ангилалын 9 тушаалын 81 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 73 иргэн тэнцэж, үндсэн ВС ангилалын 2 тушаалын 18 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 18 иргэн, мэргэжил дээшлүүлэх В-ВС ангилалд 7 тушаалын 60 жолоочоос 57, 21 хонгын давтан курсын 1 тушаалын 3 иргэнээс 3 иргэн тус тус тэнцсэн ЦЕГ-ын Лицензийн төвд холбогдох материалыг хүргүүлсэн байна. Жолооч бэлтгэх сургалт эрхэлсэн “Батлан хамгаалах туслах нийгэмлэг” авто сургуулын шалгалтын графикийн дагуу үндсэн А ангилалын 4 тушаалын 33 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 26 иргэн, үндсэн В ангилалын 3 тушаалын 54 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон жолооны шалгалтыг авч 47 иргэн тус тус тэнцсэн ЦЕГ-ын Лицензийн төвд холбогдох материалыг хүргүүлсэн байна. Жолооч бэлтгэх сургалт эрхэлсэн “Политехник” авто сургуулын шалгалтын графикийн дагуу үндсэн В ангилалын 2 тушаалын 36 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн болон

жолооны шалгалтыг авч 29 иргэн тэнцэж ЦЕГ-ын Лицензийн төвд холбогдох материалыг хүргүүлсэн байна.

Мөн тус тасагт хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасгаас ирүүлсэн албан бичгийн дагуу 26 хэрэгт ослын дахин дүгнэлт гаргах хүсэлт ирснээс 20 хэрэгт дахин дүгнэлт гаргаж, 6 хэрэгт бүрэлдэхүүнтэй дүгнэлт гаргаж ажилласан байна

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, жолооч нарын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Нийтийн хэв журам хамгаалах тасагтай хамтран Даланзадгад сумын Худалдааны төвийн дөрвөн замын уулзвар, Мөнхжин дэлгүүрийн зүүн урд талын дөрвөн замын уулзвар, Магнай трейд шатахуун түгээх станцын баруун талын дөрвөн замын уулзвар, Гуравдугаар бүрэн дунд сургуулийн зүүн урд дөрвөн замын уулзваруудыг эзэнзүүлж алба хаагчдыг Цагдаагийн газрын жижүүрийн томилгоонд оруулж өглөө 08:00-09:30 цаг, өдөр 13:00-15:00 цаг, орой 17:00-19:00 цагуудад хуваарилан ажиллуулж байгаа ба үүрэг гүйцэтгэх алба хаагчидад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан баталгаа авч ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 46/1857 дугаарт үүрэг ажлын чиглэлийг бүх сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт өгч цагийн менежменттэй эргүүл гаргах талаар удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байгаа ба Facebook-н хаалттай групп нээж өдөр бүрийн ажлын мэдээ, шалгасан тээврийн хэрэгслийн бүртгэлийг авч хоногийн рапортанд тусган ажиллаж байна

“Осол гэмтэл, хүчирхийллийн эсрэг үндэсний хөтөлбөр”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний стратеги” зэрэг хөтөлбөрүүдийн хүрээнд Замын цагдаагийн тасгаас хийх ажлын төлөвлөгөөг гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулж, ЦЕГ-ын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, ЗЦА-ны дарга, Цагдаагийн газрын дарга нараас өгсөн үүрэг чиглэлийн мөрөөр Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны “Байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг шуурхай болгохтой холбогдсон зарим арга хэмжээний тухай” 08 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд: 2016 оны байдлаар иргэд байгууллагаас 1364 албан бичиг, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн ба дээд шатны байгууллагаас ирүүлсэн албан бичгийг газрын нэгдсэн бүртгэлд оруулж, хариуцсан алба хаагчид цохолт хийж, биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна. Энэ асуудлаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй болно.

Сүүлийн 3 жилийн зам тээврийн осол хэргийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж үнэлэлт дүгнэлт хийж ЦГ-н зөвлөлийн хуралаар оруулж таницуулав. 2016 оны 11 дүгээр сараас эхлэн Цагдаагийн газрын даргын тушаалаар криминологи судалгааны багт орон ажиллаж 7 хоног бүрийн нөхцөл байдлын судалгааг гарган дүн шилжилгээ хийн ажиллаж байна.

Монгол улсын ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Өмнөговь аймагт ажиллах үеийн хэв журмын хамгаалалт зохицуулалтыг 2016 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хүртэл зохион явуулсан ба ямар нэгэн зөрчил дутагдал гаргалгүй ажиллаа. Хамгаалалтанд нийт 67 алба хаагч, 16 автомашинтайгаар оролцсон ба Цагдаагийн газраас 14 алба хаагч, 2 автомашин, Цогтцэций сумын Цагдаагийн хэлтсээс 27 алба хаагч, 12 автомашин, ханбогд сумын Цагдаагийн тасгаас 9 алба хаагч 3 автомашин, Гал унтраах, аврах ангиас 5 алба хаагч, Харуул хамгаалалтын албадаас нийт 12 алба хаагчийг татан оролцуулж ажиллаа

<u>Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хэрэг шалгах, илрүүлэх талаар:</u>

Аймгийн засаг даргын зөвлөлийн хүрлаар Замын цагдаагийн тасгийн 2015 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээг хэлэлцүүлж “Аюулгүй Өмнөговь” зам тээврийн осол зөрчилөөс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлсэн.

Мөн нэгдсэн шалгалтын хуваарийн дагуу Тус тасгийн алба хаагчид авто тээврийн төвийн улсын байцаагч нартай хамтран Улаанбаатар хотоос орж ирэх зам дээр нэгдсэн үзлэг шалгалтыг 4 удаа зохион байгуулж ажиллаа. Мөн Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсгийн алба хаагчидыг хоёр хэсэг болгон Цогт-Овоо, Цагаан хадны чиглэлд постонд ажиллуулж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллаа.

“Согтуу-1”, “Сар шинэ-2016”, “Хяналт шалгалт-1”, “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх үзлэг”, “Хяналт шалгалт-2”, “Март-8”, “Мотоцикль”, “Хөдөлгөөнт эргүүл”, “Оюутан тээвэр-1” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг аймаг орон нутгийн хэмжээнд бусад албад болон төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион явуулж үр дүнг тооцон ажиллаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор орон нутгийн телевизүүдтэй хамтран телевизийн захиалгат “Алтан говь телевиз”-ийн Хаашаа яарна вэ? Нэвтрүүлэгийг сард 2 удаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Замын Хөдөлгөөний Аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуулийн ойлголт, ач холбогдол зэргийг сурталчилах ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж ирлээ. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн боловсрол олгох, ухамсар, соёлыг төлөвшүүлэх талаар иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Southgovi tpolice” *facebook* хаягийг нээж 1 жилийн туршид 5899 хамтрагчтай болов.

Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан жил бүр уламжлал болгон зохион байгууллагддаг **“Замын хөдөлгөөний цагаан толгой-2016”** тэмцээнийг сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд соёлтой оролцох дадлыг багаас нь эзэмшүүлэх, зорилготойгоор Замын цагдаагийн газраас ирүүлсэн удирдамжийн дагуу салбар төлөвлөгөө гаргаж аймгийн ГХУСАЗЗ-н даргаар батлуулан Даланзадгад, Цогтцэций суманд зохион байгуулалаа. “Замын хөдөлгөөний цагаан толгой-2016” тэмцээнийг Аймгийн ГХУСАЗЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Насан туршийн боловсролын төв, Албан журмын даатгагчдын холбоо, Улаан загалмайн хороо, Даланзадгад сумын ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, автосургуулиудтай хамтран 2016 оны 04-р сарын 29-ны өдөр Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй 2-р цэцэрлэг, 8-р цэцэрлэг, 9-р цэцэрлэг, 11-р цэцэрлэг, 23-р цэцэрлэг, Цогтцэций сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 6-р цэцэрлэг, 7-р цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж идэвхитэй оролцож, хамтран ажилласан. Замын цагдаагийн тасгаас тэмцээнд оролцох багуудад зөвөлгөө тусламж үзүүлэн цэцэрлэгийн эрхлэгч нарт болон багш ажиллагсад, эцэг эх хүүхдүүдэд бага насны хүүхдийг аюулгүй тээвэрлэх, аюулгүйн суудлыг хэрэглэж хэвших ач холбогдол сэдвээр 5 удаагын сургалтыг зохион байгуулан ажиллаа. “Замын хөдөлгөөний цагаан толгой-2016” тэмцээнийг зохион байгуулж Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй 5 цэцэрлэг, Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж буй 2 цэцэрлэгийн ахлах бүлгийн сурагчдаас бүрдсэн 10 сурагч, 1 багшийн бүрэлдэхүүнтэй 7 баг оролцсоноос Даланзадгад сумын “2-р цэцэрлэг” 1-р байр, “11-р цэцэрлэг” 2-р байр, ”9-р цэцэрлэг” 3-р байрыг тус тус эзэлсэн. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гар зургын уралдааны зарлаж шалгарсан бүтээлүүдээр зурагт аннос бэлтгэн хэвлэсэн. Мөн сургуулийн бага ангийн хүүхдүүдийн цүнхэнд цацруулагч хийх ажлыг албан журомын даатгагчдын холбоотой хамтран зохион явууллаа.

Тус цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн албаа хаагчид хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Насан туршын боловсролын төв, Ерөнхий боловмролын сургуулиудтай хамтран “Хотын соёл” арга хэмжээг зохион явуулан бага агнийн сурагчдыг автомашин дотор Хамгаалах бүс хэрэглэх, Хамгаалалтын суудалд суух, Явган хүний гарцаар гарах, Гэрлэн дохиогоор зам хөндлөн гарах зэрэг өртөөчилсөн сургалтуудыг зохион явуулан сурагчидад номны хавчуурага тараан ажиллаа



Өмнөговь аймгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг аймгийн Засаг даргаар ахлуулан, салбар зөвлөлийг ажиллах журам, дэд хөтөлбөр зэргийг гаргаж салбар зөвлөлийн даргаар батлуулан ажиллаж байна. Мөн Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 35 дугаар тогтоолоор Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Аюулгүй Өмнөговь” дэд хөтөлбөрийг батлуулан ажиллаж байна.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/62 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор батлагдсан “Тусгай дуут болон гэрэл дохио” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу салбар төлөвлөгөө гарган орон нутагт 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Арга хэмжээний

хүрээнд Цагдаагийн газрын нийт алба хаагчдад Хууль зүй дотоод хэргийн сайдын А/62 дугаартай тушаалаар шинэчлэн батлагдсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-ыг танилцуулан эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг үүрэгжүүлж ажилласан бөгөөд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэдэг Онцгой байдлын газар, Хүн, мал эмнэлэг, Тагнуул, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний газрууд болон бусад аж ахуйн нэгжүүдийн автомашинуудад үзлэг шалгалтыг явуулж холбогдох албан тушаалтнуудад шинэчлэн батлагдсан журмыг танилцуулав.

Тагнуул, Прокурор, Иргэний харъяалал шилжилт хөдөлгөөний газрууд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тээврийн хэрэгслүүдэд хяналт шалгалтаар зөрчил илрээгүй бөгөөд Онцгой байдлын газрын автомашинуудад үзлэг шалгалт явуулахад дөрвөн автомашин тусгай дуут болон гэрэл дохио ашиглаж байгаагаас 80-32 өмө улсын дугаартай Tata Daewoo, 80-27 өмө улсын дугаартай Dongweng, 02-05 өмү улсын дугаартай Gazole маркийн тээврийн хэрэгслүүд цэнхэр өнгийн гэрэл дохио тавьж үйл ажиллагаандаа хэрэглэж байсан зөрчил илэрсэн. Аймгийн хүн, мал эмнэлгийн тээврийн хэрэгслүүдэд үзлэг шалгалтыг явуулахад зургаан автомашин тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэж байгаагаас 47-74 өма улсын дугаартай Volkswagen LT35250 маркийн автомашин цэнхэр өнгийн гэрэл дохио тавьж хэрэглэсэн зөрчил илэрсэн бөгөөд бусад автомашинууд болон мал эмнэлгийн автомашин зөвшөөрөгдсөн ногоон өнгийн гэрэл дохио тавьсан байв. Онцгой байдлын газар болон нэгдсэн эмнэлэгт заагдсан зөрчлийг арилгаж журамд зааснаар зөвшөөрөгдсөн улаан, хөх өнгийн гэрэл дохио тавьж албандаа ашиглах тухай албан бичиг хүргэж зөрчлийг арилгууллаа. Мөн цагдаагийн газрын албанд ашиглагдаж байгаа тусгай дуут болон гэрэл дохио тавьсан тээврийн хэрэгслүүдэд үзлэг шалгалтыг явуулахад зөрчил илрээгүй болно.

Хотын соёл арга хэмжээний хүрээнд Замын цагдаагийн тасаг, Насан туршийн боловсролын төв, Говийн наран телевизтэй хамтран "Хөдөлгөөний соёл" арга хэмжээг зохион явуулж замын хөдөлгөөнд соёлтой оролцож байгаа жолооч болон явган зорчигчийг шалгаруулан ивээн тэтгэгч байгууллагуудын гарын бэлэг гардуулан ажиллаа.

Замын цагдаагийн тасгаас бага насны хүүхдүүдийн дунд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд соёлтой оролцох дадлыг багаас нь эзэмшүүлэх, зорилготойгоор ерөнхий боловсорлын хоёрдугаар сургуулийн 2-5 ангийн нийт 130 сурагчдын дунд **“Ногоон гэрэл цагаан шугам-2016”** тэмцээнийг зохион явууллаа.

2016 оны 4 дүгээр улиралд замын цагдаагийн тасгаас Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 8 төрлийн зурагт хуудас, боршуурыг хэвлүүлэн ард иргэдэд тараах ажлыг зохион байгуулан ажилласан. Ман хоёр төлрийн аннос хийлгэж ажилласан.





“Гашуун Сухайт Авто Зам” ХХК-иас хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны талаар зөвлөгөөнийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг “Монпорт” ХХК-ийн кампэд 2016 оны 11 дугаар сар 01-ний өдөр 09.30-14.00 цагийн хооронд зохион байгуулж, уулзалтад аймгийн мэргэжлийн хяналт, гааль, Эрдэнэс таван толгой ХК Энержи ХХК, зэрэг бусад улс хоорондын ачаа тээврийн 42 ААН, байгууллагын 65 ажилтан төлөөлөл оролцлоо. Цагдаагийн байгууллагыг төлөөлж аймгийн ЦГ-ын ЗЦТ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ц.Мягмаржав, Цогтцэций сум дахь сум дундын ЦХ-ийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Баярбат нараар ахлуулсан Цогтцэций, Ханбогд сумын нийт 6 алба алба хаагчид хамрагдаж, цагдаагийн байгууллагаас хийх ажил, хэрэгжүүлэх бодлого шийдвэр, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, хуулинд заасан ААН байгууллагын хэрэгжүүлэн хийх ажлын талаар танилцууллаа. Зөвлөгөөний үеэр “Гашуун Сухайт Авто Зам” ХХК-иас хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, 2015, 2016 оны замын шалган нэвтрүүлэх постны ачаалал, мөн зам засварын ажлын тайлан, гүйцэтгэл, өвлийн ажлын бэлтгэл, шалган нэвтрүүлэх постны шинэ программ түүний ач холбогдол, зам тээврийн ослын шалтгааны талаар мэдээлэл хийсэн.

Мөн малын цэцэг өвчин гарсантай холбогдуулан Цогт-Овоо сумаас зүүн тийш 30 километрт, Манлай сумаас зүүн тийш 10 километрт аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран байнгын постонд 24 цагаар 4 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчидад Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, замын хөдөлгөөнд соёлтой оролцож хэвших ач холбогдлыг өсвөр үе, иргэдэд сурталчилах ажлыг эрчимжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Ногоон гэрэл цагаан шугам-2016” тэмцээнийг Аймгийн ГХУСАЗЗөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын төв, автосургуулиудтай хамтран 2016 оны 11-р сарын 18-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд 4 сургуулийн 5 баг 65 сурагч 5 багш оролцсон бөгөөд 1-р байранд 4-р сургуулийн “Шонхор” баг, 2-р байранд 1-р сургуулийн “Traffic policeman” баг, 3-р байранд Эрдмийн гэгээ сургуулийн “Хүчирхэг-13” багууд тус тус байр эзэллээ.



Аймгийн засаг даргын 2016 оны мөрийн хөтөлбөрт орон нутгийн авто замуудад хяналтын пост бий болгох /хяналтын камер, пүү, мэдээлэх самбар, хурд хэмжигч/ зэрэг асуудал тусгуулан

ажилласан байна. Мөн аймгийн хөгжлийн бодлогын хэлтэст албан тоот хүргүүлэн даланзадгад сум доторхи хатуу хучилттай автозам дээр 2016 онд шинээр 96 ширхэг хэвтэй тэмдэглэл болон босоо тэмдэг хийлгэх асуудлыг шийдвэрлүүлэн ажилласан. Аймгийн 2016 оны мөрийн хөтөлбөрт багтсан ажлын нэг болох Даланзадгад сумаас Баяндалай сум орох 78 километрт замын дутуу 20 километр замын ажлыг Дарданговь ХХК гүйцэтгэжгүйлэн 126 ширхэг тэмдэг байршуулсан ажилласан. Мөн Даланзадгад сумын захирагчын албанд албан бичиг хүргүүлэн явган хүний гарцын 96 ширхэг хэвтэй тэмдэглэл, босоо 96 ширхэг тэмдэг хийлгэх асуудлыг шийдвэрлүүлсэн ба Даланзадгад суманд шаардлагатай байгаа 48 ширхэг тэмдэгийг шинээр хийлгэж суулгасан. Өмнөговь аймгийн Даланзадгад сум нь нийт 48 километр хатуу хучилттай засмал замтай ба Даланзадгад сумын хотын захирагчийн алба арчилалт үйлчилгээг хариуцан ажилдаг. Даланзадгад сумаас Дундговь аймаг орох 192 километрт хатуу хучилттай автозамын арчилалт үйлчилгээг Даш зам ХХК хариуцан ажиллаж байна. Даланзадгад сумаас Баяндалай сум орох 78 километрт автозам шинээр тавигдсан ба арчилалт үйлчилгээг Дарданговь ХХК хариуцан ажиллаж байна. Мөн Цогтцэций сумаас Даланзадгад сум орох 56 километрт засмал замыг шинээр тавих асуудлыг Монгол улсын Засгын газраас шийдврэлүүлэн ажиллаж байна. Өмнөговь аймгийн Даланзадгад сум нь нийт 48 километр хатуу хучилттай засмал замтай ба Даланзадгад сумын хотын захирагчийн алба арчилалт үйлчилгээг хариуцан ажилдаг. Даланзадгад сумаас Дундговь аймаг орох 192 километрт хатуу хучилттай автозамын арчилалт үйлчилгээг Даш зам ХХК хариуцан ажиллаж байна. Даланзадгад сумаас Баяндалай сум орох 78 километрт автозам шинээр тавигдсан ба арчилалт үйлчилгээг Дарданговь ХХК хариуцан ажиллаж байна. Гашуун сухайт автозам тендерийг холбогдох хууль тогтоомж дүрэм журмын дагуу явуулж тендерийн үнэлгээний хороонд ажиллан гүйцэтгэгч компанийг шалгаруулж гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ хийх төслийг боловсруулан засвар арчлалтын гэрээг байгуулан засвар арчлалтын ажлыг эхлүүлсэн. Тендерийг 4 багцад хуваан зарлаж 6 байгууллага үнийн санал ирүүлснээс Багц 1, 2-т Түвшин гэгээ ХХК, Багц 3, 4-т Хүслэнт бүтээмж ХХК шалгарч засварын ажлыг эхлүүлсэн бөгөөд ажлын тоо хэмжээг газар дээр хэмжилт хийж хүлээлгэж өгч, ажил эхлүүлэхээс өмнө ХАБ-н багтай хамтарч ажлын байрны үзлэг хийж, ажилбар тус бүр эрсдлийн үнэлгээ хийж удирдлагуудаараа баталгаажуулан засварын ажлын явцад өдөр тутмын технологийн хяналтаа тавьж ажилласан.

Тус Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас Даланзадгад сумын Хотын захирагчын албанд албан мэдэгдэл хүргүүлж аймгийн төвд 2 ширхэг гэрлэн дохиог шинээр хийлгэж ажилласан. Мөн сургууль цэцэрлэгийн орчимд 16 ширхэг хурд сааруулагч, 96 ширхэг босоо тэмдэг, 2 ширхэг цацруулагчтай замын хашилт байрлуулах ажлыг стандартын дагуу Гэрэлт уулзвар ХХК-иар гүйцэтгүүлэн хүлээн авч ажилласан

Аймгийн хэмжээнд “Мотоцикль”-н хөдөлгөөн хорих тухай засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн аймгийн Говийн наран, Best телевизүүдэд захирамжийн талаар 5-10 минутын яриа өгч ард иргэдэд анхааруулж Цагдаагийн газрын facebook хуудсанд байрлуулан ажилласан ба бүх сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт захирамжийг хүргүүлэн үүрэг чиглэл өгч хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын 95 жил, Замын цагдаагийн албаны 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Замын цагдаагийн газраас зохион явуулсан Говийн бүсийн “Уран зохицуулагч-2016” тэмцээнд амжилттай оролцож 2 дугаар байранд орсон амжилт гаргасан байна.

Мөн аймгийн Прокурорын газартай хамтран сар бүрийн эхний 7 хоногт уулзалт, зөвлөгөөнийг зохион явуулж цаашид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд анхаарах асуудал алдаа дутагдлыг харилцан солилцож ажиллаж байгаа ба хохироос өөр төрлийн ял шийтгэгдсэн иргэдэд тавих хяналт сэвдээр аймгийн прокурорын газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, даланзадгад сумын хотын захирагчын албатай хамтарсан зөвлөгөөнийг хийж ажилласан.

Замын цагдаагийн тасгаас жижүүрийн шуурхай албанд үүрэг гүйцэтгэж байгаа жолооч нар болон Замын цагдаагийн цагдаа зохицуулагч нараас Замын хөдөлгөөний дүрмийн түвшин тогтоох шалгалтыг авч дүнг нэгтгэн ажиллаа. Ингэснээр алба хаагч нарын замын хөдөлгөөний мэдлэг дээшилж ард иргэдийн амар амгалангын төлөө ажиллах нөхцөл бүрдэж байна.



Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнээс Замын хөдөлгөөний дүрмийн түвшин тогтоох шалгалтыг авч дүнг нэгтгэн ажиллаа. Мөн жолооч бэлтгэх автосургуулиудтай хамтран Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтанд хамруулах ажил зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

2016 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр Цагдаагийн газрын автомашин мотоцикльд албаны тээврийн хэрэгслүүдийг эзэмшиж байгаа алба хаагчдыг байлцуулан, цагдаагийн газрын даргын зөвлөлийн гишүүд үзлэг, тооллого явуулж, өвлийн улиралд үүрэг гүйцэтгэх албаны бэлэн байдлыг хангуулан ажиллаа. Ингэснээр үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдал хангагдаж, иргэдийнхээ аюулгүй амар амгалан байдлыг хангах, үүрэг гүйцэтгэхэд бэлэн боллоо.

ДӨРӨВ. ШҮҮХ, ПРОКУРОРЫН МЭДЭГДЭЛ, ЭНГИЙН МАГАДЛАЛЫН ДАГУУ АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Тайлант хугацаанд прокурорын байгууллагаас нийт 4 удаагийн шаардлага ирүүлсэн ба хэрэг бүртгэх ажиллагаанд хамаарах 2, захиргааны зөрчлийн хянан шалгах ажиллагаанд хамаарах 2 байсан ба албаны шалгалт явуулж 1 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, 8 алба хаагчийн албан тушаалын цалинг бууруулан олгосон байна.

Цаашид дээрх зөрчил дутагдлыг гаргуулахгүй байх талаар алба хаагчдад сургалт явуулж үр дүнг тооцох, шат шатны даргын хяналтыг сайжруулах талаар албадын дарга нарт үүрэг болгов. Хэрэв хариуцсан алба хаагчдаас дахин зөрчил гаргаж прокурорын шаардлаганд зөрчил заагдаж орвол давхар хариуцлага тооцох талаар анхааруулж газрын дарга, дэд даргаас байнгын хяналт тавьж ажиллаж байна.

ТАВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ИРГЭД БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ӨРГӨДӨЛ, МЭДЭЭЛЭЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ЗОХИОСОН АЖИЛ:

Эхний хагас жилийн урьдчилсан байдлаар цагдаагийн газарт иргэд байгууллагаас нийт 3196 өргөдөл гомдол үүнээс гэмт хэргийн шинжтэй 1034, захиргааны зөрчлийн шинжтэй 2162 нь өргөдөл мэдээлэл ирсэний бүгдийн нь бүртгэлд авсан байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллээс 420-д нь эрүүгийн хэрэг үүсгэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж, 612 материалд нь Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах сангалтай прокурорт хүргүүлж 100 хувь

хуулийн хугацаанд нь шалгаж шийдвэрлэсэн байна. Иргэдээс ирүүлсэн мэдээлэл нэг бүрийг хүлээн авч шийдвэрлэлтэнд газрын удирдлага байнгын хяналт тавин ажиллаж байна. Сар бүр гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн талаар сонсголыг байгууллагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж тасаг алба хаагчдад чиглэл өгч байгаа ба өдөр тутмын рапортон дээр мэдээлэл судалгааны байцаагч өргөдөл гомдлын үлдэгдлийг танилцуулж шийдвэрлэлтийг хийлгэж хэвшсэн.

2016 онд гэмт хэргийн улмаас иргэд аж ахуйн нэгж байгууллагад 3.713.006.000 төгрөгний хохирол учирснаас хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд 1.894.000.000 төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж 2.103.000.000 төгрөгний хөрөнгө битүүмжилж ажилласан нь хохирол нөхөн төлүүлэлт 51 хувьтай байна.

Тус цагдаагийн газар 2016 онд Цагдаагийн байгууллагын нэгдсэн санд баяжилт хийх ажилд удирдлдагаас тогтмол хяналт тавьж ажиллаж ирсэн бөгөөд захиргааны зөрчил, гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх зааврааар нийт алба хаагч нарт 8 удаа сургалт зохион байгуулан ажилласан. Хэсгийн төлөөлөлч нарын цугларалтаар мэдээллийн санд баяжилт хийхэд гарч байгаа алдаа дутагдал түүнийг засах аргаар сургалт зохион байгуулан ажиллаж байгаагийн дээр алба хаагч бүрийн мэдээллийн санд баяжилт хийж байгаа байдлыг дүгнэн сар бүрийн ажлын үзүүлэлтэнд оруулан урамшуулах болон арга хэмжээ тооцож ажилласан. Мөн аймгийн төвөөс алслагдсан Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын цагдаагийн хэлтэс, тасгуудын дарга нарт зааврууд бүрэн хэрэгжүүлж ажиллах чиглэлээр цагдаагийн газрын дарга зөвлөмж боловсруулан хүргүүлж биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

ЗУРГАА. САНХҮҮ НИЙГМИЙН АСУУДЛЫН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН:

2016 онд 1.898.717.100 төгрөгийн төсвийн санхүүжилт авч, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт 56.179.480 төгрөгийн орлого оруулж ажилласан.

Цагдаагийн газрын Санхүү хангамжийн газраас нийт 78.000 төгрөгийн 709 ширхэг шийтгэвэрийг авч алба хаагч нарт тараан олгож тухай бүр тооцоог хийлгэн одоогийн байдлаар алба хаагч нарын гар дээр 2.920.000 төгрөгийн торгуулийн тасалбар, 140 ширхэг шийтгвэрийн үлдэгдэлтэй байгаа ба няравын гар дээр 3.500.000 мянган төгрөгийн торгуулийн тасалбар, 17 ширхэг шийтгэвэрийн үлдэгдэлтэй байгаа болно. Нийт 45.843.400 төгрөгийн торгууль, шийдтгэвэрийн тооцоо хийгдсэн байна. дээрхи санхүүтэй холбоотой тайлан мэдээ сар бүр ЦЕГ-ын САГазарт гаргаж хүргүүлсэн

Алба хаагчдад нэг бүр нь 23.875 төгрөгний гар чийдэн 20 ширхэг, нэг бүр нь 283.7 мянган төгрөгний хамгаалатын өмсгөл 5 ширхэг, нэг бүр нь 426.355 төгрөгний автомашин албадан зогсоох төхөөрөмж 2 ширхэг, албаны автомашинд гэрлэн дууд дохио 3 ширхэг нэг бүр нь 649.377 төгрөгний үнэтэй тоног төхөөрөмж, тусгай хэрэгслэлийг байгууллагын орлогт авч алба хаагчдад хуваарьласан.

Мөн батлагдсан төсөвт багтаан 5.513.120 төгрөгөөр бичиг хэргийн хэрэгсэл, 5.480.350 төгрөгөөр авто сэлбэг хэрэгсэл худалдаж авсан байна.

Цагдаагийн газрын төв байранд 89.500.000 төгрөгөөр бүрэн засвар үүнд барилгын дээврийг бүрэн сольж засуулсан, гаднга пассадны шавар өнгөлгөө хийлгэн будуулсан, 1-3 давхарын коридор шат, үүдний иргэдийн хүлээлгийн танхимд шинэчилж бүрэн засвар, 6 өрөө тасалгааг бүрэн засч барилгын цахилгааны засвар гэрэлтүүлэг монтаж зэргийг бүрэн солиулж урсгал засвар хийлгэсэн.

Албаны авто машинуудад хувийн хэргийг нэгдсэн журмаар шинэчилж баяжилтыг цаг тухай бүрт хийжсэн

Сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулсан. Олон улсын ахмадын баярын өдрөөр 23 ахмад ажилтныг цагдаагийн газар дээр хүлээн авч урлагын тоглолт үзүүлж хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулсан Мөн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх, алба хаагч нарт гачигдал гарсан зэрэгт 250.000 төгрөг зарцуулсан

ДОЛОО. ДЭВШҮҮЛЭН ГАРГАХ САНАЛ, ХҮСЭЛТ

-ЦЕГ-ын батлагдсан бүтэц орон тооны дагуу нөхөн хангалтыг хийх болон шаардлагатай байгаа орон тоог нэмэгдүүлэх

-Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил хариуцсан бүтэц бий болгох, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хяналт шалгалт дотоод аюулгүй байдал болон урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил хариуцсан тасаг бий болгох саналтай байна

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил хариуцсан тасаг нь орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн хэмжээнд дотоод хяналт аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг Цагдаагийн байгууллагаас тухайн онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, аймаг орон нутгийн онцлогтой уялдуулан зохион байгуулах бөгөөд иргэдэд хууль сурталчлах, соён гэгээрүүлэх ажил явуулахтай хамт цагдаагийн бие бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулах ажлыг хамтатган хэрэгжүүлэхэд ахиц гарна гэз үзэж байна.

-Гадаад улстай хил залгаа оршдог аймгийн цагдаагийн газар, хэлтэст Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө санхүүг төсөвт нь суутгах

-Албаны сургалтын чанар, үр дүнд ахиц гаргах талаар зохион байгууллатын арга хэмжээ авах ажлын хүрээнд сургагч-багш нарыг төрөл мэргэжлийн албад бүрээс бэлтгэн, тэдэнд сарын цалингийн тодорхой хувиар нэмэгдэл олгодог тогтолцоог бий болгох, мөн нэгж бүрт сургалтын асуудал хариуцсан тодорхой албан тушаалтантай болох саналтай байна.

-Орон нутгийн онцлогоос хамаарч тээвэр шатахууны зардал, завсрын хөрөнгийг төсөвт нэмж суутгах

-Аймаг, сум, хот дүүргийн Цагдаагийн газар хэлтсүүд болон түүний бие даасан хэлтэс, тасаг, хэсгүүдийн дунд видео, цахим хурлын тоног төхөөрөмж суурьлуулах зэрэг саналыг дэвшүүлж байна.

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР